



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, БААСН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-86
<hr/>	
<i>1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/</i>	8
<i>2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт</i>	8-14
<i>3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	14-61
<i>4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсууриаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсох</i>	61-78
<i>5.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	78-86

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
03 дугаар сарын 22-ны өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа, П.Анужин, Т.Аубакир, Х.Баделхан, Б.Бейсен, Г.Дамдинням, Л.Мөнхбаатар, Н.Наранбаатар, Ж.Сүхбаатар, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Ш.Раднаасэд, Б.Саранчимэг;

Тасалсан: Б.Баттөмөр, С.Бямбацогт, Б.Жавхлан;

Хоцорсон: С.Амарсайхан-55 минут, С.Батболд-3 цаг 43 минут, Э.Батиугар-3 цаг 05 минут, Б.Баярсайхан-25 минут, Д.Ганбат-02 минут, Г.Ганболд-09 минут, Н.Ганибал-35 минут, Ц.Мөнх-Оргил-05 минут, М.Оюунчимэг-57 минут, Д.Өнөрболор-10 минут, Ц.Туваан-1 цаг 39 минут, Н.Учрал-1 цаг 50 минут, Ч.Хүрэлбаатар-36 минут, Б.Энх-Амгалан-21 минут.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингээс ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин үг хэлэв.

**Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 4 өдрийн завсарлага өгөв./10:22/

Уг асуудлыг 10 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Баясгалан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Баясгалан, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар тус тус танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

*Байнгын хороодоос гаргасан саналаар санал хураалт явуулав.*

**С.Одонтуяа:** 1.Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтад “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	17
Бүгд:	41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтад “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	14
Бүгд:	42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.	

Байнгын хороодын саналаар санал хурааж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа “Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

**С.Одонтуяа:** “Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 13  
Бүгд: 42  
69.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа “Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. *Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.*

Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /10:42/

*Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа Наурызын баярын мэндийг хүргэж, мэндчилгээ дэвшүүлэв.*

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир, Т.Доржханд, Б.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, О.Цогтгэрэл, С.Чинзориг, Б.Энх-Амгалан, Д.Тогтохсүрэн, Н.Энхболд, С.Одонтуяа нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 өдрийн завсарлага өгөв./13:26/

*Уг асуудлыг 13 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 11 минут үргэлжилж, 13 цаг 28 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 07 минутад эхлэв.*

*Дөрөв. Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсууриас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж “Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар” тавьсан асуулгын хариуг сонсох*

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ, тарифын газрын дарга Б.Эрдэнэбулган нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Б.Хангай нар байлцав.

Асуулгын хариуг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Батсуурь, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий нар хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсууриас “Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг хэлэлцлээ.

*Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

*Тав. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Д.Тогтохсүрэн нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн

дарга О.Цогтгэрэл завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 өдрийн завсарлага өгөв./15:35/

*Уг асуудлыг 15 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 4 цаг 39 минут үргэлжилж, 72 гишүүнээс 53 гишүүн хүрэлцэн ирж, 73.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 35 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ**  
2024 оны 03 дугаар сарын 22-ны  
өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
10 цаг 17 минут  
**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ**  
**ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Одонтуяа:** Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, Засгийн газар 24 оны 3 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх үргэлжилнэ.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Дөрөв.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсууриас Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ-д хандаж эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар тавьсан асуулгын хариуг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал

өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17-н цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинээс ирүүлсэн албан бичгийг уншиж танилцуулна. Амартүвшин гишүүний микрофоныг нээе.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлъя. Өнөөдөр чуулганаар нэг чухал асуудлыг хэлэлцэж байгаа. Энэ нь болохоор Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслөөр гишүүд санал хураана. Энэ асуудал, энэ гурилын үнийн асуудал бол төрийн хяналт зохицуулалтын алдааны нэг гай гэж харж байгаа л даа. Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар муу ажилласны жишээ.

Би бас нэг жишээ дурдъя. Хан-Уул дүүргийн Яармаг орчны орон сууцны хорооллуудын цэвэр усны чанарын асуудал, крантнаас урсаж байгаа ус нь бохир зэвтэй ус байдаг. Стандарт нормоо зөрчиж шуналтай хэдэн барилгын компаниуд, хүлээж авсан улсын комиссын алдаагаас болоод энэ гай нүүрлэж байгаа шүү. Одоо төсвөөс 6 тэрбум төгрөгөөр 4.5 км цэвэр усны шугамыг солихоор болж байна. Энэ жил энэ 7 сар гэхэд.

Гэтэл Барилгын тухай хуулийн 13.1-д маш тодорхой заасан байгаа. Барилга, байгууламжид ашиглах барилгын материал нь хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх ёстой гэсэн маш тодорхой заалттай. Гэтэл Яармагт амьдардаг 25200 иргэд эрүүл мэндээрээ ноцтой хохирч байгаа энэ жишээ шүү. Энэ стандарт мөрдөөгүй, нөлөөт өртөг, төрийн хяналтын байгууллагын алдаа. Үүнийг засах, үүнийг Засгийн газар цаашидаа анхаарах ёстой. Энэ барилгын компаниудыг хянадаг энэ улсын комисс, энэ Шударга өрсөлдөөн



гээд бусад энэ агентлагуудын ажлыг илүү чанаржуулах шаардлагатай байна.

Өнөөдөр 3 сарын 22-нд Дэлхийн усны өдөр тэмдэглэж байна. Тэгээд энэ өдрийг бас тохиолдолд нь би энэ Яармагийн орон сууцын иргэдийн цэвэр усны асуудлыг хөндөж ярьж байгаа юм шүү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Одонтуяа:** Үг хэллээ.

**Одоо Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явагдана. Тогтохсүрэн гишүүн горимын санал гаргая.

**Д.Тогтохсүрэн:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Засгийн газраас Гаалийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан. Тэгээд өчигдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн. Энэ нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд явахад, харахад гишүүдийн байр суурь өөр өөр байгаа юм. Янз янзын байр суурьтай байгаа юм.

Тийм учраас Монгол ардын намын бүлэг гишүүдийнхээ байр суурийг нэгтгэх үүднээс энэ Гаалийн албан татварын тухай хууль дээр ажлын 5 өдөр энэ завсарлага авах саналыг гаргаж байгаа юм. Шийдвэрлэж өгөхийг хүсье.

**С.Одонтуяа:** Монгол ардын намын бүлгийн даргын саналыг сонслоо. Ажлын 4 хоногийн завсарлага өгч байна. Дараагийн асуудалдаа орёё.

10.22 цаг.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.**

Үндсэн хуулийн ажлын хэсэг орж ирсэн үү? Ажлын хэсгийнхэн. Ажлын хэсгийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 22-ны өдрийн хуралдаанд оролцох ажлын хэсгийн гишүүн Гунгаагийн Баясгалан Үндсэн хуулийн цэцийн гишүүн ирсэн байна. Гунгаагийн Баясгаланг индэрт урья.

**Г.Баясгалан:** Монгол Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1 сарын 17-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг уншиж сонсгоё.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Эрдэнэбулган даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Туулхүү, Баясгалан, илтгэгч Гангабаатар, Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Долормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Номынбаясгалан оролцлоо. Харин Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хүрэлцэн ирээгүй бөгөөд хүндэтгэн үзэх ямар нэгэн шалтгаанд заасан саналаа ирүүлээгүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн

тухай хуулийн 29 дүгээр зүйлд нэмсэн 29.3.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв. Үндэслэл,

1. Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан хууль дээдлэх зарчмын гол агуулга нь нийт байгууллага иргэний аливаа үйл ажиллагаа Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байхын зэрэгцээ хуулийн хүрээнд явагдах агуулгыг илэрхийлнэ. Хууль дээдлэх зарчмын суурь болох Үндсэн хуулийг дээдлэх үзэл баримтлал нь дэлхий нийтийн түгээмэл, эрхэм дээд үзэл санаа болон хүлээн зөвшөөрөгдсөн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж заасан нь сонгогч иргэний төрийн үйл хэрэгт сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан оролцох эрхийг баталгаажуулж, сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн гарааны тэгш байдлыг хангах сонгуулийн хуулийг тогтвортой мөрдөхөд чиглэсэн байх бөгөөд ээлжит сонгуулийн өмнөх 1 жилийн хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөөгүй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 6 дугаар

сарын сүүлийн хагасын аль ажлын өдөр байна гэж, мөн хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх 1 жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт орохыг хориглоно гэж тус тус хуульчилсан байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай 2023 оны 116 дугаар тогтоол гарган ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 6 сарын 28-ны өдөр байхаар тогтоожээ.

Дээрхээс үзэхэд хууль тогтоогч 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр буюу сонгууль явагдахын өмнөх 1 жилийн дотор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийг баталсан нь Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэхийн холбогдох заалтыг зөрчиж, хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 сарын 7-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 жил хүртэл хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын

өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын .../үг тасрав./

**С.Одонтуяа:** Гишүүд их шуугилдаад сонсогдохгүй байна шүү дүгнэлт.

**Г.Баясгалан:** Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 1 сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч, Эрдэнэбулган гишүүд Туулхүү, Баясгалан, Гангабаатар, Энхтуяа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Одонтуяа:** Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1 дүгээр

дүгнэлтийг 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны журмын дагуу 24 оны 3 сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1 дүгээр дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэж 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 1 дүгээр дүгнэлтийн хэлэлцэх эсэх, хэлэлцсэн талаарх Хууль

зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

**С.Одонтуяа:** Одоо Цэцийн дүгнэлтийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд нэмсэн 29.3.3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2024 оны 01 дүгээр дүгнэлтийг 24 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу Төрийн байгуулалтын хороо 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Улсын Их Хурлын гишүүн Ганболд нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэсэн талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын Их Хурал 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэлх жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Одонтуяа:** Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байвал нэрээ өгье.

Чинзориг гишүүн дарах юм уу нэрээ? Хэрэггүй юм уу? Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Одоо Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ц.Даваасүрэн:** Үндсэн хуулийн цэцийн оруулж ирж байгаа дүгнэлтийн хувьд бол зөвшөөрч байна.

**С.Одонтуяа:** Гишүүдээ жоохон чимээгүй байгаарай. Энэ ер нь сонсогдохгүй байна шүү. Тэмүүлэн гишүүн ээ.

**Ц.Даваасүрэн:** Сонгуулийн өмнөхөн янз бүрийн өөрчлөлт оруулаад сонгуулийн дүрмээ, тоглолтоо өөрчлөөд байх энэ тэр зохисгүй зүйл л дээ. Тийм учраас энэ чиглэл дээр анхааралтай байх ёстой.

Би Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүн бас өөрчлөгдсөнд найдвар тавьж байгаа шүү. Та нар энэ төрийг яаж самарч мэдэх ийм аюултай эрх мэдэлтэй улсууд. Өнгөрсөн хугацаанд тэр харагдсан. Зарчмын байр суурьгүй, морь унасан толгойгүй тэгээд л дарга юу гээд хэлчихнэ тэрийг л дагаад л байж байдаг. Улс төрийн өндөр албан тушаалтнуудаас хувь заяагаа даатгаад айчихсан ийм арчаагүй байдалтай улсууд танай Цэцэд их байдаг. Тэр морь унасан толгойгүй хүмүүс бол ямар ч шийдвэр гаргаж мэднэ. Одоо гай нь энэ сонгуулиар гарч ирэх байх. 48 хүн гишүүн ард түмний шүүлтгүйгээр орж ирнэ. 48 гишүүн. Ард түмнээрээ шүүлгэсний буруу гэж ерөөсөө байхгүй шүү дээ. Намын жагсаалтын ард юу ч орж ирж мэдэхээр болгоод хаячхаж байгаа байхгүй юу. Тийм нүглийг зүгээр энэ одоогийн гэж хэлэх нь хэцүү юм Үндсэн хуулийн, өмнөх Үндсэн хуулийн хуучин бүрэлдэхүүн бол ийм балай юм хийсэн. Ард түмнээрээ шүүлгэхгүй гээд.

Улс төрчид төлөвшихсөн, нийгмийн хариуцлагаа ухамсарлачихсан ийм нийгэмд бол болно. Яагаад гэвэл тийм нийгэмд тэр шилдгүүдээ удирдагч нараа хамгаалах гэж тийм тогтолцоо байдаг. Манайх шиг ингээд төлөвшөөгүй, нийгмийн хариуцлагын ухамсарладаггүй, нийгмийн гишүүний үүргээ ойлгодоггүй, хувийнхаа эрх ашгийг бодсон ийм улс төрчид зонхилсон үед бол тэр намын жагсаалтын ард орж ирнэ гэдэг бол аюултай зүйл байхгүй юу. Тийм балай зүйлийг бол хийж төрийг самарсан.

Тэгэхдээ бид нар хор уршигийг нь энэ сонгуулийн дараа ойлгоно. Энэ сонгуулийн үр дүнгээр бий болох Засгийн газар бол хамтарсан Засгийн газар байна. Хэн нэг нь хариуцлага үүрээд явдаггүй Засгийн газар болно. Ванга шиг хэлчихье. Хэн нь ч хариуцлага хүлээдэггүй. Тэгээд ажил нь явдаггүй, бие биеийгээ чирч унагасан, Засгийн газар нь олон удаа огцорсон ийм төр 24 онд байгуулагдана. Хамтарсан. Европын орнууд тийм байгаад байгаа шүү дээ. Хэдийгээр тэнд улс төр нь төлөвшсөн ч гэлээ гэсэн хамтарсан засгийн газрууд.

Манайд бол ажил нь явж өгөхгүй. 12 онд тийм л байсан шүү дээ. 20 хэдэн хүн гараад ирсэн. Тэгээд л засгаа солиод л, янз бүр болоод л, нэг нь гоморхоод л нөгөө нам нь орж гараад л. Тэгээд ийм хамтарсан Засгийн газартай явах тийм шийдлийг энэ Үндсэн хуулийн цэц гэж юм хийгээд хаячихсан. Тэгээд одоо үүний дараагийн асуудал дээр Үндсэн хуулийн цэцийн асуудал орж ирэх юм байна.

Энэ Цэцийн хуулийг хэлэлцэхдээ бид нар нэлээн нарийн хэлэлцэж, энэ төрд, нийгэмд бий болгож байгаа энэ гай, хор уршигийг байхгүй болгох чиглэлд нь нэлээн хариуцлагажуулсан ийм заалтуудыг оруулж өгөхгүй бол болохгүй.

Ер нь тэр Цэцийн гишүүний тэр тавих шалгуур, тэтгэвэрт гарах асуудал, ёс зүйтэй холбогдолтой асуудал. Зарим нь хуулийн хариуцлага хүлээх улсууд өөрийгөө хамгаалаад суучихсан юм манай Цэцэд гарсан шүү дээ. Ял авчихаар, дандаа байнгын хэрэг төвөгт холбогдож байна. Одоо ч гэсэн холбогдоод явж байгаа ийм нөхдүүд хүртэл Цэцийн гишүүн болоод ингээд явж байсан.

Тийм учраас бид нар одоо энэ Цэцийн асуудал дээр нэлээн анхааралтай хандаж байхгүй бол болохгүй. Одоо шинэ бүрэлдэхүүн. Миний гол нь үг хэлэх гээд байгаа нь энэ шинэ бүрэлдэхүүн очсон. Та

нар минь хариуцлагатай байж үзээрэй, нэр хүндээ унагав. Ард түмний дунд бас явах нүүртэй байгаарай л.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хороодоор одоо санал хураалт. Санал хураалт.

1.Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтад сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт.

58.5 хувиар санал дэмжигдлээ.

Одоо 2 дахь санал. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтад сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь

зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэснээр санал хураая. Санал хураалт.

66.7 хувиар санал батлагдлаа. Санал хурааж дууслаа.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт.

69 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21 дүгээр зүйлийн 4 дүгээр хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

Батлагдлаа. Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.42 цаг.

Гурав дахь асуудалдаа оръё. Гурав дахь асуудлын өмнө нэг юм танилцуулъя.

Өнөөдөр дэлхийн усны өдрийг дэлхий даяараа тэмдэглэж байгаа юм байна. Тэгээд та бүхэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас ийм уриалга, энэ туузыг ширээн дээр тавьсан байгаа. Энэ туузыг гишүүд зүүгээд энэ усны нөөцөө үлдээхийн төлөө, усаа хамгаалахын төлөө, хуримтлуулахын төлөө хамтран зүтгэхийг уриалсан ийм уриалгыг тавьсан байна. Гишүүд энэ уриалгыг дэмжиж оролцъё.

**Гурав дахь асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил нарын 2 гишүүн 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн байна.**

Мөнх-Оргил гишүүнийг индэрт урьж байна

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Улсын Их Хуралд өргөн мэдүүлэг бүхий үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Баатарбилиг, Батсуурь, Бямбацогт, Сандаг-Очир, Энхбаяр нар ажиллаж, хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлээ.

Монгол Улс 1992 онд нийгэм, улс төрийн шинэ тогтолцоонд шилжиж түүхэндээ анх удаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нэртэй Үндсэн хуулийн шүүхтэй болсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр баталсан.

Хууль батлагдсанаас хойших хугацаанд зарим нэмэлт, өөрчлөлт орсныг эс тооцвол Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчим, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдсан дорвитой өөрчлөлт хийгдээгүй явж ирлээ.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг анх 23 зүйлтэй баталж байсан ч өнгөрсөн хугацаанд 12 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж өнөөдрийн байдлаар 13 зүйл нь л анх батлагдсан хэлбэрээрээ мөрдөгдөж байна.

Өнгөрсөн 32 жилийн хугацаанд Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд гарч буй өөрчлөлт, хөгжлийн хурдац, нийгмийн хэрэгцээг дагаж шүүх эрх мэдлийн бусад байгууллагын нэгэн адил Цэцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинэчлэн боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна гэж Хууль зүйн байнгын хорооны гишүүд үзэн тодорхой үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан юм.

Ажлын хэсэг 30 гаруй жилийн алдаа оноог дүгнэн цэгнэж, дэлхий дахинаа төлөвшин хөгжиж буй Үндсэн хуультай ёс, Үндсэн хуулийн шүүхийн өсөн нэмэгдэж буй үүрэг, хүний эрхийг тодорхой тохиолдолд хамгаалах хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өнгөрсөн 2 жил хагасын хугацаанд тасралтгүй ажиллаж хуулийн төслийг боловсрууллаа.

Ажлын хэсэг, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурор,

Улсын Их Хурлын Тамгын газар, эрдэмтэн судлаачдыг оролцуулан ажлын дэд хэсгийг байгуулан мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа, дэмжлэг авсан.

Ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тулгамдаж буй асуудлыг тодруулж, эрдэмтэн судлаач, хуульч нартай зөвлөлдөж, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор хэд хэдэн ажил зохион байгуулсан.

Тухайлбал, Үндсэн хуулийн хяналтыг боловсронгуй болгох нь сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндсэн хуулийн цэц, МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан бол Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам МУИС-ийн Үндсэн хууль эрх зүйн хүрээлэнтэй хамтран Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчлэл хэлэлцүүлгийг хуульчдын дунд зохион байгуулж, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд санал шүүмжлэл сонссон.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ардчилсан сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн шинжээчдээс мөн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын холбооны Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгч асан, профессор, доктор Майкл Эхбергээс саналыг нь авч, холбогдох саналыг Монгол Улсын онцлогт тохирох эсэхийг нь шалгуур болгон төсөлд тусгаж сайжрууллаа.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд оруулсан зарчмын өөрчлөлтийн талаар та бүхэнд товч танилцуулъя.

1.Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг тодорхой болголоо. Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих шүүх юм. Тийм учраас гишүүн нь шүүгчээр ажиллах наад захын шаардлага хангасан байх ёстой гэж үзлээ.

Үндсэн хуулийн маргаан бол хууль зүйн маргааны нэг төрөл бөгөөд түүнийг зөв шийдвэрлэхийн тулд хууль зүйн мэдлэг ур чадвараас гадна Үндсэн хуулийн онол, философийн мэдлэг тодорхой хэмжээнд хэрэгтэй учраас Цэцийн гишүүн эрх зүйч байх, хууль зүйн дээд боловсролтой байх нь зохистой гэж үзлээ.

Хууль зүйн өндөр мэргэшил гэдэг бол хуульч эсхүл эрх зүйч байгаад зогсохгүй тухайн мэргэжлээрээ тодорхой хугацаанд ажиллаж байгаа, ажиллаж туршлага хуримтлуулсан байх явдал юм. Түүнчлэн аливаа улс төрөөс ангид байлгах ёс зүйн шалгуур тавьж, Цэцийн гишүүнээр сүүлийн 4 жилийн хугацаанд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхлээгүй, санаатай гэмт хэрэг үйлдэж, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй гэсэн шаардлагыг нэмж тусгалаа. Энэ нь манай улсын ердийн шүүх, Шүүхийн сахилгын хорооны гишүүдэд тавигддаг шаардлагатай ижил юм.

2.Цэцийн гишүүнийг зөвхөн 1 удаа дахин томилж болохоор тусгалаа. Цэцийн гишүүний дахин томилгоог хязгаарлаагүй тохиолдолд Цэцийн гишүүн дахин нэр дэвших, томилогдохын тулд санал болгох, томилох эрх бүхий этгээдэд таалагдах сэдлээр ажиллах эрсдэл өндөр байдаг гэж үзэж байна. Энэ нь Цэц Үндсэн хуулийг хэрэглэж, маргаан хянан шийдвэрлэдэг болохынхоо хувьд гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс бүрэн хараат бус байх зарчим зөрчигдөх нөхцөлийг бий болгоно.

Хэдийгээр уг үндэслэлээр дахин томилох боломжийг хязгаарлах шаардлагатай гэж манай ажлын хэсгийн



гишүүд үзсэн боловч ийнхүү дахин томилохыг бүрэн шууд хязгаарлах нь Цэцийн гишүүний бүрэн эрхийг 6 жилээр байхаар Үндсэн хуульд заасан хүн ам цөөтэй манай улсад Цэц тогтвортой ажиллах, Цэцийн шийдвэрийн үндэслэгээг сайжруулахад бэрхшээл үүсгэж, чадварлаг мэргэжилтнийг хангалттай хугацаанд ажиллуулах боломжгүй болох эрсдэлтэй юм.

Ардчиллыг хуулиар дэмжих Венецийн Комиссын зүгээс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг 1 удаа урт хугацаагаар, эс үгүй бол насан турш нь, эс үгүй бол зөвхөн 1 удаа дахин томилох боломжтой байх ёстой гэж зөвлөдөг юм. Үүний дагуу Цэцийн гишүүний хараат бус тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төсөлд Цэцийн гишүүнээр зөвхөн 1 удаа дахин томилж болно гэсэн заалтыг тусгалаа.

3.Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох хугацааг тусгайлан зохицууллаа. Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох хугацааг бүрэн гүйцэд зохицуулаагүйтэй холбоотой Цэцийн гишүүнээр ажиллах хуульд заасан хугацаа дууссан атал эрх бүхий байгууллага, албан тушаалтан Цэцийн гишүүнд нэр дэвшүүлэхгүй удах энэ 1, 2 жил хүртэл үргэлжлэх гэх мэт эрх зүйн хийдлийг бий болгосон асуудал өнгөрсөн хугацаанд гарсан.

Иймд хуулийн төсөлд Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох хугацааг нарийвчилж зохицууллаа. Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө, эсвэл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон өдрөөс хойш 45-аас дээшгүй хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Цэцийн гишүүнд тавих болзол шаардлагыг хангасан иргэнийг нэр дэвшүүлж, саналаа Улсын Их Хуралд хүргүүлэхээр заалаа.

4.Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох журмыг тодорхой тогтоолоо. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох, томилох процессыг тусгайлан зохицуулаагүй нь улс төрийн зүй бус нөлөө, эрх бүхий этгээд дур зоргоор хандах нөхцөлийг бий болгосон сул талтай байна гэж судлаачид үздэг. Иймд хуулийн төсөлд Улсын дээд шүүх болон Ерөнхийлөгч цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх процессыг өөрсдийн журмаар нарийвчлан зохицуулахаар тусгалаа.

Улсын Их Хурлын хувьд олонх, цөөнхийн оролцоог хангасан хэлбэрээр тусгайлан зохицууллаа. Тодруулбал, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг парламентаас сонгож байгаа тохиолдолд нэг талын сонголт биш улс төрийн үзэл бодлын өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц байх баталгааг хангах ёстой юм. Ингэхдээ Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийг тэнцвэртэйгээр, хэрэв аль ч нам эвсэл олонх болоогүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийг авсан суудлын тоогоор нь хувь тэнцүүлэн бүрдүүлсэн 9 гишүүн бүхий ажлын хэсэг байгуулж, ажлын хэсэг дээр нэр дэвшигчийг нийт гишүүнийхээ гурваны хоёрын саналаар сонгох, нэр дэвшигчийн танилцуулгыг олон нийтэд нээлттэй зарлах зэргээр тусгасан нь Улсын Их Хурлын гишүүдийн олонх, цөөнхөд хүлээн зөвшөөрөгдсөн нэр дэвшигч сонгогдох нөхцөлийг бүрдүүлэх юм.

Түүнчлэн Улсын дээд шүүхээс санал болгож томилох нэр дэвшигч нь хяналтын шатын шүүгч байхаар тусгалаа. Энэ нь Цэцийн процессыг Үндсэн хуулийн шүүхийн жишигээр хөгжүүлэх, шийдвэрийн чанар, үндэслэлийг сайжруулахад чухал алхам болно гэж үзэж байна.

Хуулийн төсөлд Улсын Их Хурал, Улсын дээд шүүх болон Ерөнхийлөгч цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг хангах боломжтой хүмүүсийг судлах, ярилцлага хийх, ил тод

байх, олон нийтийн болон мэргэжлийн байгууллагын оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмыг тус бүрдээ баталж, цахим хуудастай байршуулахаар төсөлд тусгалаа.

5.Цэцийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулгыг олон нийтэд нээлттэй мэдээлэхээр зохицууллаа. Венецийн комиссоос нэр дэвшигчдийн жагсаалтыг санал оруулагч нар өөрсдийн цахим хуудсаараа нийтэлж, 10 хоногоос доошгүй хугацаанд олон нийтэд нээлттэй байлгах хэрэгтэй гэж зөвлөдөг. Иймд нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохоосоо өмнө танилцуулгыг нь 5-аас доошгүй ажлын өдрийн дотор цахим хуудсандаа байршуулж, олон нийтэд мэдээлэх, саналыг нь авахаар зохицууллаа.

Ийнхүү Цэцийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох хугацааг ойлгомжтой болгож, зүй бус нөлөөллөөс хамгаалах, олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

6.Цэцийн нийт гишүүний хуралдааныг байгуулж, холбогдох бүрэн эрхийг тодрууллаа. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд маргаан хянан шийдвэрлэхээс бусад асуудлыг Цэц хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт дутмаг учраас тодорхойгүй байдал үүсгэсээр байдаг. Түүнчлэн Цэцийн даргад хэт олон асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг төвлөрүүлж, тогтоол, тушаал гаргах зохицуулалт одоо үйлчилж байна. Өнгөрсөн хугацаанд гарсан зөрчил, хийдлийг засах зорилгоор Үндсэн хуулийн цэцийн нийт гишүүдийн хуралдаан ажиллахаар зааж энэ нь маргаан хянан шийдвэрлэхээс бусад асуудлыг шийдвэрлэхээр төсөлд тусгалаа.

7.Цэцийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтэц, хүний нөөцийг бүрдүүлэхээр зорьж байна. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд Цэцийн гишүүний туслах, судлаач, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг

бүхий бусад этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлоогүй байдаг юм.

Цэц үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхээр хуулийн төсөлд заасан бөгөөд ийнхүү Цэцэд хандах хүрээ нэмэгдэж байгаатай уялдуулан Цэцийн маргаан хянан шийдвэрлэх бүтэц, хүний нөөцийг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага үүслээ.

Иймд Улсын дээд шүүхийн шүүгчийн нэгэн адил Цэцийн гишүүн I туслах, I судлаачтай байхаар хуулийн төсөлд тусгалаа. Түүнчлэн Цэц судалгааны төв, номын сантай байхаар зохицуулсан Цэцийн шийдвэрийн чанар, үндэслэл, судалгааг сайжруулахад чиглэсэн шинэчлэл болно.

8.Цэцийн гишүүний хараат бус байдлыг хамгаалах. Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаагаар Цэцийн гишүүний бүрэн эрхийн баталгаа хэт ерөнхий байдлаар зохицуулсан нь Цэцийн гишүүний хараат бус байдалд халдах эрсдэлийг бий болгож байгааг тэмдэглэжээ. Бусад улсын жишгийг харахад Цэцийн гишүүдийн эдийн засгийн баталгаа, эрх зүйн байдлыг тусгайлан тодорхой зохицуулах замаар хараат бус байдлыг бэхжүүлдэг байна.

Иймд Цэцийн хараат бус байдлыг хангахын тулд олон улсын сайн жишгийг судлан, Цэцийн гишүүний баталгаа, эрх зүйн байдлыг нарийвчлан зохицууллаа. Ингэхдээ Цэцийн гишүүд нь Улсын дээд шүүхийн шүүгчидтэй нэгэн адил баталгаагаар хангагдахаар зохицуулж байна.

Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлөхийг оролдсон үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс үзүүлэх аливаа нөлөөллийг хориглох ийм үйлдэл, эс үйлдэхүйг баталгаажуулах, хариуцлага

тооцох, нөлөөллийн мэдүүлэг хөтлөх тогтолцоог тусгайлан зохицууллаа.

9.Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах үндэслэл, журмыг нарийвчлан тусгалаа. Цэцийн гишүүний халдашгүй байдлыг хуулиар тогтоох, Цэцийн гишүүнийг огцруулах, чөлөөлөх, тэтгэвэрт гарах зэрэг нөхцөлийг аливаа дур зоргоос хамгаалах механизмыг хуульчилсан байх. Иргэний эрхээ хязгаарлуулсан байдалтай нь дүйцэхүйц байдлаар амьдралын баталгааг бүрдүүлэх нь хараат бус байдлын баталгаа болно.

Цэцийн дарга, гишүүнд холбогдуулан үүсгэсэн гэмт хэргийг мөрдөн шалгах явцад уг гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагатай гэж үзвэл энэ тухай саналаа Улсын ерөнхий прокурор Цэцэд хүргүүлэх бөгөөд асуудлыг Цэцийн нийт гишүүний гуравны хоёрын саналаар шийдвэрлэж байхаар төсөлд тусгалаа.

10.Эрхээ сэргээлгэх хуульд заасан арга замыг дуусгасны дараа уул эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзсэн иргэд Цэцэд гаргах эрхийг тусгалаа. Иргэд өөрийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргах эрхтэй байгаа нь Цэц үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэх агуулгатай бөгөөд Үндсэн хуулийн анхны үзэл баримтлал нь үүнд чиглэсэн байна гэж ажлын хэсэг үзлээ.

Түүнчлэн Цэц зөвхөн хийсвэр хяналтыг хэрэгжүүлэх нөхцөл байдал бий болж улмаар Цэцийн шийдвэрийн үндэслэл, чанарт сөргөөр нөлөөлж байна. Иргэдийн үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхгүйгээс манай улсад эрх үндсэн эрх зөрчигдөж эдгээр зөрчил Үндсэн хуулийг хэрэглэж шийдвэрлэгдэж чаддаггүй. Ердийн шүүх зөвхөн Үндсэн хуулиас бусад хууль хэрэглэж маргааныг шийдвэрлэдэг манай улсын нөхцөлд үндсэн эрхийн зөрчлийг Үндсэн хуулийн түвшинд хамгаалах боломжгүй байдагтай холбоотой гэж

үзэн Үндсэн хуулийн цэц үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэхээр тусгалаа.

Цэцийг үндсэн эрхийн маргаан хянан шийдвэрлэхээр зохицуулж буйтай уялдуулан үндсэн эрх гэдэгт ямар эрхийг хамааруулах талаар эргэлзээ үүсэхээс сэргийлж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхүүдээс зөвхөн иргэний болон улс төрийн эрх сурч боловсрох эрхийг үндсэн эрхийн түвшинд хамгаалахаар тусгалаа.

Ингэхдээ иргэн хуульд заасан арга замыг дуусгасны дараа ч үндсэн эрх нь зөрчигдсөн хэвээр гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргаж, хянан шийдвэрлэх зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтийг тусгалаа. Нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд Үндсэн хуулийн цэц нь Улсын дээд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох бус, хэрэв Үндсэн хуулийн зөрчил гарсан байна гэж шийдвэрлэсэн тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын дээд шүүхэд шилжүүлэх бөгөөд Үндсэн хуульд заасны дагуу Улсын дээд шүүх өөрийнхөө шийдвэрийг эргэж харах бололцоог нээж байгаа юм.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Одонтуяа:** Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

**Э.Бат-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил нарын гишүүд 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024

оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Цэц түүний үйл ажиллагааны эрх зүйн үндэс болох Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг Монгол Улсын Бага хурлаас 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр баталсан. Хууль батлагдсанаас хойших хугацаанд зарим нэмэлт, өөрчлөлт орсныг эс тооцвол Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчим, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдсан дорвитой өөрчлөлт хийгдээгүй байна.

Хууль санаачлагч хуулийн төслийг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн Цэцийг Үндсэн хуулийн шүүх болох талаас нь холбогдох зохицуулалтыг тусгасан бөгөөд Цэц нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болж, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үндсэн хуулийн 64, 66 дугаар зүйлд заасны дагуу Цэц бүрэн эрхийнхээ хүрээнд маргаантай асуудлыг хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргах, дахин хянаж үзэж эцсийн шийдвэр гаргах, үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх эрх зүйн орчныг бий болгох зохицуулалтыг тусгасан хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн болон бусад материаллаг зардал жилд ойролцоогоор 283 сая 543 мянган 117 төгрөг зарцуулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд хуулийн [d.parliament.mn](http://d.parliament.mn) цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хуулийн төслийг хэлэлцэх цаг үеийн нөхцөл байдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хуулийн төслийг

үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаагаа илэрхийлээд Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг хангах, баталгаажуулах талаар ямар онцлог, зохицуулалт туссан талаар, мөн иргэдээс Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах явцыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавих шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилоход нэр дэвшигчийн сонголт зохион байгуулж буй асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан бөгөөд хуулийн төсөлд тус харилцааг хэрхэн зохицуулах талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хуулийн төслийн талаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн байр суурийг илэрхийлсэн бөгөөд Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавих шаардлагын талаар санал хэлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх

ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Одонтуяа:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Минийх яагаад? Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ Үндсэн хуулийн баталгаа болсон Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх шударга үйл ажиллагааг зарчмын хувьд дэмжих энэ хуулийн төслийг дэмжиж байна. Тэгэхдээ бас асуулт байна. Бид нар энэ Үндсэн хуулийн шүүх гэдэг бол яг хүний үндсэн эрхийн маргааныг авч хэлэлцдэг, төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн байгууллагуудын Үндсэн хууль зөрчсөн үйл ажиллагааг хянан шийдвэрлэдэг том байгууллага.

Тийм учраас ер нь шүүхийн шүүгчдэд тавьдаг бас тодорхой сахилгын болон бусад ёс зүйн хариуцлагыг энэ Үндсэн хуулийн цэцэд

тавилаар байна. Бид нар энэ шүүхийн тухай хуулийг батлахдаа Шүүхийн сахилгын хороог нэлээн бас өндөр түвшинд, хорооны гүйцэтгэх үйл ажиллагаа, шүүгчийн тухайн асуудлыг шийдэх үеийн санаатай үйлдэх болон бусад эс үйлдэхгүйг ялган зааглаж, шүүгчид энэ сахилгын хариуцлагыг нэлээн бас тодорхой болгож өгсөн байдаг.

Гэтэл яг манай энэ Үндсэн хуулийн цэцийн энэ хуулийн төсөл дээр Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдлыг хангасан цалин хангамж болон бусад эрх зүйн хараат бус байдлыг нэлээн сайн зааж өгсөн байна. Эдийн засгийн болон улс төрийн нөлөөллөөс ангид ажиллах. Харин яг Үндсэн хуулийн цэцийн гишүүний тодорхой үйлдэл, эс үйлдэхүй эсвэл сахилгын зөрчил дээр ямар нэгэн ийм санкц гэдэг юм уу, шийтгэл ноогдуулах заалт ер нь байна уу, үгүй юү? Энэ Венецийн комисс жишээлбэл европын нэлээд олон улсын үндсэн хуулийн шүүхэд өгсөн зөвлөмждөө тодорхой сахилгын зөрчлүүд дээр хуульчлах нь зүйтэй гэдэг ийм саналыг өгч байсан байдаг юм.

Жишээлбэл, энэ Армены үндсэн хуулийн шүүхийн хуульд өгөхдөө Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн сахилгын зөрчил, түүн дотор томоохон зөрчлүүдэд гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зааж өгөх нь зүйтэй гэдэг ийм зөвлөмж өгсөн байдаг.

Тэгэхээр манай яг Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд ийм сахилгын зөрчил алдаан дээр ер нь хариуцлага байх уу? Бид нар бүгд мэдэж байгаа. Өмнөх Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүн дэх, мөн одоо байгаа бүрэлдэхүүн дэх зарим гишүүд хүртэл ёс зүйн болон тодорхой алдаа зөрчлүүд гаргаж байсан. Харамсалтай нь үүрэгт ажлаа чөлөөлж байгаагүй. Тэгэхээр хэрэвзээ бид нар Үндсэн хуулийн цэцийн шүүхийг илүү өндөр түвшинд авч үзэж, хараат бус байдлыг нэмэгдүүлж байгаа тохиолдолд мөн адилхан сахилгын зөрчил, сахилгын

болон ёс зүйн алдаан дээр бас хариуцлага тооцох нь зүйтэй болов уу гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаар асуулт нь, энэ Үндсэн хуулийн 65.2 дээр Үндсэн хуулийн цэцийн гишүүн бол хууль зүйн улс төрийн өндөр мэргэшилтэй Монгол Улсын 40 нас хүрсэн иргэн байна гэдэг заалт байгаа. Энэ Цэцийн хууль дээр болохоор хууль зүйн дээд боловсролтой, хууль зүйн, улс төрийн өндөр мэргэшилтэй иргэн гэж нэмж оруулж ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ Үндсэн хуульд авсан ийм заалт оруулах нь ер нь зохистой юм уу, үгүй юү? Европын холбоо, олон улсын хүний эрхийн шүүхүүд, Венецийн комиссын зөвлөмжүүд дээр бас тодорхой зөвлөмж байдаг. Ер нь энэ Үндсэн хуулийн шүүгчдийг ажил мэргэжлийн хувьд хэт нарийвчилдаг мэргэшүүл зааж байгаа нь нийгмийн нөгөө олон талт асуудлыг шийдэх дээр бас учир дутагдалтай гээд байсан ийм зөвлөмж өгсөн байдаг.

Жишээлбэл, энэ Үндсэн хуулийн цэц маань яг хүний үндсэн эрхийн маргааныг шийддэг гол байгууллага болж байгаа хувьд хүний эрхийн өргөн хүрээтэй асуудлыг төлөөлж, энэ асуудлаар мэргэисэн байхыг шаардана. Тэгэхээр энэ даяаршлын нөхцөлд бид нар их олон шинэ асуудлуудыг хүний эрхийн талбар дээр гарч ирэх нь ойлгомжтой. Үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан хийх, иргэний сурч боловсрох эрх, тэр дотроо нөгөө боловсрол ашигийн буюу ашигийн бус байх уу, үгүй юу, хувийн сургууль.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Эхлээд хариултаа авчих уу? Тэгээд тодруулчихгүй юу. Тэгье, эхлээд хариултаа авчихъя. Тэгээд нэмэлт минутаа тодруулчихъя. Мөнх-Оргил гишүүн хариулах уу? Хууль санаачлагч.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Энэ Цэцийн гишүүний хариуцлага гэдэг асуудалд энэ хуулийн төсөлд их анхаарал

хандуулсан. Энэ ер нь шүүмжлэл дагуулж байгаа асуудал мөн үү гэвэл мөн. Бүтэн бүлэг байгаа. 4 дүгээр бүлэг Цэцийн гишүүний хариуцлага гээд. Энд үндсэндээ Монгол Улсын шүүхийн шүүгч нарт тавигдаж байгаа шаардлагууд бол бүрэн тусгагдаж байгаа гэж бид нар ойлгож байгаа.

Шүүхийн хуульд бид нар шүүгч нарт хийхийг хориглосон маш олон зүйлийг тусгасан байхгүй юу. Тэгээд энэ нь өөрөө хэтэрхий нарийвчлаад тусгачих нь бас их зохицуулалт талдаа буруу юм байна гэдгийг бас амьдрал харуулаад байгаа юм. Ерөнхий, аль ч нөхцөлд тааруулаад хэрэглэж болохоор тухайн нөхцөл байдалд тааруулж ашиглаж болохоор ийм зохицуулалтууд нь илүү зөв байгаа юм. Энэ 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйл дээр Цэцийн гишүүний баримтлах зарчим, хүлээх үүрэг, хориглох, хязгаарлах зүйл гээд нийт 3 заалттай, дотроо 8 задарсан ийм том зохицуулалт байгаа юм.

Цэцийн гишүүний хариуцлагын хувьд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд үндсэн санаа нь ийм байгаа байхгүй юу. Гэмт хэрэг үйлдвэл хариуцлага хүлээнэ гэж байгаа юм. Гэмт хэрэг үйлдвэл. Энийг нь бид нар Үндсэн хуультай нийцүүлээд хууль зөрчвөл гэж байгаа юм. Хууль зөрчвөл, бүх л төрлийн хууль зөрчвөл эгүүлэн татах бололцоотой болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, энд чинь зөвхөн Эрүүгийн хууль зөрчихгүй нь байна шүү дээ. Төрийн албаны тухай хууль, тэр сахилга, ёс журмыг зохицуулж байгаа хууль тогтоомжуудыг зөрчвөл Цэцийн гишүүнийг эгүүлэн татах бололцоо нэмэгдэж байгаа юм.

Гуравдугаарт, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд Цэцийн гишүүнийг бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, Цэцийн гишүүнийг эгүүлэн татах асуудал ерөөсөө процесслогдоогүй байхгүй юу. Хэн нь асуудал оруулах юм, хэдэн хоногийн дотор оруулах юм, хэдэн

хоногийн дотор шийдэх юм, ингэж шийдвэл хаашаа очих юм, дараа нь ямар дарааллаар асуудал шийдэгдэх юм гэж процесслогдоогүй байсныг одоо нарийн процессолж өгч байгаа юм. Төслийн 20 дугаар зүйл дээр Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх гэдэг дээр Улсын Их Хурлын гишүүдтэй адилхан Ерөнхий прокурор, Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлага үүслээ. Заавал бүрэн эрхийг нь түдгэлзүүлж байж энэ хүний гэмт хэрэг үйлдсэн эсэхийг шалгах шаардлагатай боллоо гээд асуудлыг Цэцийн нийт гишүүдийн хуралдаанд оруулна. Гуравны хоёророо шийдвэрлэнэ.

Эгүүлэн татах асуудал ерөөсөө зохицуулагдаагүй байсан. Үндсэн хуульд маш тодорхой заалттай л даа. Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Улсын Их Хурал эгүүлэн татна. Гэхдээ Цэцийн шийдвэрийг үндэслэнэ. Мөн анх томилсон байгууллагын саналыг авна гэж байгаа байхгүй юу. Энэ 2 зохицуулалтыг нь бид нар 21 дүгээр зүйл дээрээ нэлээн дэлгэрэнгүй тусгаж өгсөн. Хэн асуудал оруулах юм, хэдэн хоногийн дотор оруулах юм, хэд хоногийн дотор хариу өгөх юм, хариу өгөөгүй бол яах юм, Цэц яаж шийдэх юм, Улсын Их Хурал яаж шийдэх юм гээд энэ дэлгэрэнгүй орсон.

**С.Одонтуяа:** Нэмж хариулъя. Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Хоёр дахь асуултад хариулахад Энэ Үндсэн хуулийн 65 дугаар зүйл дээр Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэж үг байгаа юм. Мэргэшилтэй Монгол Улсын 40 нас хүрсэн иргэн байна гэж. Энэ дээр бид нар хууль зүйн дээд боловсролтой гэж л ганцхан үг нэмж байгаа юм. Ганцхан санаа нэмж байгаа юм. Хууль зүйн дээд боловсролтой гээд. Энэ Үндсэн хуулиас давсан заалт гэж бид нар ойлгохгүй байгаа юм. Үндсэн хуулиас дутуу заалт бид нар оруулчхаж болохгүй. Тавьж

байгаа шаардлагаас нь дутааж болохгүй. Үндсэн хууль дээр тавьж байгаа шаардлага энэ хамгийн наад захын шаардлага гэж бид нар ойлгож байгаа юм.

Тэгээд амьдрал урагшлаад, энэ Цэцийн үйл ажиллагаа өөрчлөгдөөд одоо Цэц төрийн институтууд хоорондын асуудал, хууль Үндсэн хууль зөрчсөн үү гэдэг асуудал хэлэлцэхээсээ илүүтэй үйл ажиллагааных нь 90 гаруй хувь нь үндсэн эрхийн маргаан буюу шүүхийн асуудал. Тухайн хүний өөрийнх нь аж амьжиргаа, эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг болох гэж байгаа учраас энэ гарцаагүй наад захын хууль зүйн боловсрол хэрэгтэй юм гэж бодож байгаа юм.

Тэгэхдээ хууль зүйн боловсролтой гэдэг чинь заавал хуульч гэсэн үг биш шүү дээ. Хууль зүйн боловсролтой мөртөө өөр ажил хийж байж болно. Манай Их Хурал дотор жишээ нь, хууль зүйн боловсролтой гэхдээ эрх зүйчийн, хуульчийн ажил хийдэггүй, бид нар улс төрийн ажил хийгээд явж байгаа маш олон хүн байгаа шүү дээ. Тэрэнтэй адилхан нийгэмд олон хүн байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энийг хязгаарласан гэсэн үг биш. Хүний эрхийг хүний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангах асуудлаар тэр тусмаа олон шатын шүүхийн шийдвэрүүдийг үндсэн эрх зөрчсөн эсэх асуудлыг Цэц хэлэлцдэг болох гэж байгаа энэ үед гарцаагүй хууль зүйн боловсрол бол наад захын шаардлага юм л гэж үзэж байгаа юм. Тэрнээс өөр мэргэжлүүдийг бид нар доош нь хийсэн юм байхгүй. Мэдээж хууль зүй, улс төрийн өндөр мэргэшил шаардагдана. Цэц бол ердийн шүүх биш. Энэ бол Үндсэн хуулийн шүүх гэдэг онцлогийг нь бид нар ойлгож энэ зохицуулалтыг оруул.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Бадарчийн Жаргалмаа гишүүн асуултаа асууна.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Үндсэн хуулийн цэцийн тухай хууль орж ирж байгаа. Сэтгүүлчээр ажиллаж байхад хэн Үндсэн хуулийн цэцийн гишүүн болдог вэ гэдэг зүйлийг маш олон хүмүүс асуудаг байсан. Үндсэн хуулийн цэцийн гишүүдтэй ярилцаж байгаад тэд юу ярьдаг вэ гэвэл хараат бус байх гэдэг зүйлийг машид онцгойлдог. Хэнээс ч хараат бусаар Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн хяналтыг хийх ёстой гэдэг зүйлийг маш ихээр ярьдаг байсан.

Гэхдээ өнөөдөр бид нарт хэрэгжиж байгаа 1992 оны Үндсэн хуулийн цэцийн хуулиараа Ерөнхийлөгч 3 хүн, Улсын Их Хурал 3 хүн, Улсын дээд шүүхээс 3 хүнийг ингээд томилоод Их Хурал дээр хэлэлцэн түүнийг нь баталдаг. Энд ямар нэгэн өөр хүний санал болгох гэдэг юм уу, нээлттэй сонсгол хийх, түүний хууль, эрх зүйн чадамжийг тодорхойлох, олон нийтэд нээлттэй байх тэр боломж байдаггүй. Их Хурал түүнийг хүлээж аваад л явдаг гэж би ойлгодог.

Магадгүй бүрэн эрхийн хугацаа нь дуусаад Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох шүүгч байдаггүй юм уу, яадаг юм ингээд асуудал ингээд удааширдаг. Өөрөөр хэлэх юм бол давуу байдлаар Үндсэн хуулийн цэцэд ажилладаг гэсэн үг. Энэ дээр ямар нэгэн зохицуулалт байгаа юу, үгүй юү хуулийн зохицуулалт дээр?

Тэгээд хараат бус байх гэдэг энэ зарчим энэ 3 субъектээс томилогдож орж ирж байгаа Цэцийн гишүүнд ер нь хэрхэн хамгаалагдаж байна гэж үзэх юм бэ? Хараат бус байх энэ зарчим нь хамгаалагдаж байна гэж үзэх вэ?

Нөгөө талаар мэргэжлийн хуульчийн хувьд хуульчаар ажиллах гэж байгаа хүний хувьд хараат бус байдлыг нь яаж нотлох юм бэ гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм

Хоёрдугаарт нь Шүүхийн ерөнхий зөвлөл болон Дээд шүүх дээр ер нь хуульч л энэ шүүхийн шүүгчээр ажиллах ёстой гэдэг ийм зарчим баримталдаг бол Үндсэн хуулийн цэц дээр шүүгч ч үү, хуульч уу гэдэг энэ зарчим нь шаардагддаггүйгээр Үндсэн хуулийн цэцийн гишүүн болж ажилладаг байгаа. Тэгэхлээр энэ дээр ямар нэгэн зохицуулалт хийгдэж байна уу, үгүй юү гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм.

Үнэхээр Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн цэц хийж байгаа энэ тохиолдолд Цэцийн гишүүний хууль, эрх зүйн ёсыг, ёс зүйн асуудлыг ер нь хэрхэн, яаж шаардах бэ гэдэг зүйл.

Нөгөө талаар, уучлаарай би дараа нь тодруулаад асуучихъя. Мөнх-Оргил гишүүний тайлбарын дараа.

**С.Одонтуяа:** Хууль санаачлагч, Мөнх-Оргил хариулна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Жаргалмаа гишүүн энэ чухал асуудал хөндлөө л дөө. Энэ Цэцийн гишүүний, Цэцийн дарга, гишүүний хараат бус байдлын асуудал гээд. Энэ хуулийг өргөн барихад бидний урдаа тавьж ажилласан гол зорилго энэ хараат бус байдлыг ер нь яаж л Монголын нөхцөлд бодит амьдрал дээр ер нь баталгаажуулах вэ л гэдэг асуудлыг л үзээд байгаа юм л даа. Тэгээд энэ хуулийн төсөл дээр бүхэл бүтэн бүлэг орсон дахиад. 3 дугаар бүлэг Цэц түүний гишүүний хараат бус байдал гээд. Тэгээд энэ нь өөрөө 14 дүгээр зүйл Цэцийн гишүүний хараат бус байдал, 15 дугаар зүйл нөлөөллийн мэдүүлэг, 16 дугаар зүйл Цэцийн гишүүний эдийн засаг, нийгмийн баталгаа гээд. Тэгээд 17 дугаар зүйлд Цэцийн хараат бус байдал, Цэцийн төсөв, санхүүгийн баталгаа гээд ингээд олон задарч байгаа.

Өөрөөр хэлбэл, хараат бус байдлыг анх удаа процессолж өгч байгаа



юм. Хараат бус байдалд ерөөсөө нөлөөлж болохуйц хамгийн том хүчин зүйл томилгооны буюу нэр дэвшүүлэх асуудал. Бусад улс орнуудад Цэцийн гишүүнийг эсвэл насан туршаар нь томилж байгаа юм. Шүүгчтэй адилхан. Тэгэхгүй бол чамайг 6 жил томилчихлоо, 4 жил томилчихлоо, дахиад томилох уу, үгүй юү харна, сахилга батаас чинь харна, миний үгэнд орох орохгүйгээс чинь харна гээд нөлөөлөөд байх бололцоо үүсээд байна шүү дээ.

Тийм учраас эсвэл насан турш нь томилж байна. Жишээ нь, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн шүүх, эсвэл Солонгос шиг Бүгд Найрамдах Солонгос Улс шиг 1 удаа 9 жилээр томилж байна. Тэгээд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж байхад бид нар бүлэг дээрээ ч гэсэн ярьж байсан, ажлын хэсэг дээр ч гэсэн ярьж байсан Цэцийн гишүүнийг 1 удаа 9 жилээр томилох асуудлыг судалъя гээд. Тэгээд энэ Үндсэн хуульдаа оруулаагүй. Нэг энэ удаа томилж, одоо бол Үндсэн хуульд 6 жилээр томилно, ахиж томилж болох юм уу, хэдэн удаа томилж болох юм, эсвэл ганцхан удаа юм уу гэдэг заалт тодорхойгүй байгаа байхгүй юу. Хоосон орхигдчихсон. Тэгэхлээр бид нар 1 удаа л дахиж томилъё гэж байгаа юм. Улируулъя.

Өөрөөр хэлбэл, 12 жил Цэцийн гишүүнээр ажиллаад тэгээд больё. Тэгэхгүй бол дахиж томилогдох гээд, дахиж нэр дэвших эрхээ авах гээд анх томилсон байгууллагынхаа юм уу, томилсон институтийнхээ шууд хараат бус юм аа гэхэд дохио зангааг нь хардаг, сигнал дохио хүлээдэг, тэнд нэг тал алдчихгүй байх тийм сонирхол үүсээд байгаа байхгүй юу. Энэ олон улсын сайн жишиг. Ер нь бусад улс орнууд ч гэсэн ер нь тэгээд байгаа юм. Шүүгч бол ер нь тэр хараат бус байх гэдэг асуудал, үндсэндээ мэдээж цалин мөнгөний асуудал байгаа. Хамгийн гол нь томилгооны асуудал байгаа шүү гэж.

Тэр хуульчийн хувьд сая Мөнхцэцэг гишүүний асуулттай давхцаж байна. Үндсэн хуульд заавал хууль зүйн дээд боловсролтой гэсэн шаардлага байхгүй л дээ. Хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэж. Тэгэхдээ энэ дотор хууль зүйн өндөр мэргэшил дотор хууль дээд боловсрол.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Жаргалмаа гишүүн тодруулъя.

**Б.Жаргалмаа:** Ер нь яг Үндсэн хуулийн цэцэд ажиллаж байсан гишүүдтэй Жанцан гуай, Амарсанаа ч гэдэг юм уу, Чинбат, Сарантуяа гээд ингээд эдгээр хүмүүстэй ярилцаж байгаад ер нь иргэдэд эргээд Үндсэн хуулийг таниулах, мэдрүүлэх, байнга Үндсэн хуулиа сануулж байх энэ зарчим ерөнхийдөө алдагддаг гэдэг зүйлийг аягүй сануулдаг л даа. Би олон нийтэд Үндсэн хуулийн энэ мөн чанарыг, зарчмыг танилцуулах энэ үйл ажиллагааг ер нь хэн хариуцах ёстой юм бэ дээ гэдэг зүйлийг бас их аягүй тодруулдаг байсан юм.

Тэгэхлээр энэ дээр ямар нэгэн байдлаар хэдийгээр Үндсэн хуулийн цэц шүүхийн үйл ажиллагаа явуулдаг боловчиг түүнд эрх, үүргийг хүлээлгэхдээ яг энэ асуудлыг ер нь тусгасан болов уу гэдэг зүйлийг тодруулах гэсэн юм. Түрүүний миний асуусан ёс зүйн асуудал дээр нарийн зүйл, заалтууд байгаа юу? Би сая хуулийн танилцуулгыг, төслийн танилцуулгыг харж байхад ам хуралдаан гэдэг юм уу ийм зүйлүүд байгаад байна л даа. Өнөөдөр тухайн иргэний эрх зөрчигдсөн тохиолдолд шууд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэх, гомдол гаргах эрх үүссэн, хуулиараа үүссэн энэ тохиолдолд тэдгээрийн ачаалал.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Үндсэн хуулийг сурталчлах үүрэг нийт Монгол төрийн л үүрэг л дээ. Бүх шатны бүх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн албан хаагч, төрийн байгууллагуудын үүрэг.

Гэхдээ энэ бол Үндсэн хуулийн цэцийн гол үүрэг биш. Үндсэн хуулийн цэцийн гол үүрэг бол Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар маргааныг л эцэслэн шийдвэрлэж байдаг байгууллага. Тэгээд энэ дээр Үндсэн хуулийг сурталчилна гэдэг асуудал өөрөө их нарийн төвөгтэй асуудал юм байгаа юм.

Яагаад гэвэл Үндсэн хуулийн олонх, ихэнх заалтууд энэ үндсэн гол гол заалтууд нь заавал бусад Улсын Их Хурлаар баталж байгаа органик болон органик биш хуулиудаар амилж байгаа байхгүй юу. Амь орж байгаа. Эрх нь түрүүгээрээ баталгаажиж байгаа. Тэгэхлээр тэр хуулиудаа сурталчлах нь бас илүү чухал.

Тэгээд манай энэ Үндсэн хууль бол өрөө их миний бодлоор шүү их мундаг бичигдсэн олон Монголын болон бусад улс орнуудын амьдралын туршилага дээр суурилсан, гаргалгаа сайтай их заалтууд байгаа, заалт ихтэй мундаг хууль л даа. Үүний хамгийн тод жишээ бол бид нарын энэ үндсэн эрхийн маргааныг оруулах гээд байгаа асуудал. Энэ чинь Үндсэн хуулийн 50.1.3 дээр заачихсан байгаа байхгүй юу. Хууль түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар Үндсэн хуулийн цэц, Ерөнхий прокурор, Дээд шүүхэд асуудал оруулж шийдвэрлүүлж болно гээд бүүр ингээд замыг нь нээгээд өгчихсөн байгаа байхгүй юу.

Гэтэл энийг бид нар ерөөсөө 30 жилийн дотор нэг ч удаа хэрэглээгүй. Тэгэхлээр энэ мэтээр энэ манай Үндсэн хуульд асар их потенциал байгаа юм. Үүнийгээ л бид нар өшөө нэмж ашиглах нэг жишээ нь, энэ Үндсэн хуулийн цэцэд үндсэн эрхийн маргаан хэлэлцдэг болохыг л оруулж ирж байгаа юм.

Тэр ёс зүйн хариуцлагын хувьд би түрүүн хэлсэн 4 дүгээр бүлэг гээд Цэцийн гишүүний хариуцлага гээд тусдаа том бүлэг орсон байгаа. Энд шүүгч нарт тавьж байгаа шаардлага бол үндсэндээ Цэцийн гишүүдэд тавигдаж байгаа юм. Тэгэхдээ.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Тодруулах хоёр асуудал байна. Тэгэхээр Үндсэн хуулийн 65.2-т Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй иргэнийг томилно гээд ингээд заачихсан байж байгаа. Тэгэхээр өндөр мэргэшил гэдэг тодорхойлолт одоохондоо тайлбарласан юм бараг байхгүй байгаа. Тэр улс төрийн өндөр мэргэшил гэдэг дотроо Очирбат гуай, Болдбаатар гуай энэ тэр гээд томилогдоод явж л байсан л даа. Тэгэхээр энэ нэгдүгээрт энэ өндөр мэргэшил гэдгийг сайн тодорхойлж өгөх хэрэгтэй байна. Мэргэшинэ гэдэг шүүх дээр жишээ нь, эрүү, иргэн, захиргаа энэ тэр гээд мэргэшээд, олон жил яваад, тэрнийхээ дагуу хамгийн хариуцлагатай шийдвэр гаргаад ингээд шүүгч нар явдаг.

Тэгэхээр энэ өндөр мэргэшил гэдэг дотор таны энэ хуулийн бакалавртай хүн ирээд л суучих ийм боломжийг л бүрдүүлж байна л даа. Ер нь яг ийм хуульчийн мэргэжлээр төгсчихөөд ямар ч ажил хийгээгүй, ямар ч ажлын туршилага, дадлагагүй хүмүүс очоод суух ийм боломжийг та нээж өгөөд байгаа юм.

Тийм учраас энэ яг энэ Үндсэн хуулийн тэр өндөр мэргэшил гэдэг тэр тайлбар байхгүйгээр тайлбарыг бас зөрчиж байна л гэж би үзээд байгаа юм л даа.

Хоёрдугаарт нь тэр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Цэц шийдвэр гаргах ийм боломжийг нээж өгч байгаа. Би үүнийг дэмждэг юм. Яагаад гэвэл

манай Тэмүүжин, Эрдэнэбат нарын хуульч үүнийгээ заавал дэмжих ёстой шүү гэж надад бас зөвлөдөг.

Тэгэхдээ жишээ нь, яг хүний эрхийн асуудлаар Иргэний хэргийн шүүхийн шүүгч 3 шатны шийдвэр гаргаад тэнд чинь хамгийн мэргэшсэн хүмүүс олон 10 жил ажиллачихсан тэр хүмүүс хамгийн сайн шийдвэрийг гаргаад дуусгачхаж байгаа. Тэгэнгүүт тэрийг нь Цэцэд өгөнгүүт Цэцэд тийм бакалавртай нөхөр, аль эсвэл хуульчаар төгссөн ч гэсэн бас тийм огт ажиллаагүй нөхөр тэнд очоод шийдвэр гаргаад, тэр нь буцаагаад шүүгч нараа асуудалд оруулах ийм л юм болох гээд байна л даа. Тэгэхээр шүүгч нар өөрсдөө үнэмлэхтэй, сертификаттай. Тэр сертификатынхаа дагуу асуудал гаргалаа гэхэд шүүгч нар та Сахилгын хороогоороо дамжуулаад хариуцлага тооцоод явдаг.

Гэтэл энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүнд чинь хариуцлага тооцох тийм субъект бас байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүс чинь тэр хүний эрхийн асуудлаар зөрчилтэй шийдвэр гаргалаа гэхэд энэ асуудлаа яг тийм сайн мэргэшээгүй хүмүүс энэ асуудал дээр өрөөсгөл шийдвэр гаргавал яах юм? Тэгээд 3 шатын шүүх шийдчихсэн асуудал дээр дахиад л тэр нөхөр тэс хөндлөн юм шийдээд л, тэрнээс нь болоод асуудал үүсээд л энэ Цэцийн шийдвэрийг хэн ч шийдэх боломжгүй ийм нөхцөл байдал руу орчихлоор энэ асуудлууд чинь бас тийм өрөөсгөл байдал руу орж эхэлнэ шүү дээ.

Тийм учраас энэ 2 асуудлаар нэгдүгээрт өндөр мэргэшил, хоёрдугаарт нь яг тэр мэргэшсэн хүн тэнд суухгүйгээр хүний эрхийг хамгаалах талаар буруу шийдвэр гаргах тохиолдолд яах вэ гэдэг асуудал гарч ирээд байгаа байхгүй юу. Энэ бол Үндсэн хуулийг бас тодорхой хэмжээгээр зөрчиж байгаа асуудал гэж би дүгнээд байгаа.

Тийм учраас би энэ хуулийг Ардчилсан намын бүлэг завсарлага аваад, энэ Их Хурлын Хууль, эрх зүйн газраар бас тодорхой хэмжээний Үндсэн хууль зөрчиж байна уу, зөрчөөгүй байна уу гэдэг тийм дүгнэлтийг зайлшгүй авах шаардлагатай гэж би үзэж байгаа. Тэрний дараа хэлэлцээд явсан нь зөв.

Мэдээж энэ хууль ямар ч байдлаар орж ирж болно. Тэгэхдээ энэ Их Хурал гэдэг чинь тэрийг хэлэлцээд, сайжруулаад илүү сайн болгоод явах ийм л институт шүү дээ. Тэгэхээр энэ дээр мэдээж хамтраад ажиллах ийм боломж нь байгаа.

Тийм учраас миний энэ эрх зүйн дүгнэлт гаргаач гэдэг энэ саналыг бас манай Их Хурлын дэд дарга Одонтуяа дарга бас анхаарч үзээч гэж хүсэж байна. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Санал байсан гэж ойлгох уу? Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Улс төрийн өндөр мэргэшил гэдгийг энэ хуульдаа тайлбарлахгүй байсан юм уу гэж Пүрэвдорж гишүүн эхний асуултаа асууж байгаа юм л даа. Тэгээд энэ дээр бид нар нэлээн их ярьсан л даа. Ер нь энэ хууль тийм, хууль зүйн өндөр мэргэшил, улс төрийн өндөр мэргэшил гэж. Тэгээд энэ бол ер нь 3 жил яригдаж байгаа хуулийн төсөл учраас нийт энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хууль чинь бид нар ер нь бараг 15 төсөл гарч байгаа байхгүй юу. Тэгээд янз янзаар үзэж байгаа юм. Тэгээд энэ дээр Пүрэвдорж гишүүнээ бид нар ер нь эцсийн дүндээ юу гэж үзсэн бэ гэхлээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэдгийг томилж байгаа Улсын Их Хурал өөрөө л тогтоох ёстой.

Тэрнээс биш Улсын Их Хурлын гишүүнээр ажилласан бол улс төрийн өндөр мэргэшилтэй гэж тооцно, эсвэл Ерөнхийлөгчөөр ажилласан бол улс төрийн өндөр мэргэшилтэй гэж тооцно, эсвэл МУИС-ийн улс төрийн ангийг

төгссөн бол, эсвэл гадаадад Phd хийсэн бол өндөр мэргэшилтэй гэж тооцно гэх бололцоогүй юм байна лээ. Амьдрал баян. Үндсэн гол санаа бол Үндсэн хуулийн цэцийн үүрэг, функц буюу маргаан хууль Үндсэн хуулийг зөрчсөн үү, үгүй юү гэдэг асуудлыг шийдэхэд шударгаар ёс зүйтэй, өндөр мэргэшилтэй оролцоод дүгнэлт гаргачих энэ хүн мөн үү, үгүй юү гэдгийг л Улсын Их Хуралд бид нар санал өгч шийдэж байгаа байхгүй юу.

Тэгэхийн тулд Улсын Их Хуралд энэ асуудлыг үлдээж байгаа юм. Тэгэхлээр үүгээрээ явах нь зүйтэй юм байна. Тэгэхгүй бол бид нар ингээд хайрцаглагчхаж болохгүй юм байна.

Жишээ нь, аймгийн намын хороон дарга хийж байсан бол улс төрийн өндөр мэргэшилтэйд тооцоод, дүүргийн намын хороон дарга хийж байсан бол улс төр өндөр мэргэшилтэй гэж тооцохгүй бол болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Эсвэл Их Хурал нэг сонгогдсон бол бага мэргэшилтэй, 4 сонгогдсон бол өндөр мэргэшилтэй гэж хэлж болохгүй болчихоод байгаа байхгүй юу.

Хууль зүй бас адилхан. Шихихутуг төгссөн бол өндөр мэргэшилтэй, өөр сургууль төгссөн бол бага мэргэшилтэй гэж бас хэлж болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхлээр энэ бол хууль тогтоогч, Үндсэн хууль тогтоогч энэ асуудлыг шийд ээ, шийдэх бүрэн эрх нь Улсын Их Хуралд байна. Тухайн хүн энэ шаардлагыг хангаж байна уу, үгүй юү гэдгийг нь үлдээж байгаа. Бид нарт энэ эрхийг нь үлдээж байгаа юм.

Бид нар харин одоо үндсэн эрхийн маргаан шийдвэрлэдэг болж байгаа учраас ганцхан заалт дээр тодруулж өгч байгаа юм. Хууль зүйн дээд боловсролтой байна шүү. Хууль зүйн дээд боловсролтой байна гэдэг чинь улс төрийн өндөр мэргэшилгүй гэсэн үг биш байгаа байхгүй юу. Хууль зүйн дээд боловсролтой мөртөө улс төрийн өндөр мэргэшилтэй

байж болно шүү дээ. Энэ талаас нь үзмээр байгаа юм.

Тэр үндсэн эрхийн маргаан дээр би жосоохон дэлгэрэнгүй тодруулга хийчихье. Яагаад гэвэл энэ Улсын Их Хурал энэ хуулийг батлах юм бол энэ монгол төрийн хүний үндсэн хуулиар олгогдсон эрхийг хамгаалах асуудал дээр бид нарын сүүлийн 30 жилд энэ Үндсэн хууль батлагдсанаас хойш оруулж байгаа хамгийн том өөрчлөлт орох юм байгаа юм. Тэгээд энэ өөрөө шүүхийн үйл ажиллагаа, прокурор, төрийн захиргааны байгууллагууд, Цэцийн үйл ажиллагааны хоорондын уялдаанаас маш их шалтгаална. Маш их юм өөрчлөгдөнө. Энэ дээр 2 асуудал байгаа юм.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Пүрэвдорж гишүүн тодруулж асууя. 1 минут.

**Б.Пүрэвдорж:** Тэр өндөр мэргэжлийг Их Хурал дээрээ тодорхойлоод, тэндээ шалгуураа тавиад явна гэдэг бол өрөөсгөл. Өнгөрсөн хугацаанд яаж явсан юм бэ гэхээр Их Хурал гурвыг нь, Ерөнхийлөгч гурвыг нь, Дээд шүүх гурвыг нь. Тэгээд энэ тохиолдолд дандаа тэр ялсан намын дарга нарын саналын дагуу асуудал орчихоод ирдэг. Ингээд л ерөөсөө хэтэрхий олонх ялчихсан тохиолдолд энэ өндөр мэргэшилтэй гэдэг юман дотор чинь нөгөө 2, 3 субъект чинь бүгдээрээ тохирч байгаад л тэгээд л дурын хүнээ оруулж ирээд л тэгээд л шууд Их Хурлын гишүүдийг дуугүй болгож байгаад л тэр Ерөнхийлөгч, Их Хурлын дарга нар чинь бүгдийг нь томилоод явчих ийм боломж нь байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ асуудал дээр нэг тийм бас гэгээлгээр их бодоод хэрэггүй. Бид нар тийм учраас энэ өндөр мэргэшил гэдэг зүйлийг.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар яг таны сая ярьж байгаа аюул байгаа учраас Пүрэвдорж гишүүн ээ энийг чинь энэ хуулийн төслөөрөө бүгдийг нь хааж өгч байгаа юм. Яаж хааж байгаа гээч Дээд шүүхээс томилогдож байгаа, нэр дэвшиж байгаа Пүрэвдорж гишүүн ээ Дээд шүүхээс нэр дэвшиж байгаа хүмүүс чинь Дээд шүүхийн шүүгчид байна. Дээд шүүхийн шүүгчид байна. Улсын Их Хурлаас нэр дэвшихдээ Улсын Их Хурал олонх, цөөнх байхгүй бол Улсын Их Хуралд суудалтай намуудыг хувь тэнцүүлж байгаад ажлын хэсэг гаргаад, тэр ажлын хэсгийн гуравны хоёрын саналыг авсан өөрөөр хэлбэл олонх, цөөнхийн аль алиных нь дэмжлэгийг авч байгаа хүмүүсийг Улсын Их Хурал нэр дэвшүүлэх байхгүй юу.

Тэгэхлээр таны саяын яриад байгаа шиг дарга цэрэг нарт таалагдсан хүмүүс ордог асуудал энд байхгүй болж байгаа юм. Гол юм бол энэ үндсэн эрхийн маргааны асуудал байгаа юм. Үндсэн эрхийн маргаан дээр тэр бакалавр боловсролтой хэдэн нөхдүүд очоод л Дээд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох тухай асуудал энд байхгүй. Тийм юм явуулж байгаа Улсын Их Хурал өөрөө харууллага хүлээх ёстой байхгүй юу нэгдүгээрт.

Хоёрдугаарт, одоо энэ хууль хүчин төгөлдөр болоод үйлчлэхээр Улсын дээд шүүхээс нэр дэвшиж байгаа хүмүүс нь Дээд шүүхийн шүүгчид байна. Өөрөөр хэлбэл, Цэцийн 9 гишүүний чинь 3 нь Дээд шүүхийн шүүгч нар байх байхгүй юу. Дээд шүүхийн шүүгчийнхээ ажлаас чөлөөлөгдөөд тэнд Цэцийн гишүүн болоод очно. Тэгж байж тэд нар чинь энэ Цэц шүүхийн шийдвэр ингэж ингэж гардаг үндэслэлтэй, ийм ийм юм байдаг юм гээд дүгнэлтээ гаргаж хэлнэ. Энэ нь өөрөө Цэцийн шийдвэр Дээд шүүх дээр хүлээн зөвшөөрөгдөх үндэслэлийг бий болгож байгаа юм.

Ингэх хэрэгтэй байна, энэ асуудлыг ингэж шийдэх хэрэгтэй байна гэдэгт Улсын дээд шүүх санал нэгтэй биш боловч олонхоороо хүлээн зөвшөөрч байгаа юм. Тэгээд 3 процессын хуульд өөрчлөлтүүд орж байгаа юм. 3 процессын хуульд өөрчлөлт орж байгаа юм. Дээд шүүхийн шийдвэрийг Пүрэвдорж гишүүн ээ шууд хүчин төгөлдөр бол.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Пүрэвдорж гишүүн 1 минут тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр Цэцийн гишүүд дээр ямарваа нэгэн шалгуур тавьдаггүй. Жишээ нь, хуульчийн сонгон шалгаруулалт өгүүлдэггүй. Ингээд Цэцийн гишүүн болох дээр онцгой эрх авчихсан. Тэгсэн мөртөө бусад байгууллага дээр прокурор ч юм уу байдаг юм шүүх ч юм уу тэр газарт болох дээр хуулийн сургууль төгсчихсөн хүмүүсийг дахиад л хуульчийн сонгон шалгаруулалт авдаг. Тэгээд ажил, мэргэжлээр нь ялгаварлах, байгаа тэр томилогдож байгаа газраа, албан тушаалаар нь ялгаварлах ийм хандлага гараад байгаа байхгүй юу. Инженер хүн инж инженерийнхээ сургууль төгсчхөөд дахиж шалгалт өгдөггүй биз дээ? Тэрэнтэй адилхан.

Ер нь ингээд нэгэнтээ энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн асуудлыг ингэж шийдвэрлэж байгаа бол буцаагаад тэр доор, доод шатад хүртэл бүгдээрээ тэр тухайн байгууллагууд өөрсдөө тэр шалгалтаа аваад шийдвэрлэдэг ийм юмыг нь нээж өгөөрэй. Тэгээд ер нь Цэцийн гишүүн нь хамгийн дээд талд байгаа хөх тэнгэр гэж яригдаж байгаа Цэцийн гишүүн л сонгон шалгаруулалт авахгүй бол доор нь адилхан л авахгүй байх ёстой шүү дээ. Ийм зүйлийг бас та дараа дараагийнхаа хууль дээр хуульч хүний хувьд оруулж ир.

**С.Одонтуяа:** Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууна.

**С.Ганбаатар:** Эрх баригчдын, Монгол ардын намын урдаа барьдаг хуульч ийм юм оруулж ирж байгаад би мэл гайхаж байна. Би эсэргүүцэж байна. Үндсэн зарчмаа шууд ярьчихъя. Хуульд оруулж ирж байгаа энэ Үндсэн хуулийн суурь зарчмуудын эсрэг зүйл орж ирж байна. 4.2.5 Үндсэндээ ийм байгаа л даа.

Ер нь Цэцээр юу хэлэлцэх ёстой юм бэ? Түүний бүрэн эрхийн дотор Ерөнхийлөгч 4.2.3-ыг би уншиж байна. Ерөнхийлөгч Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх л гэж байгаа юм. Эднүүсийн шийдвэр Үндсэн хуульд нь нийцэж байна уу, үгүй юү гэж байгаа юм. Олон улсын хүний эрхийн конвенцод байдаг л даа. Ер нь шийдвэр гаргагч нар хүний эрхийг зөрчдөг юм шүү гэж байгаа юм. Тэгсэн өнөөдөр таны оруулж ирж байгаа юман дээр, 4.2.5 дээр иргэний үндсэн эрхийн маргаан гэж оруулж ирж байгаа юм. Үндсэндээ бусад шүүхүүдийн ажлыг давхардуулж байна, булааж байна, ажилгүй болгож байна л гэсэн үг. Энэ байж болохгүй зүйл.

Нөгөө талаараа энэ дарга нарыг дур зоргыг хазаарлах ёстой ажлаа олигтой хийхгүй байж байж бусад ажил руу хошуу дүрж байна гэж би ойлгож байна. Либерти гэж үндсэн хуулийн үндсэн зарчим нь дарга нарын, сайд нарын дур зоргыг боомилох гэж анх гарч ирсэн зүйл л дээ. Тэгвэл тэрнийхээ хажуугаар тэртээ тэргүй та нар бас би юм хэлье, танд хоёр зүйл хэлье. Ёстой гуя дагаж хүзүү гэдэг шиг тэр тэтгэвэр хамаагүй. Гол ярьж байгаа юм нь үндсэн зарчим нь, үндсэн суурь таны барьж байгаа юм нь Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 1.1.3.2.2-т Хүний эрхийн Үндэсний Комисст Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Засгийн газрын гишүүд, Улсын дээд шүүх, Ерөнхий шүүгч, прокурорын Үндсэн

хуульд заасан хүний эрх, эрх чөлөөний талаарх заалтыг зөрчсөн тухай асуудлаар иргэдээс гомдол гаргахад тэд энэ асуудлыг шийдээрэй гэж байгаа.

Дээр нь 1.1.1.2-т хуулийн Цэц болон бусад шүүхээс гэж байгаа шүү. Цэц бусад шүүхийн асуудлыг давхардуулж аваарай гэсэн үг биш. Та хоёр анхаар. Тэгэхдээ Цэц өөрөө энэ сайд дарга нар чинь хүний эрхийн онцлогтой хүний эрхийг зөрчсөн шийдвэрүүд гаргах вий гэдгийг онцгой анхаар л гэсэн.

Хоёрдугаар зүйл. Энийг би эсэргүүцэж байгаа гол зүйл гэвэл энэ батлагдсанаараа дараагийн тэр процессын хууль нь батлагдах юм байна лээ. Тэр хоёртой холбогдуулж Улсын дээд шүүхээс дүгнэлт ирсэн байна. Өөрөөр хэлбэл би танаас онцлог асуух гээд байгаа юм гэвэл энэ иргэний эрхийн маргаан гэдэг чинь иргэний үндсэн эрхийн маргаан гэдэг чинь ерөөсөө ямар ч эзэн биегүй явж байгаад өнөөдөр Цэцэд өгөх гээд байгаа юм уу, эсвэл шүүх дээр харьяалуулаад яваад муу ч сайн ч яваад бүүр барахаа болиод тэднүүсээс салгаж авч байгаа юм уу, эсвэл тэд чадахгүй байна дэм өгье гэж байгаа юм уу гэдгийг тодорхой болгох үүднээсээ энэ дээр Улсын дээд шүүхээс тодорхойлолт ирсэн байна. Энэ байдал бий болох юм бол 4 шатлалаар хэрэг хянадаг болно. Анхан шат, дунд шат, Улсын дээд шүүх. Тэртээ тэргүй та нар Улсын дээд шүүхийн шийдвэрийг хянах эрх нь энэ Цэцэд байгаа л даа энэ хуулиараа. Тэгэхэд 4 шаттай. Энэ тодорхойгүй байдал үүснэ. Бүүр энэ дээрээ тодорхой хэлсэн байна лээ шүү. Хуулийн төсөлд тусгагдсан шинэ зохицуулалтыг энэ хэвээр баталбал маш тодорхойгүй байдал үүснэ гэж байгаа юм. Бүүр энэ дээр өндөр гэж байгаа шүү, өндөр тодорхойгүй байдал үүснэ.

Тэгэхлээр энэ үүднээс өргөн мэдүүлсэн хуулийн төслийг бусад гишүүд нь арай ч үүнийг дэмжихгүй байлгүй дээ. Зүгээр буцааж татаад авах боломж

байна уу? Энэ бол Улсын Их Хурлын Үндсэн хуулийн цэцээ хүндэтгэж Үндсэн хуулийн суурь зарчмуудыг шинэ шатад гаргах биш улам баталгаажуулж, сайжруулах.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Хууль санаачлагч Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Ганбаатар гишүүн ийм байр суурьтай байгаад би бас харамсаж байн. Мааш их харамсаж байна. Та энэ оруулж ирсэн хуулийн ерөнхий үзэл санаа, үндсэн эрхийн маргаан гэдэг зүйлийг ерөөсөө ойлгоогүй байгаа юм байна. Таны саяын уншиж танилцуулаад байгаа Улсын Их Хурлын 2003 онд 41 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт чинь та сая зөвхөн нэг заалтыг нь уншихлаа шүү дээ. Яг дээд талын заалтад нь ийм байгаа байхгүй юу. 1.1.3.1.3-д Цэцийн үйл ажиллагааг идэвхжүүлж, Үндсэн хуульд заасан хүний эрх зөрчсөн тохиолдлыг шийдвэрлэхэд онцгой үүрэгтэй ажиллуулах механизм болго гэж заасан байхгүй юу нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ өөрөө Үндсэн хуульд ерөөсөө хориглосон зүйл биш. Харин Үндсэн хуульдаа энийг хийгээрэй гэж үндсэн хуульд чинь заалт орсон байхгүй юу. Тэр нь Үндсэн хуулийн 50 дугаар зүйл. Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд.

Гуравт нь хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх гээд Үндсэн хуульд чинь заачихсан байхгүй юу. Үндсэн хуульд. Бид нар үүнийг 32 жил хэрэгжүүлээгүй байхгүй юу. Хэрэгжүүлээгүй байхгүй юу. Яг тан шиг юм ярьж байгаад шүүхгүй болголоо, шүүх ёстой асуудал шийдэх гэж байхад Цэц дунд дундуур нь орж ирэх гэж байна гэсээр байгаад 32 жил энэ Цэц хүний эрхийг хамгаалах

асуудлаар үүрэг гүйцэтгэх асуудлыг нь хойшлуулчихсан байхгүй юу. Хариуцсан хүн шүүх дээр байгаа юм.

Тэгэхдээ шүүх дээр хүний эрх нь зөрчигдлөө гэж хэвээр үзэж байгаа бол тэр эрхээ Цэцээр хянуулах эрх нь байна шүү гэж Үндсэн хуулийн 51.3-д хэлсэн байхгүй юу. Хэлчихсэн юм. Тэрийг нь хэрэгжүүлж өгөхгүй байгаа юм. Та энэ дарга нарын дураараа загнаж байгааг хязгаарлахын оронд шүүхийг ажилгүй болгож байна гэж хэлж байна шүү дээ. Яг эсрэгээрээ байхгүй юу. Энэ чинь яах вэ гэхлээр дарга нар дураараа доргичихно, төрийн захиргааны байгууллагынхан дураараа доргичихно, тэр хүний эрх зөрчигдчихнө, шүүхийн бүх шатаар явчихна. Асуудал нь шийдэгдээгүй байхгүй юу. Тэгээд Цэц дээр очихлоор надаа энэ судалгаа байж байна. Өнгөрсөн 32 жилийн хугацаанд 300 гаруй удаа Дээд шүүх, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн талаар гомдол гаргасан. Цэц хэлэлцээд хэлэлцэх бололцоо байхгүй.

Яагаад гэвэл энэ хуулийн заалт байхгүй. Үнэхээр зөрчигджээ гэдэг нь Цэцийн гишүүд хүлээн зөвшөөрөөд байгаа. Одоо энэ судалгаан дээр зөвшөөрөөд байгаа юм. Гэхдээ хуулийн заалт байхгүй учраас хэрэгжүүлж чаддаггүй. Харин энэ заалт орох юм бол тэр дарга нарын төрийн захиргааны албан хаагчдын дураараа загнасан үйлдлийг чинь Цэц хэлэлцээд Дээд шүүх ээ танай танай давж заалдах шатын шүүхийн ийм шийдвэр чинь Үндсэн хуулийн энэ заалтыг зөрчсөн байна, энийг та нар хэлэлц гээд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож байгаа биш. Дээд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож байгаа биш. Алдаагаа засах бололцоог.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Ганбаатар гишүүн тодруулъя. 1 минут.

**С.Ганбаатар:** Яах вэ ээ нуль ухаан царайлж байгаад л чи ойлгоогүй байна гэж хэлэх амархан. Би бол зүйл,

заалтаар. Би зүйл заалтаар нь ярьж байна шүү дээ. Би зүйл заалтаар нь ярьж байгаа байхгүй юу. Би зүйл заалтаар нь ярьж байгаа. 1.1.3.2.2-ыг ярьж байгаа

Хоёрдугаарт би Улсын дээд шүүхээс ирсэн дүгнэлтийг бас би ярьж байгаа. Энэ дээр давхардана, энэ дээр одоо маш өндөр ийм тодорхойгүй байдал үүснэ гэж байгаа юм шүү. Бүүр тодорхойгүй байдал үүсэх гээд байна. Үүнийгээ эргэж хараач, үүнийгээ засаач гэж хэлсэн. Тэгэхлээр энэ дээр Улсын дээд шүүх дээр энэ маргаанаа, энэ үл ойлголцлоо засаад залруулаад ороод ирсэн юм уу? Би тодруулж асууж байгаа нь энэ.

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн тодруулгад хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Ганбаатар гишүүн ээ энэ хуулийн төслийг өргөн барихаасаа өмнө бид нар Улсын дээд шүүхэд хуулийн төслөө хүргүүлсэн юм. Өргөн барихаас өмнө. Тэгээд таны саяын хэлж байгаа эш татаад байгаа Дээд шүүхийн саналыг нийт шүүгчдийнхээ зөвлөгөөнөөр хэлэлцээд бид нарт ирүүлсэн. Тэр саналуудыг нь бид нар тусгасан. Тусгахаар барах уу Дээд шүүхийн шүүгч нартай хамтарч ажлын хэсэг гаргаад, саяын тэр тодорхойгүй байна, үлдэж байна гээд байгаа асуудлуудыг процессын хуулиуд дээр тусгасан.

Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүхийн шийдвэр гараад Дээд шүүх дээр очихгүйгээр асуудал шүүхийн шат нь дуусчихлаа. Энэ үед яах вэ? Үндсэн эрхийн маргаан үүсвэл, үнэхээр үндсэн эрх маргаан үүсгээд зөрчигджээ гээдэг Цэцийн дүгнэлт гарах юм бол ийм дэс дарааллаар асуудлыг шийднэ гээд эрүүгийн, захиргааны, иргэний процесстoo тусгачихсан юм. Дээд шүүхийнх нь өөрийнх нь шийдвэр хууль зөрчсөн байна гээд Цэц үзчихвэл Цэц Дээд шүүхэд өгнө, тэд хоногийн дотор өгнө. Дээд шүүх нь ингэж хэлэлцэнэ гээд

Дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцээд дэмжигдчихсэн саналыг бид нарт бас ирүүлсэн.

Тэгэхлээр энэ бол юу гэдэг юм мэдээж Дээд шүүхийн бүх шүүгч нар энэ дээр сэтгэл хангалуун биш байгаа л даа. Мэдээж өөрийнх нь гаргаж байгаа шийдвэрийг өөр нэг байгууллага хянаад л чи Үндсэн хууль зөрччихсөн байна, үндсэн эрх зөрччихсөн байна гээд байх ч хэнд ч сонирхолтой биш байхгүй юу.

Тийм учраас энийг 32 жил эсэргүүцээд явж байгаа байхгүй юу. 32 жил. Харин энэ удаагийн дээд шүүх үнэхээр хэрэгтэй юм, хүний эрх хамгаалахад хэрэгтэй юм, Үндсэн хуулийн энэ 50.1.3 гэдэг заалтыг амилуулахад хэрэгтэй юм. Энийгээ хийе, хүлээн зөвшөөрч байна. Үнэхээр хүний үндсэн эрхийг зөрчсөн байна гээд Цэц шийдвэрээ гаргачихвал бид нар тэр шийдвэрт хүндэтгэлтэй хандана гэж хэлж байгаа байхгүй юу. Энэ бол маш том ололт. Энэ бололцоог бид нар нийгмээрээ, хууль тогтоох дээд байгууллага, та бид нар энэ бололцоог алдаж болохгүй. Ер нь.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууна.

**Ц.Сандаг-Очир:** Би хуулийн төслийг дэмжиж байгаа. Гэхдээ бас тодруулах зүйлүүд байна.

5 дугаар зүйл дээр 5.2.1 Цэцийн гишүүнээр томилохыг хориглоно гээд төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн гээд. 65. Томилох үедээ 65 хүрээгүй л байх ёстой. Гэхдээ өнгөрсөн хугацаанд бас насны хязгаар хэтэрчхээд хуулиар зохицуулагдаагүй ингээд явсан хууль зөрчиж байсан тохиолдол гарч байсан. Томилох үед нь насны хязгаар хүрээгүй, тэгээд бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй байхад насны хязгаар хүрчихсэн тохиолдолд яах юм? Энэ бас нэг хуулийн цоорхой үүсдэг юм байна лээ.



Энийг тодорхой болгож өгөхгүй юм уу гэж. Ингэж асууя.

Хоёрт, 19.2 дээр Цэцийн гишүүний хариуцлага дээр энэ 3 хууль буюу Төрийн албаны хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх. Энэ 3 хуулийн холбогдох үүрэг, хориглолт хязгаарыг л дагаж мөрдөнө гэсэн ингэж. Заавал энэ 3 хуулийг, бусад Цэцийн гишүүд чинь ер нь бүх хуулийг л дагаж мөрдөх ёстой биз дээ. Энэ 3 хуулийг заавал ингэж тодорхойлж ингэж үүрэгжүүлж байгаа нь ямар учиртай юм бэ гэдгийг хоёрт асууя.

Гуравт, энэ үнэхээр хүний эрхийг хамгаалах, хангах чиглэлээр маш том нэг дэвшил гарч байгаа гэж би хувьдаа ойлгож байгаа. Иргэн хүн бас Цэцээр өөрийнхөө Үндсэн хуулиар олгогдсон асуудлаа шийдүүлэх нэг бололцоо, боломж гарч ирж байна гэж харж байгаа.

Тэгвэл 21.1 дээр Цэцийн дарга, гишүүнийг эгүүлэн татах асуудал. Цэцийн, дарга гишүүн хууль зөрчвөл, Эрүүгийн хууль гээгүй шүү. Хууль зөрчвөл, бүх хууль зөрчсөн тохиолдолд энэ нь нотлогдоод баримтлаад явал эргүүлэн татах асуудлыг Цэц дээрээ яригдах нь байна шүү дээ. Тэгвэл өнгөрсөн хугацаанд ёс зүйн асуудлууд Үндсэн хуулийн цэцийн гишүүд их айхтар Эрүүгийн хуульд гэдэг юм уу, Авлигын хуульд холбогдоод явах асуудал ховор байх. Ховор байх.

Харин жил дараалан Цэцийн гишүүдийн ёс зүйгүй гаргаж байгаа үйлдлүүд гарч байгааг та бүгд мэдэж байгаа шүү дээ. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй, ёс зүйн хариуцлага хүлээлгэх асуудлууд. Энэ чинь өөрөө төр. Монгол төрийн нэг институт. Тэгээд энийг дагаад төрд итгэх иргэдийн итгэл алдарч байгаа. Ноднин жил Цэцийн гишүүн онгоцон дотор ямар асуудал боллоо. Саяхан л ажлын байран дээр яаж

архи дарс хэрэглээд явж байна гээд ингээд. Энэ бол төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүйн асуудал. Энэ тохиолдол хэвээрээ хадгалагдаад үлдэж байна. Ямар ч хариуцлага хүлээхгүй нь. Энэ тохиолдолд. Эргүүлэн татагдах асуудал хөндөгдөхгүй байна.

Гэхдээ өөр ямар нэгэн хариуцлагын асуудал байхгүй юм уу? Захиргааны хариуцлага, ёс зүйн хариуцлага хүлээлгэх асуудал энэ ёс зүйн алдаа, зөрчил, дутагдал гаргадаг дээр. Бид ноднин Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг баталсан. Бат-Эрдэнэ аварга маань ажлын хэсгийн ахлагч. Баттөмөр ах эд нар. Тэгээд төрийн дунд шатынх нь төрийн захиргааны албан тушаалтнууд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль яриад байдаг. Харин Цэцийн гишүүдээр ёс зүйн асуудал зөрчил, дутагдал гаргавал яах юм бэ? Энэ чинь эсрэгээрээ бараг Эрүүгийн хууль, Авлигын хуульд холбогдсоноосоо илүү төрийн, иргэдийн уур бухимдлыг хүргэсэн асуудлууд үүсээд байна шүү дээ. Энэ дээр энэ хуулиар ямар зохицуулалтыг хийж өгсөн бэ гэдгийг асууя.

Гуравт нь зөвхөн Цэцийн гишүүдээс гадна Цэцэд ажиллаж байгаа туслах ажилтнууд байна. Энэ ажилтнуудын цалин хангамжийн асуудлууд бид нар ноднин шүүх, шүүхийн туслахуудын ажлын албанд ажиллаж байгаа улсуудын цалин хангамжийн асуудлыг нэмэгдүүлсэн. Энд ажиллаж байгаа албан тушаалтнуудын.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариултаа бэлдэж байх хооронд мэндчилгээ дэвшүүлье.

Өнөөдөр Наурызын баярын өдөр.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, ард иргэд ээ,

Өнөөдөр урин хавар айлчлан ирж, өдөр, шөнө тэнцсэн өдөр тохиож нарны баяр, хаврын баярыг манай улсад өргөн тэмдэглэн өнгөрүүлж байна. Наурыз хэмээх энэ хаврын баяр нь Казах түмний төдийгүй хүн төрөлхтний баяр билээ.

Тиймээс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 64 дэх хуралдаанаас олон улсын баяр хэмээн албан ёсоор баталж, ЮНЕСКО-ын дэлхийн халдашгүй соёлын өвд бүртгэн тэмдэглэдэг энэхүү баярыг дэлхийн олон оронд ёслол төгөлдөр тэмдэглэж байна.

Манай Улсын Их Хурлын дарга Занданшатар мөн казах түмэнд өөрийн биеэр баяр хүргэхээр Баян-Өлгий аймгийг зорьсон байгаа. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Тилиханы Аубакир, Буланы Бейсен, Хавдисламын Баделхан болон ажил хичээнгүй казах түмэндээ энэ сайхан нарны баяр, Наурызын баярын мэндчилгээг дэвшүүлж эрх чөлөөт Монгол эх орондоо аз жаргалаар бялхан амьдарч, ажил үйлсэд нь амжилт бүтээлээр цалгиж, Алтайн бүргэд мэт хийморьтой байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Одоо Мөнх-Оргил гишүүн хариулах уу?

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ төрийн алба хаших дээд насны хязгаар хүрээгүй байхад томилж болно. Таны асууж байгаа асуулт бол томилогдоод явж байх хооронд дээд насны хязгаар хүрчихлээ шүү дээ? Тэр яах вэ гэдэг асуудал гарч байгаа юм. Тэрэнд Үндсэн хуулиа л баримтална. Үндсэн хууль бол Цэцийн гишүүнийг 6 жилээр томилно л гэж байгаа юм.

Тэгэхээр тэр хүн бүүр томилох дээд насны хязгаартаа тулчхаад 64-тэй томилогдохыг гэж бодъё тийм үү? Тэгвэл Үндсэн хуульд заасан 6 жилээ баримтлаад л тэр хүн 70 нас хүрээд л тэтгэвэртээ гарна л гэсэн үг. Тэрнээс

биш 64-тэй томилчихоод жил ажиллаж байсан ч өө та 65 хүрчихлээ төрийн алба хаах дээд насны хязгаар хүрчихлээ гээд тэр хүнийг албан тушаалаас нь чөлөөлчих юм бол бид нар Цэцийн гишүүнийг 6 жилээр томилно гэсэн Үндсэн хуулийнхаа шууд заалттай зөрчилдчихэж байгаа байхгүй юу. Тэрэнд нь уялдуулж байгаа юм.

Тэр 19.2-т цөөхөн хэдэн хууль заачихсан байна шүү дээ гэж байгаа юм. Энэ бол Цэцийн гишүүнийх нь хувьд онцгой анхааруулж байгаа л заалтууд байхгүй юу. Яг Цэцийн гишүүн төрийн албан хаагчийнх нь хувьд. Иргэн хүний хувьд тэр чинь мэдээж захиргааны бусад хуулиуд, тэгээд л нөгөө Зөрчлийн хууль, Эрүүгийн хууль, ямар л хууль байдаг юм замын хөдөлгөөний дүрэм, бүх юмаа дагаад л явна шүү дээ. Тэр бол Цэцийн гишүүн гэдэгт нь тодруулахгүйгээр явж байгаа байхгүй юу.

Тэр ёс зүйн хариуцлага гээд би түрүүн тайлбарлаж хэлж байсан тээ? Одоо хүчин төгөлдөр хувилж байгаа хуулиар гэмт хэрэг үйлдвэл л хариуцлага хүлээж байна гэж. Тэгэхлээр энийг бид нар өргөжүүлээд, хариуцлагыг нь өндөржүүлээд хууль зөрчүүл гэж. Хууль зөрчүүл гэдэг нь өөрөө Үндсэн хуулийн заалт байхгүй юу. Бүх төрлийн хууль зөрчвөл гэж.

Ёс зүйн хариуцлага яах юм бэ гэхлээр Сандаг-Очир гишүүн ээ, энэ чинь төрийн албан хаагч чинь нийт Төрийн албаныхаа хуулиар л явж байгаа шүү дээ. Төрийн албаны зөвлөлийн дэргэд чинь Ёс зүйн хороо байгаа шүү дээ. Та бид хоёр ч гэсэн адилхан шүү дээ. Улсын Их Хурлын дэргэд Ёс зүйн хороотой, Төрийн албаны зөвлөл дээр Ёс зүйн хороотой. Тэр яамны тамгын газрын ажилтан байсан ч гэсэн тэр Ёс зүйн хороондоо л захирагдаад л, ёс зүйн зөрчил гаргасан лтэр Төрийн албаны зөвлөл нь шийдээд сахилга, шийтгэл онооно.

Тэгэхлээр тэн дээр Цэцийн гишүүдэд бид нар илүү нөхцөл, бололцоо олгоод л хариуцлага тооцохгүй болгож байгаа юм бол ерөөсөө байхгүй. Нэгхэн асуудал байгаа юм. Цэцийн гишүүнд хариуцлага тооцох нэрээр Цэцийн гишүүний үйл ажиллагаанд, гарах шийдвэрт нь нөлөөлөх бололцоо нь илүү байгаа байхгүй юу. Илүү байгаа байхгүй юу. Чи тэнд архи ууж байсан, чи тэнд мөрийтэй тоглож байсан, чи тэр янз янзын юм хийсэн гэж дарамталж байгаад одоо энэ шийдвэрийг ингээж гарга гэж шахах эрсдэл нь илүү өндөр. Яагаад гэвэл энэ чинь есүүлхнээ, гаргаж байгаа шийдвэрүүд нь дандаа Үндсэн хуулийн заалттай, төрийн тогтолцоотой холбоотой, улс төрийн өндөр агуулгатай шийдвэрүүд гаргадаг учраас бас тодорхой хэмжээний хамгаалалтад байх ёстой. Тийм ч учраас энэ хуульд бид нар тэр Цэцийн гиш.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууна.

**Т.Доржханд:** Баярлалаа. Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байна. Бид нар нөгөө парламентын аргачлалыг бэхжүүлэх зорилгоор сая Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийгдсэн. Тэгээд маш олон бас ийм тогтолцооны өөрчлөлтүүдийг бас хийх шаардлага байна.

Тэгэхлээр энэ өөрчлөлтийг бас ингээд тов тодорхой шийдвэр гаргах процесс дээр Үндсэн хуулийн цэц бол үнэхээр оролцоо нь өндөр юм билээ. Тэгэхлээр үүнийгээ энэ хаврын чуулган дээрээ багтаагаад энэ Үндсэн хуулийнхаа цэцийн асуудлыг тодорхой болгох нь зүйтэй байгаа юм. Энийг дэмжиж байгаа юм. Тэгэхдээ тодорхой хоёр, гурван асуудал байна.

Нэгдүгээрт, энэ цэцийн гишүүнийг зөвхөн 1 удаа 6 жилээр сонгоно гээд орхичих нь өөрөө зөв үү? Америкийн Нэгдсэн Улсад тухайлбал энэ супрем

корт /Supreme Court/ гэж ярьдаг шүү дээ тээ. Шийдвэр гаргах эрх бүхий тэр шүүгч нь АНУ-ын хамгийн эрх мэдэлтэй Ерөнхийлөгчийн урд талдаа сууж байгаад асуудлаа тавиад хууль зөрчсөн бол импичмент буюу албан үүргээс нь чөлөөлөх хүртэл шийдвэр гаргаж байгаа шүү дээ. Цаана нь юу байна гээд тэгэхлээр бүх насаараа энэ хүмүүс томилогддог үр дүнд нь ямар нэгэн улс төрч эрх мэдэлтэй, эд хөрөнгөтэй хүмүүсээс үл хамааран шийдвэрээ гаргаж байгаад л энэ Америкийн ардчиллын давуу тал байгаа юм аа л гэж америкчууд ярьж байгаа. Гэтэл манайд тийм юм байхгүй байгаа.

Тэгэхлээр энэ яагаад 6 жил гэдгээ, та нар энийгээ өшөө сунгая гэсэн байдлаар оруулж ирж болоогүй юм уу? 12 жил, эсвэл бүх насаар нь ч гэдэг юм уу? Энэ дээр хариулт авмаар байна.

Хоёрдугаарх нь энэ 9 Цэцийн гишүүнийг 3 институтээс санал болгоод тэгээд Улсын Их Хурал шийдээд байгаа шүү дээ тийм биз? Үүнийг өшөө хараат бус байдлаар оруулж ирэх тийм тогтолцооны асуудлаар бас санал орж ирж байгаа зүйл байна уу, үгүй юү? Хэн нэгэн шийдвэр гаргадаг эрх мэдэлтэй Ерөнхийлөгч биш, парламент биш Засгийн газар биш, тэндээсээ яг сонгон шалгаруулалт яваад хараат бусаар ингээд томилогддог, томилохыг нь парламент хийдэг нэг ийм тогтолцоог бас бодож үзсэн юм байна уу, үгүй юү? Санал тэгж орж ирж байгаа юу?

Гуравдугаарх зүйл нь болохлоор сая яах вэ Үндсэн хуулийн цэц дээр Улсын Их Хурлын гишүүний хувиар бас энэ нэлээн их явсан, ярьсан. Энд бол маш олон мундаг онолын хүмүүс бас байна л даа. Мэдээж шүүмжлэх зүйлүүд байж л байна. Гэхдээ итгэл үнэмшил байна. Тэр нь юу вэ гэхлээр мэргэжлийн хүмүүс тэнд бас байна. Ялангуяа сүүлд орсон залуучууд мундаг байна лээ. Тэгээд энэ хүмүүс маань цаашаагаа нөгөө философийн асуудал руу, яг зөвхөн энэ

Үндсэн хуулийн хуулийн хүрээнд биш цаашаа онолын шүүх байгуулах, цаашаа тэнд маргаан мэтгэлцээнээ хийдэг. Тэгээд саналаа бас Улсын Их Хурал руу оруулж ирэх тэр боломжийг нээж өгмөөр санагдсан л даа. Тэгж байж нөгөө энэ Үндсэн хуулийн цэц яг л өөрийнхөө агуулгаараа явах юм байна гэдэг ийм ойлголт надад байгаа. Яг энэ чиглэлээр тэр боломжийг нь нээж өгсөн зохицуулалт энэ дээр орж ирсэн байна уу, үгүй байна уу? Энэ дээр бас та саналаа өгмөөр байна.

Гуравдугаарт, энэ хүний эрхийн асуудлыг их өндөр түвшинд аваачаад, цаашаагаа Үндсэн хуулийн цэцийн түвшинд бас эцэслэн шийдвэрлэдэг байна гэдэг энэ зохицуулалт зөв. Дэлхий нийт энэ чиглэлээр ингээд явж байгаа. Явж явж тэгээд л Үндсэн хууль чинь тэгээд л хүний эрхийн зохицуулалтаасаа л эхэлж байгаа шүү дээ.

Тэгэхлээр парламентын ардчилалтай ардчилсан улсын хувьд энэ бол онцгой анхаарах зүйл. Ганцхан асуулт нь юу байна вэ гээд тэгэхлээр нөгөө хуулиараа бид нар чинь шүүхийн шийдвэр эцсийнх байна гэхчхэн байдаг. Түүнийг нь даваад Үндсэн хуулийн цэц бас үүнийг даваад шийдэх тэр боломж, бололцоо нь ямар байгаа юм бэ? Болно гэж тооцож байгаа юм уу? Ямар байдлаар зохицуулж байгаа юм? Яг хүний эрхтэй холбоотой маш олон асуудлууд Цэц рүү яваад ирэх болохлоор тэр ачааллыг нь яаж харж байгаа юм бэ? Тэгээд яг тэндээ шийдвэр гаргахдаа, зөвхөн энэ хэсэг дээрээ ингээд улс төрийн үйл ажиллагаа, тэгээд өөр өөрсдөө илэрхийлж байгаа ямар нэгэн ацтай холбоотой

**С.Одонтуяа:** Хууль санаачлагч Мөнх-Оргил гишүүн хариулна.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Тэр үндсэн эрхийн маргаан шүүхээр шийдвэрлэж байгаа нь шүүхийн шийдвэр эцсийнх гэдэг заалттай зөрчилдөж

байгаа юм биш үү гэдэг асуултаас хариултаа эхэлье.

Үндсэн хуулийн цэцээр шүүхийн бүх шатаар яваад, үндсэн эрх нь зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэн Цэцэд өргөдөл гаргаад, Цэц үнэхээр үндсэн эрх нь зөрчигдсөн гэж үзэх юм бол, жишээ нь, Германд, бусад орнуудад Дээд шүүхийнхээ шүүхийн шийдвэрийг хүчингүй болгочхож байгаа юм. Манайд тийм бололцоо байхгүй.

Яагаад гэвэл Үндсэн хууль дээр Дээд шүүхийн шийдвэр эцсийнх гээд хэлчихсэн байхгүй юу. Тэгэхлээр бид нар түрүүний миний Ганбаатар гишүүнд уншиж танилцуулаад байсан Үндсэн хуулийн 50.1.3-ын заалт буюу хууль, түүнд заасан эрх, эрх чөлөө хамгаалах асуудлаар Үндсэн хуулийн цэц Дээд шүүхэд асуудал оруулж хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ, болно гэдэг тэр заалтыг ашиглаад Цэц асуудал оруулна. Дээд шүүх эцэслэн шийдвэрлэнэ. Цэц өөрөө шийдвэрлэхгүй гэсэн үг.

Давж заалдах шатын шүүхийн шийдвэр байх юм бол Дээд шүүх давж заалдах шатын шүүх рүү нь дахин илэрсэн нөхцөл байдлаар энэ асуудлыг шийд. Цэц ингэж шийдсэн байна шүү. Цэцийн энэ дүгнэлтийг харгалзаж үзээд зөрчилгүй болгоод асуудлаа шийдгээд давж заалдах шатын шүүх рүү өгнө. Өөрийнх нь шийдвэр байх юм бол Үндсэн хуульд заасан Дээд шүүх өөрийнхөө шийдвэрийг эргээж харна гэдэг заалт байгаа шүү дээ. Тэрнийхээ дагуу шийднэ.

Тэгэхлээр энэ дээр Үндсэн хуулийн зөрчил гарахгүй. Ачаалал бол их болно. Ачаалал бол маш их болно. Энэ хуулийн явцад ингээд судалж байхад ер нь энэ анх 92 онд Үндсэн хууль батлагдаад л энэ үндсэн эрхийн маргааныг Цэц хэлэлцэх юм уу, үгүй юү гэдэг асуудал хуульчдын дунд өрнөсөн байхгүй юу. 32 жил маргаж байгаа юм. Тэгээд тэнд бол, тэр үед үгүй ээ, үгүй ерөөсөө энийг бол ингээд дөнгөж Цэц байгуулагдлаа, дөнгөж шинэ

шүүхтэй боллоо, одоо ачаалал нь дийлдэхгүй гэсээр байгаад үүнийг 32 жил хойшлуулж байгаа юм.

Бусад орнуудын жишээ, ер нь туршлагыг хараад байхад Герман ер нь 20-30 жил наана, цаанатай болж байж энэ тэнцвэрээ олсон байгаа юм. Туркүүд бол би түрүүн хэлсэн 5-10 жил болж байна гэж байгаа юм. Тэгэхдээ одоо тэнцвэрээ олчихлоо. Одоо энэ зөв гэдэг нь харагдлаа гээд. Тэгэхлээр манайд бас хэдэн жил бужигнана. Цэцийн ачаалал маш их нэмэгдэнэ. Хүн болгон тийшээ асуудлаа авч очно. Тэрний зохицуулах бид нар зохицуулалтуудыг нь, шүүлтүүрүүдийг нь энд хийгээд өгчихсөн. Цэц нэлээн ачаалалтай ажиллана. Нийт үйл ажиллагааных нь 90 хувь энэ үндсэн эрхийн маргаан руу орно. Одоо 100 хувь төрийн тогтолцооны асуудал, хууль Үндсэн хуультай нийцэж байна уу гэдэг хийсвэр хяналт л хийж байгаа шүү дээ. Хувь хүний асуудал бол тэнд үндсэндээ яригдахгүй. Шүүхийн шийдвэр яригдахгүй. Тэгэхлээр энэ их том өөрчлөлт гарна.

Нэг удаа 6 жилээр гэдгийг өөрчилж болохгүй юм уу гэж байна. Энэ Үндсэн хуулийн заалттай юм. 65.1 дээр. Гэхдээ нэг удаа 6 жилээр сонгоно гэххэд дахиж сонгож болох юм уу, нэгхэн удаа юм уу.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Нэмж хариулъя Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Тэр 6 жилийн хугацаагаар томилно гэххэд араас нь хэдэн удаа дахиж сонгож болох юм, 1 удаа юм уу, ахиж сонгохгүй юм уу гэдэг заалт ерөөсөө хоосон орхичихсон учраас асуудал, маргаан үүсээд байгаа байхгүй юу. Тэгэхлээр үүнийг одоо бид нар юу гэж оруулж ирж байгаа вэ гэхлээр 1 удаа 6 жилээр сонголоо, дахиад 1 л удаа улируулъя гэж байгаа юм. 1 л удаа улируулъя ,12 жил болгоё. Энэ тэгэхдээ өөрөө их маргаантай асуудал.

Яагаад гэвэл энэ асуудлаар Цэц дүгнэлт гаргачихсан юм. Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацааг дахиж ганцхан удаагаар сонгож байгаа нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн байна. Үндсэн хуульд 1 л удаа сонгоно гэсэн үг байхгүй байна. 1 л удаа улируулан сонгоно гэсэн үг байхгүй байна.

Тийм учраас Цэцийн гишүүнийг хэдэн л бол хэдэн удаа сонгож болно гэж бид ойлгож байна гээд Цэцийн дүгнэлт гарчихсан байхгүй юу. Тэгэхдээ бид нар энэ хуулийг батлаад явуулахад Цэц энэ асуудлыг дахиад хэлэлцэнэ. Тэгээд ямар шийдвэр гарах юм бүү мэд. Магадгүй дахиад Үндсэн хууль зөрчлөө гээд шийдвэр гаргах юм уу.

Яагаад ингээд нэгхэн удаа дахиж улируулъя гээд байгаа юм бэ гэхлээр хараат бус байдалд нь нөлөөлөөд байгаа юм. Нөгөөдөх чинь дахиж томилогдохын тулд, дахиж томилолт авахын тулд дахиж нөгөө нэр дэвшүүлдэг хүмүүсээсээ итгэлийг нь хүлээхийн тулд дохио зангаагаар ажиллах. Үндсэндээ том аюул байгаа байхгүй юу.

Тийм ч учраас та санаж байгаа бол 19 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад бид нар 2 хувилбар ярьж байсан юм шүү дээ. Цэцийн гишүүнийг насан турш нь томилгё, эсвэл Цэцийн гишүүнийг 1 удаа 9 жилээр томилгё гээд. Тэгээд ингээд тал талаасаа ярилцаад харамсалтай нь зөвшилцөлд хүрч чадаагүй байхгүй юу. Одоо энэ байгаа Үндсэн хуулийнхаа зохицуулалтаар явъя гээд цаашаа явсан юм.

Гурван институт гурав, гурван хүнийг нэр дэвшүүлэхдээ хараат бус байх уу гэж. Энэ дээр хараат бус байлгах гээд бид нар нэлээн их өөрчлөлтүүд оруулж байна гэж би бол одоо аминдаа бодоод байгаа юм. Жишээ нь, Улсын Их Хурал дотор одоо яадаг вэ гэхлээр Байнгын хороон дээр Улсын Их Хурлын дарга нэр оруулаад л, Байнгын хороо олонхоороо

шийдээд л нэгдсэн хуралдаан дээр олонхоороо шийдчихээд явчхаад байна шүү дээ. Энийг бид нар яаж өөрчлөхийг санал оруулж байгаа вэ гэхлээр олонх цөөнх пропорцоороо хувь тэнцүүлэн оролцсон ажлын хэсэг байгуулъя. Аль нь ч олонх, цөөнх болоогүй бол Улсын Их Хуралд суу.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Доржханд гишүүн тодруулга 1 минут.

**Т.Доржханд:** Зарчимтай нь санал нэг байна Мөнх-Оргил гишүүн ээ. Одоо ингээд хамааралгүй байлгамаар байна шүү дээ улс төрөөс. Тэгээд Үндсэн хуулийн цэц чинь яг ардчиллын ийм эмзэг байгаа, дэлхий дээр ийм байгаа үед бид нар парламентын ардчиллыг бэхжүүлэх гэж ямар их хичээж байгаа билээ.

Цааидаа ч гэсэн сорилт байгаад байдаг. Яг энэ тал дээрээ ингээд байдаг. Монгол Улсын тусгаар тогтнол, Монгол Улсын ардчиллын талд байдаг ийм Үндсэн хуулийн цэцтэй баймаар байгаа байхгүй юу. Энд итгэл үнэмшилтэй баймаар байна. Итгэл үнэмшилийг нь бий болгохын тулд ямар нэгэн улс төрийн намаас, эрх мэдэлтэй хүнээс хамааралгүй баймаар байна. Хамааралгүй байхын тулд энэ хугацаа нь урт баймаар байна. Тантай 100 хувь санал нэг байна. Нэг л удаа бид нар сонгодог баймаар байгаа байхгүй юу. Хоёр удаа сонгохын тулд хэн нэгэн даргыг дагаж гүйдэггүй баймаар байна. Тэгэхлээр Үндсэн хуулийн асуудал гэж ойлголоо. Тэрийг цаашаа бид нар нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг гаргаж ирэх юм байна. Одоо нөгөө философийн асуудал дээр та саналаа өгөөч. Одоо энэ Үндсэн хуулийн цэц гэдэг чинь баахан ингээд мундаг философийн, онолын ийм хүмүүс цуглачхаад байна шүү дээ.

**С.Одонтуяа:** Хариулт Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Доржханд гишүүний тэр Цэцийн шийдвэрийн

үндэслэлийн асуудлаар хариулт өгч амжсангүй, цаг хүрсэнгүй. Тэгээд энэ дээр арай жоохон дэлгэрэнгүй ярьчихъя. Бид нар Цэцийг их шүүмжилдэг л дээ. Би ч гэсэн байнгын шүүмжилж байна. Үгүй ээ, наадах чинь яг ямар үндэслэлээр шийдвэр гаргаж байгаа юм бэ гээд л. Одоо бол Цэцийн дүгнэлтийг та нар бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Нэхэмжлэгч ингэж хэлэв гээд л 5, 6 хуудас нөгөө нэхэмжлэгчийн хэлсэн бүх юмыг нь ингээд соруу, past хийчихдэг. Улсын Их Хурал ингэж хэлэв гээд. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн юмыг ярьж. Тэгээд сүүлд нь Үндсэн хуулийн тэр заалтыг үндэслэж Үндсэн хууль зөрчсөн гэж үзэв үү, эсвэл зөрчөөгүй гэж үзэв үү гээд л Цэцийн дүгнэлт гарчихдаг байхгүй юу. Энийг шүүмжилдэг. Энэ дээр ингээд Цэцийн гишүүдтэй ярихлаар 2 зовлон байгаа юм. Бид нар өөрсдөө үүнийгээ энэ хууль дээрээ засахгүй бол болохгүй юм байна лээ.

Яадаг вэ гэхлээр нэгдүгээрт бид нар маргаан үүсгэсний дараа 30 хоногийн дотор асуудал шийд гээд Цэцийг шахчхаж байгаа байхгүй юу. 30 хоногийн дотор. Гэтэл жишээ нь, Цэц дээр байгаа бие төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцоод явж байгаа нэг асуудал байгаа юм. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг Цэц хянах эрхтэй юм уу, үгүй юү гэдэг асуудал байгаа байхгүй юу. Агуулгын хувьд. Энэ чинь өөрөө аягүй том философийн асуудал болчихоод байгаа байхгүй юу. Хуулийн, улс төрийн асуудлаасаа илүү төр эрх барих нь хаана байгаа юм, хууль тогтоох нь хаана байгаа юм, ард түмний төлөөлөл нь аль нь юм, яаж үүнийгээ зохицуулах юм гээд аягүй том асуудал байдаг. Үүнийг 30 хоногийн дотор бид нар шийд гээд шахчихдаг байхгүй юу. Нэг шахалт.

Нөгөө шахалт нь болохлоор хуралдсан л бол ерөөсөө тэр өдөртөө шийдвэрээ гарга. Тасралтгүй хуралдаж байгаад шийдвэрээ гарга. Шийдвэрээ

гаргачихсан бол 24 цагийн дотор Улсын Их Хурал шийдвэрээ явуул гээд шахчихдаг. Тэгэхлээр нөгөөдүүл чинь 30 хоногт нэг шахагдаж шийдвэр гаргана, хуралдаад 24 цагийн дотор шахагдаж нэг шийдвэрээ гаргана, тэгэнгүүтээ нөгөө яриад байгаа том үндэслэлээ бичиж амжихгүйгээр ийм юм явуулчхаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр одоо энэ хууль дээр бид нар юу гэж зааж байгаа вэ гэхлээр нэгдүгээрт маргаан үүсгэсэн бол 90 хоногийн дотор шийд, үнэхээр ээдрээтэй байх юм бол дахиад 90 хоногоор сунга. Ингээд л 180 хоногийн дотор энэ асуудлаа шийд гэж хугацааг нь нэгдүгээрт тавьж өгч байгаа юм.

Хоёрдугаарт, шийдвэрээ гарга, амаар гарга. Харин бичиг.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Та тодруулах минуутуудаа авчихсан. Одоо 1 минут нэмж өгье .

**Ц.Мөнх-Оргил:** Зөв зөв. Тэгэхлээр миний асуугаад байгаа юм нь юу байна гээд тэгэхлээр хугацаа ингээд тавьж өгч байгаа юм байна ойлголоо. Гэхдээ тэндээс нөгөө яг Үндсэн хуулийн чиглэлээр мэргэшсэн хүмүүс маань яг онолынхоо маргааныг хийгээд, тэгээд Улсын Их Хуралд бид нар яг ингэж үзэх нь зүйтэй байна гэдэг зүйл зөвлөмж, саналаа өгмөөр байгаа байхгүй юу. Өнөөдрийнх шиг ингээд хүрч ирээд ингээд амандаа бувтнаад аягүй хурдан уншаад явчихдаггүй баймаар байгаа байхгүй юу тухайлбал. Тэгээд л баахан хэдэн хуулийн заалт ингээд л уншаад явчихдаг л баймааргүй байгаа юм. Эсрэгээрээ тэр нь ингээд илүү ингээд мэдлэг дээр тулгуурласан, онол дээр тулгуурласан, судалгаан дээр тулгуурласан тэр чинь институт шүү дээ. Тэгээд Үндсэн хуулиа хамгаалж байгаа энэ бүтцийн байгууллагын хувьд яг тэр чиглэлээрээ өөрсдийнхөө судалгааны ажил дээрээ үндэслээд зөвлөмжөө өгдөг баймаар байгаа юм. Тэгээд онолын маргаанаа бид нар очоод хийдэг байна. 5 цаг хийхэд тэр

хамгийн сонирхолтой хэсэг тэнд байгаа байхгүй юу.

Гэтэл тэр хэсгийг нь бид нар ингээд хойшоо тавиад,м Үндсэн хууль бол болж бүтэхгүй энэ зүгээр ингээд л манаач байх ёстой гэсэн байдлаар хязгаарлахаар энэ хөгжлийнх нь асуудал, институтийн хөгжлийн асуудал нь орхигдчихоод байгаа.

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ нэгдүгээрт цаг хугацааны асуудал байгаа. Энэ дээр бид нар хуулиараа ингээд асуудлыг шийдчихнэ.

Хоёрдугаарт бидний томилж явж байгаа хүмүүс тэнд очоод яг таны саяын хэлж байгаа шиг тэр нарийн үндэслэл гаргаж ирж чадаж байна уу, үгүй юу? Энэ дээр бид нар анхаармаар байгаа юм. Би тантай санал нэг байна. Сүүлийн үед Улсын Их Хурлаас томилогдож очиж байгаа Цэцийн гишүүдийн онолын болон практик мэдлэгийн түвшин өндөр байгаа учраас сүүлийн үеийн гаргаж байгаа шийдвэр харьцангуй үндэслэлтэйгээ орж ирээд байгаа шүү дээ. Шинжээч томилж байгаа.

Гэхдээ энэ дээр асуудал гендээ ч гоондоо ч байгаа юм. Сая жишээ нь, Цэцийн гишүүн Баясгалан орж ирээд Цэцийн дүгнэлтийг танилцуулж байна. Тэр Баясгалангийн ярьж байгааг би сонсох байтугай Баясгалан ярьж байгаа юмаа сонсох бололцоогүйгээр энэ заал шуугьж байгаа байхгүй юу.

Тэгээд бид нар өөрөө бас Цэцдээ хүндэтгэлгүй ханддаг байхгүй юу. Энэ бид нарт ч гэсэн асуудал байгаа. Бид нар ч гэсэн энэ хууль Үндсэн хууль зөрчөөгүй байна гэж үндэслэлээ гаргаж өгөхдөө Цэцээс нэхээд байгаа тэр онолын өндөр түвшиний тайлбарыг бид нар бас гаргаж өгч чаддаггүй байхгүй юу. Их Хурал баталчихсан бол ерөөсөө ямар ч байсан гэсэн энэ Үндсэн хууль. зөрчөөгүй гээд л

өгөөд л үзье. Тэнд тэгээд яах нь вэ харъя гээд л ийм маягтай хандаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр асуудал гээндээ ч гоондоо ч байгаа. Шаардлагыг нь одоо бид нар тавьж байгаа юм байна.

Ер нь энэ дээр тэгэхдээ Их Хурлын дарга аа ийм зовлонтой асуудал байгаа юм. Цэц байна шүү дээ шүүх байхгүй юу. Шүүх хаана ч, хэнд ч шийдвэрээ тайлбарлах ёсгүй байхгүй юу. Зөвлөмж бол өгнө. Танайх ийм хуулиа ингээд ингээд баталчихсан чинь ийм ийм юм зөрчлөө, ийм ийм үндэслэлээр, ийм ийм онолоор гарчихсан байна шүү тийм учраас дараагийн хууль дээр энийг анхаар гээд зөвлөмж өгч болох байхгүй юу. Тэрнээс биш Цэцийн гаргасан шийдвэрийг энд бид нар авчраад зөв, бурууг нь яриад чи тэгсэн, чи ийм муу, чи тэгвэл авлигач, чи тэгвэл энэ өөрөө Цэцдээ бид нар хүндэтгэлгүй хандаж байгаа, шүүхдээ хүндэтгэлгүй хандаж байгаа. Та нар бодоод үз ямар улсын бид нар Улсын дээд шүүхийн шүүгч нарыг энд авчраад шүүхийн шийдвэрийг нь бид нар зөв, бурууг нь ялгаад суудаггүйтэй л адилхан байхгүй юу. Тэгэхлээр тэрийг бас.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Тэгээд өмнө нь асуулт асуусан гишүүдийн асуултад миний бас асууя гэж санаж байсан ийм санаанууд давхардаж байна л даа. Би тэгэхээр нэг зүйлийг асууя. Энэ 4 дүгээр бүлэг Цэцийн гишүүний хариуцлага гээд

**С.Одонтуяа:** Та жоохон микрофондоо ойрхон ярих уу? Сонсогдохгүй байна.

**Б.Бат-Эрдэнэ:** 4 дүгээр бүлэг Цэцийн гишүүний хариуцлага, 19 дүгээр зүйл болохоор зэрэг цэцийн гишүүний баримтлах зарчим, хүлээх үүрэг, хориглох хязгаарлах зүйл гээд. Тэгээд энэ

зүйлийг бүхэлд нь үзэх юм бол яг энэ Цэцийн гишүүний хариуцлагатай холбоотой юм төдийлөн тусгагдаагүй байна гэж би хэлэх гээд байгаа юм.

Яагаад гэвэл бид нэг сайн үндэслэл гаргаж авсан шүү дээ. Тэр нь бол ер нь шатны гишүүнийг дээрээс нь шүүрдэнэ. Шатны гишүүнийг доороос нь шүүрдээд хэзээ ч цэвэрлэгддэггүй. Тийм учраас бид Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм энэ хуулийг баталж авна гээд. Энэ 20 оноос хойш 4 жилийн хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа манай Их Хурал энэ КОВИД, дайны бусад энэ хүндрэлтэй үед бүгдээрээ л зүтгэж ингэж ажиллалаа шүү дээ. Тэгээд тэр дотроо бол энэ Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм энэ хууль буюу яг өөрөө өөрсдөдөө хэм хэмжээ тогтоосон энэ шийдвэрийг гаргаж чадсан нь ер нь бусад улс орны парламент ч гэсэн жишиг болохоор ийм гаднаас ирсэн улсууд чинь энийг магтаж хэлж байгаа шүү дээ. Ийм зүйлийг хийсэн.

Тэгэхээр зэрэг үргэлжлүүлээд бид нар төрийн албаны ёс зүйн тухай хуулийг санаачлаад ингээд Их Хурлаар бас батлуулаад, Төрийн албаны зөвлөлийн дэргэд Ёс зүйн том хороо байгуулагдаад ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр зэрэг энэ чинь бид нар Дээд шүүх дэргэдээ Ёс зүйн хороотой тийм ээ? Энэ Цэц маань болохоороо зэрэг энэ хариуцлага гээд ингээд 4 дүгээр бүлэгт Цэцийн гишүүний хариуцлага гээд тавьчихсан боловч яг энэ талаараа би зүйл олж үзэхгүй л байгаад байна л даа. Яах вэ том төрийн албан албаны ёс зүйн тухай дүрмийнхээ дагуу тэр Ёс зүйн том хороо бол дүгнэлт гаргана. Бүгд л тэрэнд хамаарагдана.

Гэхдээ үүнийг илүү хариуцлагажуулах чиглэлээс нь ямар зүйл байгаа юм. Энэ 19.1-д Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, төвийг сахих, хараат бус, бодитой, үндэслэлтэй хандах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг



чамд баримтлал гэж байгаа юм. Яг үүгээр хязгаарлаж байна уу? Энэ дээр жаахан тодруулга авахгүй бол болохгүй байна эсэн ийм санааг л би хэлээд асуух гээд байгаа юм л даа. Үгүй яах вэ янз бүрийн зүйлээр хүнийг хараар бодож болж байна шүү дээ.

Тэгэхээр зэрэг энэ тухай асуудлыг яриагүй. Энэ ашиг сонирхлын зөрчил ямар нэгэн нөлөөллөөс ангид байх талаас нь хариуцлагыг нь чангатгасан ийм зохицуулалт байна уу, үгүй юу гэж? Одоо бүүр санаа амар болсон байна шүү дээ. Миний утсанд жишээлэх юм бол хэн нэгэн дурын хүн элдвээр дайрсан, гүтгэсэн, доромжилсон мессеж бичээд тэрийгээ скрийншот /screenshot/ хийгээд тэгээд Ба аваргын утсанд ийм мессеж хийжээ гэж. Үгүй тэр нь хүний санаанд ормооргүй. Монгол хүний үзэл, ухамсарт байж болохооргүй. Бүүр турж үхсэн хүний удам гэж байгаа юм намайг. Бадмаанямбуугийн хүү Бат-Эрдэнэ гэж байгаа юм. Ингээд тэр Баянбулагтаа тайван нойрс гэдэг чинь юу гэж байгаа юм? Шууд үхүүлж байгаа юм уу, яаж байгаа юм? Тэгээд энэ мэтийн зүйлийг бичээд ингээд явдаг энэ сошиал, энэ нийгмийн харилцаа байдал чинь ер нь хүний хүмүүнлэг ёсноос бүүр хэтэрсэн иймэрхүү байдалтай байгаа юм. Би зүгээр ийм мэтийн зүйлийг хэлээгүй шүү. Энэ ашиг сонирхолтой илт холбоотой элдвийн хулгай худал, авлигал, ашиг сонирхолтой холбоотой ийм юман дээр л энэ төрийн алба нийтийн албанд ажиллаж байгаа хүмүүст хариуцлага чанга байх ёстой гэдэг л ийм хатуу зарчимтай л байгаа.

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ 92 оны Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5.2 дээр ийм л заалт байсан байхгүй юу. Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон бол түүнийг Цэцийн гишүүнээс эргүүлэн татна гээд. Гэмт хэрэг үйлдсэн бол. Одоо бол хууль

зөрчвөл. Хууль дотроо Төрийн албаны тухай, Авлигын хэсэг, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, саяын миний ярьсан, таны саяын эш татсан бүх хуулиуд чинь орж байгаа байхгүй юу. Тэгэхлээр хариуцлага нь хамаагүй эгүүлэн татах үндэслэл нь хамаагүй өргөн болж байна. Хариуцлага нь өөр болж байна, нэмэгдэж байна гэж ойлгох хэрэгтэй.

Ёс зүйтэй холбоотой асуудал бол энэ төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүйн шаардлага Цэцийн гишүүдэд нэг л адил үйлчилнэ шүү дээ. Төрийн албаны тухай хуулиараа, Ашиг сонирхол, Зөрчлийн тухай хуулиараа, Төрийн албаны ёс зүйн тухай хуулиараа тэгээд Төрийн албаны дэргэдэх Ёс зүйн хороо энэ асуудлыг шийдээд л явна.

Хэлэлцэх эсэхээ шийдээд хэдүүлээ цаашаа энэ асуудлыг үргэлжлүүлээд Байнгын хороод дээрээ ярихдаа магадгүй Бат-Эрдэнэ гишүүн энэ Цэц өөрөө дэргэдээ Ёс зүйн хороотой байхыг хуульчилж өгч болж байгаа юм тийм ээ? Хуульчлаад ийм ийм зарчмаар та нар Ёс зүйн хороогоо байгуулаад ингээд ажиллана шүү гэж шаардлага тавьж ажиллаж болно. Ер нь энэ маш товчхон хэлэхэд Улсын Их Хурлын гишүүд Дээд шүүхийн шүүгч нарт тавигдаж байгаа хуулийн, ёс зүйн сахилга хариуцлагын бүх шаардлагууд Цэцийн гишүүдэд адилхан үйлчилнэ. Тэгж л бид нар энэ хуулийг ойлгож томъёолж байгаа юм. Тэгж ойлгогдохгүй дутуу байгаа бол нэмж тодруулахад асуудал байхгүй. Бүгд хүлээн зөвшөөрнө.

**С.Одонтуяа:** Одоо Дашдондогийн Ганбат гишүүн асуултаа асууна.

**Д.Ганбат:** Бид нар дэмжихгүй байгаа юм. Яах вэ дэмжихгүй гэдэг байр сууриа ч илэрхийлээд л явж байгаа. Ер нь яагаад вэ гэхээр энэ чинь яг ээлжит сонгуулийн л өмнө л ингээд Цэцээрээ оролдоод байж болохгүй л дээ. Цэцийнхээ хуулиар. Тэгээд гадна, дотнын нөхцөл ямар байгаа билээ. Ийм тогтвортой бас

нэг ч гэсэн байгууллага муу, сайн ч гэсэн Цэц гээд тэнд байж байна. Ажлаа хийгээд явлаа, 30-аад жил хийчихлээ. Яг одоо ээлжит сонгуулийн өмнө үүгээрээ ингээд оролддог ийм юм байж болохгүй. Тэгээд өмнө ч Үндсэн хуулийн цэцийг та заримдаа шүүх гэж яриад байх шиг байна. Статус нь яг ямар юм? Тэр нь одоохондоо тийм, ийм гээд хэлчихэд хэцүү.

Нөгөө талаар Үндсэн хуулийн цэцээр дамжуулж янз бүрийн сөрөг хүчнээ, мөн янз бүрийн байдлаар хүмүүсийг янз бүрийн байдалд оруулдаг Монголд гарах монголчуудад хэрэгтэй гаргасан, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоосон гаргасан шийдвэрүүдийг тэнд өөрчлүүлж байдаг ийм юмнууд өмнө нь байсан.

Тухайлбал, би 2012-16 оны үед бид нар энэ төмөр замын асуудлыг нэлээн сайн, зөв зүйтэй шийдчихсэн байсан. Олон улсын тэр цариг нь байх ёстой гээд шийдчихсэн ийм байсаар байтал Үндсэн хуулийн цэц дээр аваачиж өөрчлүүлээд л тэгээд л өнөөдөр бид нар маш өндөр үнэтэй ийм импортын бараа хэрэглэх, экспорт ч гэсэн өндөр үнэтэй болчихсон, өрсөлдөх чадвар нь муу, мухар төмөр замтай гэх мэтчилний ийм зүйл байгаа л даа. Тухайн үеийн шийдвэр гаргаж байсан Цэц дээр байсан нөхдүүд дараа нь ямар нэгэн албан тушаал үр хүүхдэдээ аваад өгчихсөн байх ч юм уу ийм байдлууд байдаг.

Тэгэхээр Үндсэн хуулийн нэлээн том өөрчлөлтийг бид нар хийсэн. Тогтолцоондоо бид нар өөрчлөлт оруулсан. Энэ сонгуулийг ч гэсэн бас будилаантуулдаг. Одоо энэ хуулийг баталлаа гэж бодоход хэдийнээс эхэлж хэрэгжих юм? Ямар байдлаар нөлөөлөх юм? Өмнө нь хэд хэдэн удаа өөрчлөлт оруулчихсан. Хууль одоо тогтвортой байх хэрэгтэй л дээ.

Нөгөө талаар энэ бүүр эсрэг юм яриад байх юм. Тэр олон улсын

байгууллага бүх заавар зөвлөгөө өгч байгаа ер нь жишиг хандлагаас хараат бус байхын тулд эсвэл шүүгчийг бүх насаар нь томилдог, эсвэл 1 удаа томилдог сонгодог. Гэтэл энэ 6 жил ажиллана гэдэг чинь хангалттай хугацаа шүү дээ.

Гэтэл тэрийг 2 дахиж сунгана гээд байх юм. Энэ чинь тэр хараат байх нөхцөлийг бүрэн алдагдуулж байгаа. Эсвэл бүх насаар нь байлга, эсвэл тэр 6 жил ч юм уу, 10 жил 1 удаа томилдог ийм л байсан нь дээр л дээ. Энэ нөхцөл, шаардлагыг хангахгүй ийм хуулийг та ингээд оруулж ирээд байх юм. Танаас өөр хэн гэдэг хүн санаачиллаа. Хоёр гишүүн санаачилсан юм уу, хэдэн хүн санаачилсан юм?

Нөгөө талаар тэр Үндсэн хуулийн цэцийн дарга байсан Амарсанаа гуайг маш сайн хуульч гэж боддог. Олон Үндсэн хуулийн цэцийн дарга нар байсан. Энэ хүмүүстэйгээ ярилцаж, заавар зөвлөгөөг нь авч бас ингэж ажилласан уу? Өнөөдөр гэхэд ганцхан танай талаас л яриад байдаг энэ ямар ч байсан 3 намын төлөөлөл байж байна. 2 бүлэг байж байна. Ерөөсөө л ганцхан л Ардын нам байгаа юм шиг, 1 намын дарангуйлалтай юм шиг.

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариултаа хэлье.

**Ц.Мөнх-Оргил:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн жилээр ингээд Цэцээр оролдоод байна гээд байх юм. Тэгээд энэ чинь 32 жил оролдоогүй л байхгүй юу даа Ганбат гишүүн ээ. Тэгээд та өөрөө сая хэлж байна шүү дээ Цэцийн үйл ажиллагаа чинь алдаа дутагдалтай байна, гомдол их байна, янз бүрийн шийдвэр гаргаад байна гээд. Тэгээд энэ нөгөө 32 жил оролдоогүй эрх зүйн орчныг нь сайжруулаагүй, алдаа дутагдлаа засаагүй учраас л ийм байдалтай яваад байна шүү дээ. Тэгээд энэ хууль яах вэ оройтож өргөн барьж байгаа нь миний

буруу байх л даа, манай ажлын хэсгийн буруу байх.

Гэхдээ энэ бид нар хоёр жил хагас, ер нь 3 жил ажиллаж байгаа хууль юм. Тасралтгүй ажиллаж байгаа юм. Энэ хуулийн төслийг боловсруулахад том ажлын дэд хэсэг гарч ажилласан. Энд манай судлаачид, эрдэмтэд, Цэцийн Тамгын газрынхан, зарим Цэцийн гишүүд, Дээд шүүхийн шүүгчид гээд ингээд том бүрэлдэхүүнтэй 24 хүний бүрэлдэхүүнтэй ажлын дэд хэсэг ажиллаж байна. Тэгэхлээр энэ зөвхөн өргөн барьсан нэр нь минийх л болохоос биш, боловсруулсан ажил нь том хамт олны хөдөлмөр байхгүй юу. Тэгэхлээр тэрэнд бас хүндэтгэлтэй хандаарай гэж би танаас хүсэх гэсэн юм.

Цэцийн шийдвэр янз янз гарч байгаа л даа. Заримдаа бүүр арай ч дээ гэмээр шийдвэрүүд ч гарч байгаа, заримдаа овоо шүү дээ гэж шийдвэрүүд гарч байгаа юм. Тэгээд энийг бид нар л томилж явуулсан хүмүүс шүү дээ. Улсын Их Хурал эндээсээ олонхоороо санал болгоод л томилж явуулсан хүмүүс. Тэгэхлээр энэ дээрээ хэдүүлээ өөрсдөө өөрсдөө дүгнэлт хийгээд, энэ томилогдож явуулж байгаа хүмүүстээ тавигдах шаардлага, нэр дэвшүүлж байгаа хүмүүстээ тавигдах шаардлага эд нарыг л бид нар энэ хуулиараа нэлээн чангалж байгаа юм.

Жишээ нь, Дээд шүүхээс одоо энэ хууль хүчин төгөлдөр болсны дараа Дээд шүүхээс нэр дэвшигчид зөвхөн Дээд шүүхийн шүүгчид байна. Одоо 24 шүүгч байгаа шүү дээ. 24-өөсөө 3-ыгаа сонгоод явуулаа гэж байгаа юм. Энэ бол улс төрийн нөлөө байхгүй 3 хүн орж ирнэ. Ойлгомжтой шүү дээ. Улсын Их Хурлаас нэр дэвшүүлж байгаа хүмүүсийг олонх, цөөнхийн тэнцүү төлөөлөл оруулсан олонх, цөөнх байхгүй бол Улсын Их Хуралд суудалтай бүх улс төрийн нам, эвслүүдийн хувь тэнцүүлж байгуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээр нэр дэвшигч нарыг судлаад гуравны хоёрын

саналаар гэж байгаа шүү. Гуравны хоёрын саналаар тэр хүнийг оруулж ир гэж байгаа юм. Энэ дээр хэн нэг нь олонх болчихоод түрэмгийлж тэр Цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх бололцоо байхгүй болгож байгаа байхгүй юу. Нэр дэвшигч нарыг бүгдийг нь хэлэлцүүл гэж байгаа юм, намтар түүхийг нь тавь гэж байгаа юм, санал бодлыг нь ав гэж байгаа юм. Энэ хуулийн шаардлагууд бүгд орж байгаа.

6 жил жилийг дахиад 1 удаа ингээд сунгаад 12 жил болгочоод байх юм гэж байгаа юм. Энэ Үндсэн хуульдаа ерөөсөө 6 жил гээд хэлчихсэн, дахиж хэдэн удаа сонгож болох юм, эсвэл ганцхан удаа сонгох юм уу гэдэг заалт нь ойлгомжгүй байхгүй юу. Тэгэхлээр энэ дээр 1 удаа дахиж улируулж сонгож болно шүү гэж тодруулж өгөхгүй. бол яг таны саяын хэлж байгаагийн чинь эсрэг хэдэн ч удаа энэ хүмүүс чинь дахин сонгогдож болоод байгаа байхгүй юу. 1 удаа, 2 удаа, 3 удаа, 4 удаа, 5 удаа. Тэгээд энийг л хязгаарлаж байгаа юм. 1 удаа сонгоно.

Яагаад 1 удаа сонгож байгаа юм бэ гэхлээр Монгол яг энэ Цэцийн гишүүнээр ажиллах хүн цөөтэй.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Гүйцээж хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Цэцийн гишүүнд тавигдах өндөр шаардлагыг хангаад, тэнд ажиллаад, дадлага туршилага суугаад тэгээд бид нар дөнгөж ажлын дүйтэй болж байхад нь 6 жилээр ингээд халаад байх бидэнд тийм Их Монгол Улсад хүний нөөц байхгүй. Тийм учраас 1 удаа улируулж сунгаад 12 жил ажиллуулаад тэгээд дараагийн хүнээ сонгож байя гэдэг санал оруулж байгаа юм.

Цэцийн өмнө нь ажиллаж байсан дарга нараас санал авсан уу гэж байна. Санал авсан манай ажлын хэсэг зохион байгуулаад Цэцийн дарга нараар

ажиллаж байсан одоо амьд байгаа бүх хүмүүсээс санал авсан. Амарсанаа академичаас авч чадаагүй, утсыг нь би олоогүй. Харамсалтай нь. Бусдаас нь бүгдээс нь санал авсан. Чинбат, Бямбадорж, Жанцан дарга гээд ингээд бүгдээс нь саналыг нь авсан. Тэр хүмүүст санал нийлж байгаа юм, байгаа санал зөрж байгаа юм байгаа. Ер нь ихэнх саналуудыг нь тусгасан.

**С.Одонтуяа:** Ганбат гишүүн тодруулга 1 минут.

**Д.Ганбат:** Ингээд ярилцаад эхлэхээр бас таны хардаг өнцөг өөр, миний хардаг өнцөг өөр л дөө. Хүн хүн болгоны хардаг өнцөг өөр байх. Та мэдээж хэрэг хаана бэлтгэгдсэн хуульч вэ гэдэгт ойлгомжтой. Нөгөө талаар одоо та ингээд сая хариултдаа Дээд шүүхээс заавал Дээд шүүхийн 3 шүүгч нь ийшээ явна л гэж байна. Тэгэхээр Дээд шүүх чинь ингээд л бас л хараат болчхож байгаа байхгүй юу. Арай гэж гайгүй байсан юмыг. Одоо Дээд шүүх чинь өөрөө томилгоо авч авахын тулд бас эрх баригчдаас ингээд хамааралтай болчхож байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл Үндсэн хуулийн цэцэд 3 хүн суух юм байна. Тийм би боломжтой юм байна гээд л. Ингээд л яг энэ маягаараа яваад л ингээд байхаар болохгүй. Тэгэхээр дараагийн тоо нь ч ихсэх юм байна, ард түмний төлөөллийг яг Улсын Их Хурал хууль, тогтоох байгууллагад тусгах юм байна. Тэр парламенттай үлдээе хэдүүлээ.

**С.Одонтуяа:** Нэмж хариулья Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Дээд шүүхээс нэр дэвших нэр дэвшигч нар Дээд шүүхийн шүүгч нар байх ёстой гэдэг хуулийн шаардлагыг бид нар тавьж байгаа. Ийм шаардлага тавихад Дээд шүүх дээр ямар нэгэн хүндрэл үүсэх үү, эсэргүүцэл байна уу гэдгийг бид нар тодруулсан. Тодруулахдаа албан ёсоор

хуулийн төслөө Дээд шүүхэд өгөөд, Дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр манай хуулийн төслийг хэлэлцсэн. Ганцхан манай хуулийн төслийг байтугай дагаж өргөн барьсан процессын хуулиудыг хүртэл хэлэлцсэн. Тэн дээр Дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөс асуудал байхгүй. Бид нар нийт 24 шүүгч нараасаа 3 шүүгчээ 6 жилээр Цэцийн гишүүн болгоод явахыг дэмжиж байна гэж байгаа. Дэмжиж байна гэж байгаа юм.

Яагаад дэмжиж байгаа юм бэ гэхлээр нэгэнт Цэц дээр үндсэн эрхийн маргаан хэлэлцдэг, хүний шүүхээр шийдүүлчихсэн асуудлыг дахиж үндсэн эрх талаас нь хараач гэдэг шийдвэрийг Цэц гаргах гэж байгаа бол шүүхийн ажлын дадлага, туршилагатай, мэдлэгтэй хүмүүс тэнд шийдвэр гаргаж байхад бидэнд хэрэгтэй. Тийм учраас энэ 2 байгууллагын ажлын уялдааг хангахад ч гэсэн үүднээс энэ хэрэгтэй юм, бид нар дэмжиж байна гэж байгаа юм.

Тэгээд ингэлээ гээд Дээд шүүх хараат болохгүй шүү дээ. Угаасаа Дээд шүүх чинь дээд шүүхийн гишүүд чинь насан туршийн томилолтоо аваад л яваад өгнө. 6 жил юм уу, 12 жил Цэцийн гишүүнээрээ ажиллаад төрийн алба хаах насны дээд хязгаар хүрээгүй бол буцаад Дээд шүүхдээ орох бололцоог нь бид нар энэ хуулийн Дагаж мөрдөх журмын тухай хуулиараа нээж өгч байгаа юм. Тэгэхгүй бол бас нөгөө залуу шүүгч нараа явуулахгүй, яг тэтгэвэрт гарах гэж байгаа хүмүүсээ явуулаад байх аюул байна гэж Дээд шүүхийн шүүгч нар өөрсдөө зөвлөмж дээрээ бичсэн учраас бид нар энэ заалтыг оруулж өгсөн. Дээд шүүх бол энэ асуудал дээр проблем байхгүй.

**С.Одонтуяа:** Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Ингээд л асуудал байгаа байхгүй юу даа. Та бид 2 юмыг 2 талаас нь өөрөөр харж байа л даа. Над

шиг харж байгаа зөндөө хүмүүс байгаа бас энэ хуульчид дотор чинь. Тэгээд Дээд шүүхээс өөрөөс нь шүүгч нараас нь авахад мэдээж хэрэг тэд нар дэмжсэн л санал өгнө шүү дээ.

Яагаад гэвэл эд нар ахиад л тэнд 6 жил байх юм байна, Үндсэн хуулийн цэцийн гишүүн болох юм байна, бид нарын нэг нь байх юм байна, аягүй бол би байх юм байна л гэсэн ийм л бодлоор тэд нар чинь өгнө шүү дээ. Ийм маягаар явж байгаа болохоор уг нь ч, тэгэхээр наад хууль чинь ер нь бас арай хэтэрхий нэг талыг барьсан, яг ард түмний эрх ашгийг илэрхийлэх, ард түмэнд хэрэгтэй ийм зөв зүйтэй хууль болох талаасаа нэлээн л асуудалтай юм байна. Би ахиад хэлье. Дараагийн парламентад бид нар үлдээх хэрэгтэй. Бид нар өнөөдөр гурилынхаа асуудлыг хэлэлцээд, ард түмэнд хэрэгтэй шийдвэрийг гаргах ёстой байтал бүх юмны өмнүүр ороод л аль болохоор бүх байгууллагыг ямар нэгэн бай.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариулт.

**Ц.Мөнх-Оргил:** Энэ Ганбат гишүүн ээ миний шийдэх асуудал биш л дээ. Улсын Их Хурал олонхоороо л шийднэ. Тэгээд энэ дээр нэг л төрийн үйл ажиллагааны үндсэн том зарчим байгаа шүү дээ. Тасралтгүй явна. Улсын Их Хурлын үйл ажиллагаа бүрэн бүрэлдэхүүнээрээ ингээд үйл ажиллагаа явуулж байгаа цагт бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжоо батлах шаардлагатай гэвэл батална. Батлах бололцоогүй юм аа дараагийн Их Хуралдаа үлдээнэ гэвэл үлдээнэ. Та бол үлдээх ёстой юм байна гэж бодож байна. Би бол батлах ёстой юм байна гэж бодож байгаа юм.

Яагаад гэвэл 126 гишүүнтэй болно, шинэ дэгтэй болно, шинэ процесстэй болно. Тэр 126 бүрэлдэхүүнтэй Их Хурал жигдэрсээр байтал энэ хуулийг баталтал ахиад

хэдэн жил болно. Тэр хооронд Цэц өнөөдөр жишээ нь, даргагүй л явж байна шүү дээ. Энэнээс авхуулаад л энэ Цэцийн үйл ажиллагааг цэгцлэх, янзлах бас эрх зүйн шинэ орчинд хүрэх гарцаагүй шаардлага байгаа байхгүй юу.

Тэгэхлээр та бид хоёр санал зөрж байна. Тэгээд Улсын Их Хурал олонхоороо л шийдэх байх. Би таны саналд хүндэтгэлтэй хандаж байна. Таны санааг би ойлгож байна. Та Байнгын хороон дээр ч гэсэн эртээд энэ саналаа хэлсэн.

**С.Одонтуяа:** Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууна.

**О.Цогтгэрэл:** Үндсэн хуулийн цэц гээд асар чухал байгууллагын хууль орж ирж байна л даа уг нь. Үндсэн хуулийн цэцийнхэн болохоор Үндсэн хуулийн цэцийн дээр хөх тэнгэр байдаг гэдэг. Уг нь бол утга агуулгаараа Үндсэн хууль Цэцийн дээр Монгол Улсын Үндсэн хууль нь орших ёстой. Яг өнгөрсөн хугацаанд ингээд улс төрийн нөхцөл байдлуудыг, түүхийг харахад Үндсэн хуулийн цэцийн дээр Үндсэн хууль биш үндсэндээ том дарга нар өнгөрсөн хугацаанд явж ирж улс төрийн шийдвэр гаргуулж ирснийг бид нар бас бүгдээрээ л бас мэднэ. Нэг асуудлаар өөр өөр шийдвэрүүд олон удаа гарч байсан. Сонгуулийн тогтолцооны асуудлаар яг адилхан асуудлаар олон олон шийдвэр, давхар дээлийн асуудлаар гэх мэт асар олон олон шийдвэрүүдийг зүгээр улс төрийн улс төрийн эрх баригч намын захиалгаар л гаргадаг. Уг нь бол нэг зүйл дээр хоёр үнэн гэж байхгүй шүү дээ.

Тэгэхээр олон олон асуудлууд яг энэ Үндсэн хуулийн цэц өөрөө тийм дээд хүчин чадалтай Үндсэн хуулиа сахиулах ёстой байгууллага. Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн өөрийнх нь заалтыг хүртэл Үндсэн хууль зөрчсөн байна гээд л өнгөрсөн жил гаргаж байсан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчихжээ гээд.

Энэ чинь Үндсэн хуульд бусад хууль дагаж нийцэж байгаа эсэхийг шийдэх ёстой байгууллага гэж бид нар ойлгодог. Тэгээд энэ хууль дотор бас олон олон зүйлүүд байна байна. Жишээ нь, тэр иргэний үндсэн эрхийн маргаан гэдэг зүйлийг дагалдах хуулиар шийдье гэж байгаа. Энэ бол бас их зөв зүйтэй.

Гэхдээ Ардчилсан намаас бас туршилагатай хуульчдын хэлж байгаагаар өнгөрсөн 30 жилийн хугацаанд Үндсэн хуулийн цэц иргэний үндсэн эрхийн маргааныг шийдэхгүй, Цэц дээр шийдэхгүй гэдэг байр суурь асар олон удаа баримталж ирсэн нь бас ийм түүх байдаг. Тэгэхээр эндээс юуг хэлэх гээд байна вэ гэхээр одоо Цэцэд эрх шилжүүлсэн Цэцтэй холбоотой асар олон хууль, дүрэм, өөрчлөлтийг бид нар хийх нь. Эндээс өөрт хэрэгтэйгээ авч үлдээд, өөрт хэрэггүйгээ Цэц өөрөө Үндсэн хууль зөрчсөн гээд хасаж хаяад, тэгээд ийм өөрийнхөө эрх эрх ямбыг нэмсэн ийм байгууллага болоод үлдчих вий. Яг энэ иргэний үндсэн эрхийн маргааныг энэ бол Монгол улсад асар чухал хэрэгтэй байгаа хууль. Тэр тусмаа энийг өнгөрсөн жилийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ардчилсан намын зүгээс энийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, бүр Үндсэн хуулийн өөрийнх нь заалт болгож оруулъя гэдэг саналыг гаргаад тухайн үедээ хүчрээгүй.

Тэгэхээр энэ энэ олон олон зүйлүүд дээр бид нарт бас ингээд тодорхой дүгнэлт хийх цаг хугацааны хувьд одоо яг энэ мөн үү гэдэг дээр өнгөрсөн нэг дэх өдөр энэ Ардчилсан намын бүлгийн хурлаар бид нар бас энийг хэлэлцсэн. Бас тэнд ярилцсан зүйлүүдийн гол зүйл нь яг өнөөдөр эрх барьж байгаа Ардын нам ард түмний 40 хувийн мандатыг авсан. Ард түмний 40 хувийн санал авсан. Улсын Их Хурал дээр дийлэнх олонх буюу 80 гаруй хувийн эрх мандаттай байгаа. Энэ Улсын Их Хуралд бас ийм тогтолцооны том өөрчлөлтүүдийг яг одоо ингээд ийм төгсгөлд нь ирж хийх ийм яг эрх зүйн ёс суртахууны ийм эрх

бас байна уу гэдэг зүйлийг ч хүртэл тухайн үед бас ингэж ярилцсан.

Ийм учраас Ардчилсан намын бүлэг дээр бид нар бас санал хурааж, шийдвэр гаргасан. Зарчмын хувьд энэ хуулийг энэ удаад Ардчилсан намын бүлгийн зүгээс дэмжихгүй байх нь зүйтэй. Тийм ч учраас энэ шинээр бүрэлдэж байгаа, шинэ тогтолцоогоор илүү тэр ард түмний санал гээгддэггүй тогтолцоогоор гарч ирсэн 126 хүнтэй парламент нь энэ том суурь өөрчлөлтийн шинжтэй энэ асуудлаа шийдэх гэдэг ийм байр суурийг бас нэгтгэж гаргасан. Ийм учраас миний хувьд бас Ардчилсан намын бүлгийн байр суурийг илэрхийлээд яг энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хууль дээр Ардчилсан намын бүлгийн зүг бас ажлын 5 хоногийн завсарлага өгөөч гэж Улсын Их Хурлын дэд даргаас хүсэж байна.

**С.Одонтуяа:** Тэгье. Тэгэхээр одоо 3 гишүүн асууна. Тэгээд асуулт асуугаад, хариултаа авсны дараа завсарлага өгье. Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа Цогтгэрэл гишүүн ээ энэ ийм юм. Хар аа энэ 3 парламент дамжиж байгаа асуудал шүү. Тэгээд л яг асуудал хэлэлцэх болохлоор л дараагийн парламентдаа, дараагийн парламентдаа гээд л. Ингээд л хойшлуулсаар байгаад л 32 жил энэ Цэцийн хууль ерөөсөө шинэчлэгдэхгүй явж ирчхээд байгаа юм.

Тэгээд үндсэн эрхийн маргааныг шийдэх асуудлыг Ардчилсан нам ийм бололцоо гарч ирээд, ийм хуулийн төсөл орж ирээд Дээд шүүх нь болж байна гэж хэлээд Цэцийн нийт гишүүдийн олонх нь ер нь болно гэж хэлж байгаа ийм түүхэн ховорхон орон зай гарч байгаа үед та нар маань ингээд завсарлага аваад дараагийн Их Хуралд шилжүүлж байгаа. Би бол хуульч хүний хувьд, хууль тогтоогч хүний хувьд үнэхээр харамсаж байна. 2000 оноос хойш л нийт хуульчид бид нар чинь энэ Цэц энэ хүний үндсэн эрхийг

хамгаалдаг болоосой, энэ шүүхийн шийдвэрт үндсэн хүний эрх талаас нь хардаг болоосой гээд л бид нар чинь олон олон үе дамжиж л, мөрөөдөж ирж энэ бололцоог л гаргаж байгаа шүү дээ.

Тэгээд ийм нэг үүлэн чөлөө гарч ирээд. Энэ чинь хуучин ийм байдаг байсан байхгүй юу. Яагаад үндсэн эрхийн маргааныг Цэц дээр хэлэлцдэггүй гэхлээр энэ хуулийн нээлтийг нь бид нар хийж өгөөгүй байхгүй юу. Цэцийн хуульд, Цэцийн процессын хуульд үндсэн эрхийн маргааныг ингэж шийдвэрлэнэ, шүүхийн шийдвэр гарчих юм бол ингэж шийдвэрээ гаргана, тэгээд асуудлыг нь шүүх дээр ингэж шийдвэрлэнэ гэдэг процессолж өгөөгүй учраас мэдээж Цэцийн ямар ч бүрэлдэхүүн байсан гэсэн үгүй үгүй ээ энэ чинь хуулиараа бид нарт шууд эрх нь олгогдоогүй байна, процесслогдоогүй учраас бид нар шийдэхгүй гээд л орхино шүү дээ. Одоо бид нар тэрийг нь нээж өгч байгаа байхгүй юу. Процессолж өгч байгаа байхгүй юу.

Дээд шүүх дээр энийг буцаадаг тал олон удаа байсан юм. Одоо бол харин Дээд шүүхийн бүрэлдэхүүн бол энэ асуудалд маш юу гэдэг юм ирээдүйг харсан, өөрийнхөө зөвхөн өөрийнхөө арьсаа бодсон бол Дээд шүүх энийг 100 хувь эсэргүүцээд л таслаад хаях байхгүй юу. Тэгтэл тэгэхгүй байгаа байхгүй юу. Хүний эрхийг хамгаална гэдэг шүүхийн шийдвэр гарснаар 100 хувь баталгаажихгүй. Тэрийг Цэц Үндсэн хуулийн нүдээр хараад, Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн нүдээр хараад та нар ийм алдаа гаргасан байна шүү, үүнийгээ засаач гэдэг бололцоо өгвөл бид нар тэр алдаагаа засна шүү дээ гэж байгаа байхгүй юу. Ийм ховорхон орон зайд бид нар байна Цогтгэрэл гишүүн ээ.

Тэгэхлээр би ийм саналтай байна. Та мэдээж завсарлага авч байгаа юм чинь завсарлагаа авах байх. Энэ завсарлагын хугацаанд би ажлын хэсгийн гишүүд, ажлын дэд хэсэгт орж ажилласан судлаачид эд нарыг дагуулаад

танай бүлгийн хуралд хэд вэ та тийм бололцоо олгох юм бол бид нар оръё, танай бүлгээс ажлын хэсэгт орох, дэд ажлын хэсэгт орох судлаачдаа өг. Тал талаасаа ярья. Танай бүлгийн гишүүдийн асуулт хариулъя. Эргэлзээтэй байгаа зүйлүүдэд тодруулга өгье. Тэгээд энэ хуулиа бололцоо байвал хэдүүлээ энэ бүрэлдэхүүнээрээ батлаад явах нь зөв дөө Цогтгэрэл гишүүн ээ. Энэ бол түүхэн бололцоо шүү. Цаг хугацаа бол биднийг хүлээхгүй шүү. 32 жил бид нар энэ цагийг алдлаа. Одоо ахиад.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Цогтгэрэл гишүүн тодруулга 1 минут.

**О.Цогтгэрэл:** Яг түрүүн Ардчилсан намын бүлгийн шийдвэрээр бид нар завсарлагын хүсэлт хэлчихсэн. Завсарлагаа Их Хурлын дэд дарга өгөх байх. Тэгэхдээ тэгээд Мөнх-Оргил гишүүн бас тодорхой саналууд хэлж байгаа юм чинь. Ирэх 7 хоногийн нэг дэхийн бүлгийн хурал дээр та бас саяын хэлдэг тэр үндэслэлүүд, бид нар бас энэ дээр бусад Ардчилсан намын болоод хуучин парламентад сууж байсан гишүүдээсээ бид нар бас оролцуулъя. Та ажлын хэсэгтэйгээ ирээд бас манай бүлэг дээр тайлбар хийгээрэй. Тэгээд бас яг цаашид яах вэ гэдгийг бас тэн дээр бас олонхоороо бас шийднэ биз дээ.

**С.Одонтуяа:** Одоо Чинзориг гишүүн асуултаа асууна.

**С.Чинзориг:** Энэ Цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон жил бас ярьж байгаа. Шийдэх ёстой асуудал гээд гишүүд байнга л ярьдаг асуудал. Тийм учраас би Мөнх-Оргил гишүүн нарын санаачилсан энэ хуулийн төслийг бол хэлэлцэхийг нь бол дэмжиж байна.

Би харин Цогтгэрэл даргыг энэ хуулийг хэлэлцэхээс завсарлага авъя гэж байгаад нь гайхаж байна. Манай Ардчилсан намынхан хүний эрх их ярьж улс төр их хийдэг нам. Яг иргэний үндсэн

эрхийн маргаантай холбоотой асуудлыг Цэцээр бас хянан шийдвэрлэдэг болъё гэдэг асуудал орж ирэхээр энэ хуулиас бас завсарлага авъя гэж байгаад нь би бол бас жаахан гайхаж байна. Ам, ажлын зөрүү бас нэлээн байгаа юм биш биз дээ гэж гайхаж байна.

Хэд хэдэн тодруулах зүйл байна Мөнх-Оргил гишүүн ээ. Үндсэн хуульд чинь Дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна гэсэн Үндсэн хуулийн заалттай. Одоо энэ Цэцийн тухай хуульд оруулж ирж байгаа хууль түүний дагалдан гарч байгаа энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд чинь Дээд шүүхийн шийдвэрийг Цэц бас хянах юм шиг.

Тэгээд Цэцийн дүгнэлт гарвал өмнөх гаргасан шийдвэрээ хүчингүй болгож гээд бүүр биччихсэн юм байна. Хүчингүй болгож, Цэцийн дүгнэлтэд нийцүүлэн хянан шийдвэрлэнэ гээд ингээд ороод ирж байна. Тэгэхээр энэ чинь нөгөө Дээд шүүхийн шийдвэр эцсийн байна гэсэн Үндсэн хуулийнхаа агуулгатай, суурь зарчимтайгаа зөрчилдөх үү, үгүй юү? Үүнийг бас хууль санаачилж юу гэж үзэж байгаа юм? Би бол ийм болгоомж бол байна.

Нөгөө талаасаа засаглал хуваах онолоор чинь шүүх чинь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг хараат бус байгууллага. Тэгэхээр энэ Цэцийн хуулийн дагуу энэ хуулиуд өөрчлөлт орсноороо бас Үндсэн хуулийн бас маргаан зөрчил рүү орчихгүй биш биз дээ гэдгийг бас хариулт тайлбар авмаар байна.

Хоёр дахь асуудал нь ер нь Цэц маргаан хянан шийдвэрлэх тэр эрхийг нь хэр оновчтой болгож өгч байгаа юм бэ? Би ойлгохдоо Үндсэн хууль хууль тогтоомжууд Үндсэн хууль зөрчиж байна уу, үгүй юү гэдэгт Цэц дүгнэлт гаргах ёстой гэж ойлгодог.

Гэтэл манай Цэц чинь бол практикаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг ч гэсэн бас Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн энэ дүгнэлт эд нар гаргаад л явж байсан асуудал бий шүү дээ. Гэтэл Үндсэн хуульд чинь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр байна гэсэн бас хуультай. Ингээд энэ хэлэлцэх маргаан хянан шийдвэрлэх асуудлууд нь их оновчтой бус байгаа юм. Энийг бас хэрхэн шийдэж чадаж байгаа юм?

Гурав дахь асуудал нь Цэцийн гишүүнийг тодорхой хугацаатай, дарга томилох нь ч хугацаатай. Хугацаагүй байна уу? Манай Цэц чинь дарга ч үгүй л байгаад байна шүү дээ. Олон сар боллоо шүү дээ. Тэгээд Цэцийн гишүүнийг хугацаа дууссан бол тодорхой хугацаанд нь дараагийн хүнийг нь томилдог байх, даргыг нь тодорхой хугацаанд томилдог эд нар байх энэ зохицуулалтууд нь хэр оновчтой болж орж байгаа юм бэ гэдгийг нь тодруулмаар.

Гурав дахь асуудал манай хуулийнхан нэг асуудал байна. Бусад салбаруудын нийгмийн хамгаалалттай холбоотой асуудлуудыг ярихлаараа салбарын суурь хуулиар явах ёстой, Төрийн албаны хуулиар явах ёстой гээд манай хуульчид их ярьдаг. Тэгээд хуульчид өөрсдөө хуулийн төсөл боловсруулаад ороод ирэхлээрээ хууль хяналтын байгууллагуудад болохоор энэ нь үйлчилдэггүй. Хууль хяналтын байгууллагуудын бүх л нийгмийн хамгаалалттай холбоотой, цалин хөлстэй холбоотой, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлыг салбарынх нь хуулиар зохицуулах ийм хууль хийгээд байдаг. Хуульчид маань ингээд төрийн албандаа албан хаагчдад ингээд ялгамжтай хандаад байдаг. Энэ хуулиас нь харахлаар Цэцийн гишүүдийн тэтгэврийг 60 хувиар бодож байх юм байна. Амь нас эрүүл мэндийн даатгалын шитгэлийг нь төр хариуцах юм байна, тэтгэвэрт гарахад нь 36 сарын



тэтгэмж өгөх юм байна. Бүр өмнө нь Цэцийн гишүүнээр ажиллаж байсан бол 36 сарын тэтгэмж өгнө гээд. Ингээд төрийн албан хаагчдаа ингээд тэгш бус хандаад байх уу? Энэ талаар.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Хууль санаачлагч Мөнх-Оргил гишүүн хариулъя. Түрүүн нэг гишүүн асуусан шүү дээ. Тантай хамт нөгөө санаачилсан гишүүн нь хэн юм бэ гээд. Тэрийг та бас хариулчих.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. 21 оны 9 сарын 28-нд Хууль зүйн байнгын хороо ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар намайг томилоод, ажлын хэсгийн гишүүдээр Алтанхуяг гишүүн, Баатарбилиг, Батсуурь, Бямбацогт, Сандаг-Очир, Энхбаяр нар томилогдсон юм. Би ажлын хэсгийг 2 удаа, 3 удаа хуралдуулсан. Хуралдаанд Алтанхуяг гишүүн, Бямбацогт гишүүн, Батсуурь гишүүн, Сандаг-Очир гишүүн нар ирсэн. Хуралдаанд орсон гэсэн үг. Хуулийн бүх төслүүдийг ажлын хэсгийн гишүүдэд өгөөд явж байсан. Яг өргөн барихад Бямбацогт, Мөнх-Оргил хоёр гарын үсэг зурсан. Яагаад гэвэл Батсуурь гишүүн, Алтанхуяг гишүүн хоёр хоёулаа хөдөө томилолттой явж байсан байхгүй юу. Бямбацогт бид хоёр өргөн барьсан.

Чинзориг гишүүний асуултад хариулахад Дээд шүүхийн шийдвэр эцсийнх л дээ. Тэгэхдээ Үндсэн хуульд ийм заалттай юм. 50 дугаар зүйлийн 2 дээр Улсын дээд шүүхийн шийдвэр Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Дээд шүүх өөрөө хүчингүй болгоно гэж байгаа юм.

Тэгэхлээр бид нарын ойлгоод байдаг шиг Дээд шүүх шийдвэрээ гаргачихсан л бол ахиж хэзээ ч өөрчлөхгүй гэсэн заалт байхгүй байхгүй юу. Дээд шүүх өөрөө шийдвэрээ өөрчилж болно. Тэгэхлээр энэ хуулиар бид нар Цэц

Дээд шүүхэд өөрийнхөө гаргасан шийдвэрийг өөрчлөх бололцоог нь л олгож байгаа юм нэг талаас.

Нөгөө талаас бид түрүүн уншиж танилцуулсан шүү дээ. Энэ Дээд шүүхийн бүрэн эрхт 51.3 дээр ийм заалт байгаа юм хууль түүнд заасан эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц Улсын ерөнхий прокуророор шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх гээд. Энэ ерөөсөө хэрэгжээгүй байхгүй юу. Ерөнхий прокурор Үндсэн хуулийн цэц Дээд шүүхэд танай энэ шийдвэр чинь энэ хүний үндсэн ийм ийм эрхийг зөрччихсөн байна шүү, үүнийгээ шийдвэрлээч гэж. Дээд шүүхэд асуудал оруулж байх ёстой байсан байхгүй юу. 32 жил оруулаагүй. Яагаад гэвэл бид нар хуулийг нь хийж өгөөгүй байхгүй юу.

Тэгэхлээр энэ Үндсэн хуулийн зөрчилдөөн энд байхгүй. Дээд шүүх ийм шийдвэр гаргачихлаа гэхэд Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн ийм заалтын ийм ийм эрхийг тухайн иргэн Доржийн ерөнхийдөө биш, абстракт биш яг тухайн иргэний тухайн асуудлаар Үндсэн хуулийн ийм эрхийг нь зөрчсөн байна, үүнийгээ эргэж хараач гэдэг шийдвэр гаргахлаар Дээд шүүх өөрөө шийдвэр гаргачихсан бол энэ Үндсэн хуулийн 50.2-хоо заалтаар өөрийнхөө шийдвэрийг эргээд харчихна. Доод шатын шүүхийн, давж заалдах шатын шүүхийн шийдвэр гарчихсан байх юм бол Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй нийцүүлж шийдвэрээ өөрчил гээд гаргана. Тэгэхлээр шүүхийн шийдвэр эцсийнх хэвээрээ байна. Дээд шүүхийн шийдвэр эцсийнх хэвээрээ байна. Үндсэн хуулийн 50.1.3-аар заасан Үндсэн хуулийн цэцийн Дээд шүүхэд асуудал оруулах эрхийг л бид нар баталгаажуулж өгч байгаа юм.

Эрх зүйн хувьд онолын болоод практикийн хувьд асуудал гарч ирдэг. Цэц ингээд асуудал оруулаад ирэх.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Нэмж хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Уучлаарай би дэлгэрэнгүй хариулаад энэ маргаан дагуулж байгаа шүүгч нар, өмгөөлөгчид, хуульчид, жирийн иргэдийн дунд ч гэсэн их асуудал үүсгэж байгаа асуудал учраас дэлгэрэнгүй тайлбарлахгүй бол болохгүй байгаа юм.

Тэгэхлээр Цэц Дээд шүүхэд асуудал оруулаад ирэхлээр, үндсэн эрх зөрчигдчихлөө гээд асуудал оруулаад ирэхлээр эрх зүйн ямар арга, техникийг хэрэглэж энэ асуудлыг шийдэх вэ гэдэг асуудал гарч ирээд байгаа байхгүй юу. Ямар процесс. Тэгээд үүнийг бид нар Дээд шүүхийн шүүгч нартай яриад Дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр энийг хэлэлцээд арга нь бол шинээр илэрсэн нөхцөл байдал гэдэг техник байгаа шүү дээ. Шинээр илэрсэн нөхцөл байдлыг хэлэлцэх журмынхаа дагуу энийг шийдвэрлэнэ гээд Дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр 3 процессын хуульд оруулсан өөрчлөлтийг Дээд шүүхийн шүүгч нар дэмжчихсэн юм. Яг энэ процессоор явах юм бол шүүхийн процесс гацаагүй явах юм байна, Үндсэн хуулийн болон Шүүхийн хуулийн дагуу явах юм байна гээд энийг зөвшөөрчихсөн юм.

Тэгэхлээр энэ бол одоо юу байхгүй. Засаглал хуваарилах зарчим дээр онолын маргаан гарахгүй. Гол юм бол энд шүүхийн шийдвэр Үндсэн хуульд нийцэж байх ёстой юм. Ерөөсөө л энэ зарчим байгаа байхгүй юу. Үндсэн хуульд нийцээгүй, тэгэхдээ бусад хуульд нийцсэн шүүхийн шийдвэр гэж байж болохгүй шүү дээ. Манай шүүхийн тогтолцооны манай хууль, эрх зүйн нэг онцлог байгаа байхгүй юу. Энийг яваандаа бид нар бас бодолцмоор л юм байна лээ. Бусад ихэнх оронд үндсэн хуулийн заалтыг бусад шүүхүүд нь бусад шүүх хуулийн заалттай адил шууд хэрэглэдэг байхгүй юу. Шууд хэрэглэнэ. Жишээ нь, Германд үндсэн хуулийн тийм тийм заалт байлаа гэхэд л тэрийг амилуулсан органик хууль

шаардлагагүйгээр Үндсэн хуулийн тэдийн тэдийн дагуу гээд шийдээд явчихдаг.

Манай шүүхийн практик болон манай онол бол Үндсэн хуулийн заалтыг заавал амилуулах ёстой. Тэр нь органик хуулиар баталгаажих ёстой, бусад хуулиар амилах ёстой. Тэрийг нь шүүх хэрэглэдэг байхгүй юу.

Тийм учраас шүүх бол Үндсэн хуулийг шууд хэрэглэдэггүй. Тэгэхлээр энэ Үндсэн хуульд заасан үндсэн эрхийн зөрчлүүд чинь Цэцээс өөр газар хэлэлцэгдэхгүй бол тэр бүгддээ зөрчилтэй үлдээд байгаа юм. Ийм онолын том ялгаатай байгаа байхгүй юу.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн тодорхой хариулчих. Минутдаа багтаагаад л товчхон, тодорхой.

**Ц.Мөнх-Оргил:** Энэ өөрөө тийм маргаан, энэ ингээд л хууль батлагдахлаар л асуудал гарна шүү дээ. Өө Дээд шүүхийн шийдвэр эцсийн байхад л та нар ингээд Дээд шүүхийн шийдвэрийг эргэж харж байна гээд л асуудал байна. Тэгэхлээр энд тийм биш юм. Дээд шүүх өөрөө шийдвэрээ эргэж харах эр эрх зүйн болон үндсэн хуулийн үндэслэлтэй юм гэдгийг л би тайлбарлаж яриад байгаа байхгүй юу. Энэ тэгэхлээр олон нийтэд, нийт гишүүдэд мэдээлэл өгөхөөс гадна олон нийтэд мэдээлэл өгөх чухал ач холбогдолтой юм.

Тэр Цэц ямар асуудлууд шийдэх ёстой юм бэ гэдгийг энэ дээр бас их онолын том маргаан гардаг юм. Энийг хаалттай жагсаалт гэж яриад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн цэц дээр ийм ийм асуудлуудыг л хэлэлцэнэ шүү гээд хэлчихсэн юм. Жишээ нь, 66 дугаар зүйл дээр Үндсэн хуулийн цэц ийм 66.2 дээр ийм асуудлыг л хэлэлцэнэ гээд 6 асуудал жагсаачихсан. Энэнээс өөр асуудал хэлэлцэх ёсгүй гэж. Энийг би онолын бөгөөд практикийн

хувьд буруу гэж үзэж байгаа байхгүй юу. Цэц бол аливаа шийдвэр Үндсэн хуультай нийцэж байна уу, үгүй юү л гээд асуудлыг л хэлэлцэх ёстой байхгүй юу. Тэрнээс биш өө энэ 5-ыг л хэлэлцэнэ, бусад нь Үндсэн хууль зөрчсөн ч гэсэн манайд хамаагүй гэж ярьж болохгүй байхгүй юу. Тэр утгаараа бид нар энэ асуудлыг оруулж ирж байгаа юм.

Тэр Чинзориг гишүүний Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуультай нийцэж байна уу, үгүй юү гэдгийг Цэц хянах юм уу, үгүй юү гэдэг асар том маргаантай асуудал. Миний бодлоор энэ маргаантай асуудлыг манай Үндсэн хууль дээр тодорхой заачихсан байхгүй юу. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил үйлчилнэ гээд заачихсан учраас Цэц бол хуучин, өмнө нь Совд даргын үед, Жанцан даргын үед зөвхөн хэлбэрийн хяналт тавьдаг байсан байхгүй юу.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурал тэр процессын дагуу хэлж үү, үгүй юү гэдгийг л хэлбэр талаас нь хянадаг байсан болохоос биш, агуулга нь Үндсэн хуультай нийцэж байна уу, үгүй юү гэж хянаж байгаагүй.

Харамсалтай нь сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг агуулгын талаас нь хянаад эхэлсэн. Агуулгын талаас нь хянахдаа Үндсэн хуулийн үндсэн бүтцийн онол буюу бейсек стракчер докторин /basic structure doctrine/ гээд.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Минут болсон доо хариулт. Дараагийн хүнээс асуулгачихъя. Чинзориг гишүүн 1 минут тодруулга.

**С.Чинзориг:** Би асуумаар байна. Одоо манай Цэц чинь даргагүй явж байдаг. Даргаа ямар хугацаанд томилж байх вэ гэдгийг нь тодорхой болгож байна уу? Цэцийн гишүүд хугацаа нь дуусчхаад зарим нь бүүр 2, 3 жил явсан ч асуудлууд бий. Үүнийгээ яаж цэгцэлж

байгаа юм? Одоо хугацаа зааж байгаа юм байна лээ.

Нөгөө талдаа тэр нийгмийн хамгаалалттай холбоотой юмыг нь хэт их давуу байдал олгож болохгүй шүү дээ. Тэтгэврийг нь 60 хувиар бодно, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, амь насны шимтгэлийг нь төр хариуцна, одоо ажиллаж байгаа болоод өмнө нь Цэцэд ажиллаж байсан хүн болгонд 36 сарын тэтгэмж өгнө гээд би хуульчдыг гайхаад байдаг юм. Бусад салбарын юм ярихлаар Үндсэн хуулиараа зохицуулах ёстой, Төрийн албаны хуулиараа зохицуулах ёстой гэдэг. Тэгээд хуульчид өөрсдөө хууль хяналтын байгууллагууд хууль оруулж ирэхлээрээ энэ нь хамааралгүй. Ерөөсөө хууль болгонд нь цалин, тэтгэвэр, бүх юмыг нь оруулж шийддэг. Төрийн албан хаагчдаа хууль боловсруулах ажилд ийм ялгамжтай хандаж болохгүй шүү дээ. Үүнийг одоо яах юм бэ Мөнх-Оргил гишүүн ээ?

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Чинзориг гишүүн маш чухал асуулт асуулаа. Би маш товчхон хариулъя. Би тантай 100 хувь санал нэг байна. Би дандаа тэр салбарын хуулиар нийгмийн асуудлаа шийдэхээ болиоч гэдэг би байнга үгээ хэлж ирсэн, байнга эсэргүүцэж ирсэн. Энэ удаагийн хууль дээр байна шүү дээ тийм юм ер илүү юм ерөөсөө оруулаагүй шүү Чинзориг гишүүн ээ. Монгол, байж бай л даа. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйл дээр шүүгч түүний гэр бүлийн гишүүний нийгмийн баталгаа гээд заалт байгаа юм. Яг тэрийг л бид нар хуулиудад нь оруулж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, Дээд шүүхийн шүүгчтэй адилхан болгож байгаа юм. Тэрнээс биш нэг ч зүйл нэмээгүй. Тэтгэврийг 60 хувиар тооцно гэдэг чинь одоо хүчин төгөлдөр хууль байхгүй юу Чинзориг гишүүн ээ. 36 сар чинь одоо

хүчин төгөлдөр хууль дээрээ байж байгаа юм. Шинээр нэмж оруулж, 1 ч төгрөгийн цалин нэмээгүй, 1 ч төгрөгийн тэтгэвэр нэмээгүй. Цэцийн гишүүн дээр Цэцийн гишүүн дээр нэмж байгаа нэг л зүйл байгаа юм. 1 судлаачтай л нэмэгдэж байгаа юм. 1 туслахтай байсан. Одоо 1 судлаач нэмж өгч байгаа. Өөр юу ч нэмээгүй шүү. Тэрийг та нар минь бүрэн зөв ойлгож өгөөрэй.

Өөрөөр хэлбэл, Дээд шүүхийн шүүгч ямар нийгмийн баталгаа эдэлж байна яг тэрэнтэй адилхан Цэцийн 9 гишүүнийг л нэмж өгч байгаа юм шүү. Тэр даргын асуудал их чухал байгаа юм аа. Одоо болтол даргагүй болчиход байгаа юм. Тэгээд манай энэ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн онгорхой заалтууд нь ийм байгаа байхгүй юу. Орон тоо гарчихлаар хэдэн хоногийн дотор дараагийн хүнээ томилох заалт байдаггүй.

Тэгэхлээр би юу гэдэг юм томилчихсон хүн нь манай институтийн томилчихсон хүн 4, 6 жилийн хугацаа нь дуусчхаад байхад дараагийн хүнийг нь томилохгүй 1 жил, 2 жил болчихдог. 2 жил 6 сар хамгийн урт хугацаа нь. Тэгэхлээр дараагийн хүн томилогдож байж нөгөө Цэцийн гишүүний бүрэн эрх дуусаж байгаа учраас 6 жилийн хугацаа нь дуусчихсан ч гэсэн 8 жил 6 сар ажиллачхаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр энийг нь бид нар 45 хоног гээд хязгаар тогтоож өгч байгаа юм. 45 хоногийн дотор нэрийг нь оруулж Улсын Их Хурал тэрийг нь хэлэлцэж батлахгүй бол нэр оруулаагүй албан хаагч, институт хууль зөрчсөн болно. Хариуцлагаа хүлээнэ. Баталж өгөөгүй бол Их Хурал өөрөө хариуцлагаа хүлээнэ. Хугацааг нь товлож өгч байгаа юм. Даргын хувьд ч гэсэн бид нар энэ дагаж.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Тодруулга 1 минут.

**С.Чинзориг:** Манай манай хуульч гишүүд 2 гартай л юм шиг л байдаг юм.

Бусад салбарынхандаа болохлоор Үндсэн хуулиараа бусад салбарынхаа хуулиар зохицуулах ёстой гээд гадуурхаад байдаг. Хууль хяналтын байгууллагуудын хуулийг хийхдээ тэр нь ерөөсөө хамаагүй болчихдог. Одоо наад Цэцийн хуульд чинь тэр 60 хувьд тэтгэвэр бодно гээд байгаа юм. Тэгээд наадах чинь амьдралаа хэрэгжихгүй яваад байгаа юм.

Яагаад вэ гэхлээр нөгөө нийгмийн даатгалынхаа суурь хуульд ороогүй учраас суурь хуулиараа зохицуулна гээд хэрэгжихгүй яваад байгаа байхгүй юу. Хэрвээ энийг оруулах гэж байгаа бол тэр дор нь нийгмийн даатгалынхаа хуульд оруулаад явах ёстой. Яахаараа тэр амь нас, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцах ёстой юм. Яахлаараа тэр одоо бол өмнө нь ажиллаж байсан бол тэтгэмжийг нь 36 сараар өгөх юм. Бид нар Төрийн албаны хуульд оруулаад төрд ажилласан жилдээ дүйцэхүйц сарын тэтгэмж олгоно гэсэн шүү дээ. Ингээд давуу байдал олгоод байж болохгүй. Хуульчид төрийн албан хаагчдаа хууль боловсруулах ажилдаа ингээд 2 гартаа хандаад байж болохгүй шүү дээ Мөнх-Оргил гишүүн ээ. Та бол энийг яг надтай адилхан юм яриад л байдаг. Тэгээд хуулийнхных нь санал ороод ирэхлээр шал өөр болоод явчихдаг байж болохгүй шүү дээ.

**С.Одонтуяа:** Санал байлаа. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуултаа асууна.

**Б.Энх-Амгалан:** Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Энэ бас яг Мөнх-Оргил гишүүний хэлж байгаа шиг их удаан ингэж хүний эрхийн үндсэн хүний эрхийг хамгаалах асуудал бол маш чухал байгаа юм. Би тэгээд Мөнх-Оргил гишүүн Чинзориг гишүүн байж бай даа Мөнх-Оргил гишүүнээс би хоёр юм асуух гээд байгаа юм.

Ингээд Цэцийн шийдвэр хүний эрхийн зөрчил гарлаа гэдгээр ингээд очихдог байжээ. Өмнө нь улс төрийн хэлмэгдүүлэлтэд орсон хүнийг, ар гэрийг нь төр хойч үе, дараа үе нь төлбөрийг нь төлөөд ингээд явж байна. Хэлмэгдүүлчихсэн хүнийг ер нь цаашидаа яах вэ? Хэлмэгдүүлчихсэн тэр хууль хяналтын байгууллагын албан хаагч, хэлмэгдүүлчихсэн тэр шүүгч тэр хүний эрхийг ноцтой зөрчихсөн ийм юмыг бид наравч үзэхгүй бол тэр нь ингээд л цол хэргэм одон медалиа зүүгээд л яваад байдаг. Хэлмэгдчихсэн хүн нь яах вэ тэгээд ар гэр, хойч үеийн нус нулимстайгаа холилдож байгаад хэдэн төгрөг аваад салдаг ийм болох гэж байна шүү дээ.

Хоёр дахь нь энэ хүний эрхийн ноцтой зөрчлийг хэрвээ энд орж ирж байгаа юм чинь хэлбэр нь төдий болох гээд байна шүү дээ. Ингээд Дээд шүүхэд чи энэ шийдвэрээ зас гээд явуулна. Дээд шүүх хэрвээ давж шатынх бол давж шатынх нь энийгээ эргэж хар гэж явуулна. Харахгүй бол яах юм?

Жишээлбэл, сая ингээд тэр хүний эрхийн ноцтой зөрчил гарч, эрүүдэн шүүсэн асуудал гарсан. Хууль бус аргаар хүчээр мэдүүлэг авсан асуудал гарсан. Энэ чинь Зоригийн хэрэг дээр гарлаа шүү дээ. Ийм юм гараад байвал яах юм? Тэгээд л энэ хүн чинь 5, 6 жил шоронд сууж сууж гарч ирж байгаад л тэгээд л одоо тэр эрхээ хангуулж чадахгүй ингээд байж байх юм уу? Үүнийг яах вэ гэдэг дээр та маш тодорхой хариулт өгөөч. Энэ чинь хэрвээ шийдэхгүй бол яах юм цаашидаа? Бид нар ийм сайхан юм бодоод байдаг. Гэтэл тэрийгээ хэрэглэхгүй бол яах вэ энэ чинь? 30 жил хэрэглээгүй юм чинь хэрэглэхгүй болчихвол яах вэ, хүлээж авахгүй бол яах вэ гэдэг асуудал.

Миний хувьд бол Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн манаач түүнээс Үндсэн хуулийг тайлбарладаг, Үндсэн хуулийг буруу байна гэж үздэг газар биш шүү дээ. Бид нарт ийм тохиолдол гарсан.

Та бас хэлж байна агуулгаар нь үзээд ингээд юм гарлаа гэж. Үндсэн хуулийн цэц өөрөө Үндсэн хуулиа тайлбарлаад л эхлэх юм бол энэ бол тэгээд Цэц дампуурч байгаагийн шинж. Бас Үндсэн хуулийн цэцийн асуудлаар ингээд мэдээлэл хийж байгаа ялангуяа тусгай албадын асуудлаар, үндэсний аюулгүй байдлын асуудлаар, хүн, ам зүйн бодлогын асуудлаар, төрийн хар хайрцгийн бодлогын асуудлаар ярьж байгаа энэ юман дээр мэргэжлийн хүмүүсийг орж тэнд хуралд нь хэлэлцүүлж яахгүй бол хариуцагч гээд Их Хурлын гишүүн нэг оруулчихдаг, нөгөөх нь тэр чиглэлийнхээ юмыг тэр хүмүүс шигээ мэргэжлийн түвшинд мэдэхгүй байж байгаад тэр асуудлыг нь унагаавал үндэсний аюулгүй байдлын ноцтой зөрчил гарчих гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энийг та одоо бас яг тэр ажлын хэсэг дээрээ бас нэлээн сайн яриарай гэж би бас ингэж хэлэх гээд байгаа юм. Одоо энэ юу бол их сайн байна. Тэр 45 хоног болгодог. Тэгэхгүй бол одоо энэ чинь ингээд бойкотлоод л байгаад байвал тэгээд л сэтэрлээд тавьчихсан юм шиг ингээд л байгаад байвал болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд хэн ч тэрэнд хариуцлага хүлээдэггүй, яадаггүй тэгээд л ингээд байгаад байдаг. Тэгээд л даалгавар өгчихсөн, тэгээд л хөдөлдөггүй, үгэнд орохгүй бол тэгээд л юм нь яваад байдаг тийм ээ ийм байдлаар. Тэгээд л эсвэл бойкотлоод хуралдаа ирдэггүй ч байдаг юм уу, нийт олонх болохгүй бол сонгохгүй ч гэдэг юм уу ингээд яваад байдаг.

Тийм учраас энэ бүх юмнууд дээр бол яг дараа дараагийн яг хэлэлцүүлгийн явцад анхаарах ёстой. Ингэж салхи оруулж өөрчлөх цаг нь болсон юм. Тэгээд би яг түрүүний хэлсэн 2 ийм асуудал дээр яах вэ? Өмнө 37 онд тэгээд аваачаад Бөмбөгөр ногоон театрт хурлыг нь хийгээд л Шар хаданд аваачаад буудчихдаг байлаа шүү дээ. Одоо бол тэгээд ингээд хэрвээ энэ цаг үед хэлмэгдүүлэлт гарах юм бол энийг чинь

яаж тэр хэлмэгдүүлсэн хүмүүс дээр хариуцлага тооцох вэ гэдгийг бид нар бас харж байхгүй бол болохгүй болчхоод байгаа юм. Энэ дээр та хариулт өгөөч.

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Цэцэд асуудал танилцуулж хариуцагчаар томилохдоо Засгийн газар сайдаараа эсвэл хуулийн төлөөлөгчөөрөө, Улсын Их Хурал гишүүнээр, гишүүнээс гадна бусад шинжээчдийг бас дагаж оролцуулж байх энэ бололцоог нээж өгч байгаа юм.

Хоёр дахь асуултад чинь хариулахад тэр Дээд шүүх юм уу шүүх тэр шийдвэрийг биелүүлэхгүй бол яах юм бэ гэдэг асуулт гарч ирж байна шүү дээ. Энэ дээр ийм зохицуулалт байгаа юм. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа юм. 25.7.6 дээр Цэц шүүхийн шийдвэрийн үйлчлэлийг түдгэлзүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3-д заасны дагуу үндсэн эрхийг хамгаалах асуудлыг шилжүүлсэн тохиолдолд, өөрөөр хэлбэл Цэц шүүхэд, Дээд шүүхэд асуудал оруулаа шүү дээ. Уг шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж, тухайн асуудлыг Цэцийн дүгнэлтийн дагуу үндсэн эрхэд нийцүүлэн хянан шийдвэрлэх, эсвэл холбогдох шүүхэд шилжүүлэх гэдэг нь Цэцийн шийдвэр үндсэн эрхийг зөрчсөн байна гэдэг Цэцийн шийдвэрийг шүүх биелүүлнэ л гэсэн үг. Тэрийг Дээд шүүх хүлээн зөвшөөрч байгаа юм. Бид нар шүүхийн шийдвэрээ эцэслэнэ, өөрсдөө эцэслэнэ. Гэхдээ үндсэн эрхийг зөрчсөн байна, Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг зөрчсөн байна гэдэг Цэцийн шийдвэрийг бид нар хүндэтгэлтэй хандана. Тэрэнд нийцүүлнэ гэж байгаа юм.

Гэхдээ тэрэнд нийцүүлнэ гэдэг нь заавал шүүхийн шийдвэрийг 100 хувь бас өөрчилнө гэсэн үг биш байхгүй юу. Нийцүүлчхээд байсан ч гэсэн шүүхийн

шийдвэр нь хэвээрээ үлдэх бололцоонууд бас байх байхгүй юу. Цөөхөн л дөө. Цөөхөн. Тэгэхдээ нийцүүлж шийдлээ тэгэхдээ энэ нь өөрөө ийм ийм заалттай юм аа, ийм ийм хуулийн ийм ийм юмтай юм. Бусдын бусад эрх ашигтай ингэж ингэж ингэж яаж байна гээд шүүхийн шийдвэр хэвээрээ үлдээх бас цөөхөн ч гэсэн онолын тийм бололцоонууд байгаа.

Тэр хэлмэгдүүлэлтийн хувьд энэ чухал асуудал. Тэгээд энэ дээр би тантай санал нэг байна. Ерөөсөө одоо манайд үйлчилж байгаа үндсэн зарчим тэр шүү дээ. Төрийн албан хаагчдынхаа буруутай үйлдлийг төр хариуцаж байгаа юм. Тийм учраас шүүх ерөөсөө нөгөө төрөө шийтгэхгүйн тулд нөгөө хүмүүстээ хариуцлага тооцож үлдээхээд, тэр хүмүүсийн үйл ажиллагаанаас гарсан эдийн болон эдийн бус хохирлуудыг төрөөр төлүүлэхгүй байгаа байхгүй юу. Энийг засахын тулд нэг том алхам хийсэн. Нямбаатар сайдын үед эдийн бус хохирлыг тооцох аргачлалыг анх удаа Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгч Дээд шүүхтэй хамтраад энэ онолын аргачлалыг нь баталсан юм. Тэгэхлээр хуучин бол Дээд шүүх яадаг байсан бэ гэхлээр сэтгэл санааны хохирлыг тооцох гэхлээр баримжаа байдаггүй. Хэдээр тооцох юм, яаж тооцох юм гээд. Тэгээд тэр бол одоо яг л тэр.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Тогтохсүрэн дарга асуултаа асууна.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Энэ Үндсэн хуулийн цэцийн хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх хууль хоёрыг нэлээн бас олон жил ярьж байгаад шинэчилсэн найруулга орж ирж байгаа юм. Манай Мөнх-Оргил гишүүнтэй ажлын хэсэг бараг жил гаран ажиллаж байгаа юм. Тэгээд би бол одоо Мөнх-Оргил гишүүн ээ зөвхөн Цэцийн хуультай холбоотой асуудлаар нь асуултаа асууя гэж бодож байна. Дараа нь хянан шийдвэрлэх хуультай холбоотой юм нь бол, Маргаан хянан шийдвэрлэх

дээр тусдаа ярих юм байна гэж бодож байна.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн гол баталгаа л даа. Манай энэ Үндсэн хуулийн гол концепцыг би тэгж ойлгож байна л даа. Өмнө нь бол Үндсэн хуулийн цэц энэ онолын, улс төрийн ийм шинжтэй байсныг илүү Үндсэн хуулийн шүүхийн шинжтэй болгож байгаа юм байна гэж ингэж ойлгож байна. Тийм.

Энэ Үндсэн хуулийн цэцийн хуулиар хоёр том харилцааг л зохицуулж байгаа л даа. Нэг нь бол энэ Цэцийн гишүүнд тавигдах шаардлагыг нарийсгах, шинэчлэх, сайжруулахтай холбоотой асуудал. Хоёр дахь нь Цэцийн бие даасан хараат бус байдалтай холбоотой асуудал байгаа юм. Би энэ Цэцийн гишүүн тавигдах шаардлагатай холбоотой асуудлаар хэдэн зүйлийг тодруулъя гэж бодож байна. Хамгийн чухал юм бол энэ байгаа юм. Ингээд Цэцийн гишүүдийг хараад л байхад ерөнхийд нь ингээд л чанар жаахан сулраад л байгаа юм. 92 онд байснаасаа ингээд сулраад яваад байгаа юм. Энд ч гэсэн олон нийт, судлаачид шүүмжлэлтэй ханддаг.

Тэгэхээр бид нар энэ хуулиар хамгийн чухал юм бол Цэцийн гишүүнд тавигдах шаардлага маш нарийн, тодорхой, процесс тодорхой болох тухай асуудал л их чухал байгаа юм. Энэнтэй холбоотой асуудал юу байна вэ гэхээр мэргэжлийн тухайд бол нөгөө Үндсэн хуульд заасан хууль зүйн, улс төрийн өндөр мэдлэгтэй, мэргэжилтэй байна гэдэг энэ заалтыг тодотгоод зөвхөн хууль зүйн дээд боловсролтой байна гээд ингээд яваад өгсөн юм харагдаж байна лээ. Энэ яах вэ энэ Үндсэн хуулийн шүүх болохтой холбоотой асуудлаараа ингэж байгаа болов уу гэж бодож байна. Үүнээс гадна хоёр том шаардлага байгаа юм.

Нэг дэх нь мэдлэг, ур чадварын асуудал байгаа юм. Энэ мэдлэг ур чадвар хамгийн том шаардлага. Энэний чиглэлээр бол хуульд ер нь нарийн юм харагдахгүй л байгаад байгаа юм. Турилагыг нь л харчхаад байгаа юм. Турилагыг нь бол энэ хараад тэрийгээ мэдлэг ур чадвар гэж хараад байгаа юм. Тэр нь мэдлэг ур чадварынх нь шаардлагыг тавигддаг асуудал их чухал байгаа юм.

Хоёр дахь асуудал нь ёс зүйн асуудал байгаа юм. Бид чинь ёс зүйн тухай их олон ярьдаг. Энэ Цэцийн гишүүн их өндөр ёс суртахуунтай байх ёстой. Тийм учраас энэ ёс зүйн чиглэлээр тавигдах шаардлагын асуудал байгаа юм.

Дараагийн юм нь юу байна вэ гэхээр Цэцийн гишүүд хориглодог зүйл. Энийг тодорхой болгож өгөх ёстой. Энийг хэр тодорхой болгосон бол?

Дөрөв дэх асуудал нь хариуцлагын асуудал байгаа юм. Бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, эргүүлэн татах, өөр бусад хариуцлагын асуудлуудыг яг тодорхой оруулж өгсөн үү, үгүй юү? Цэцийн гишүүний настай холбоотой асуудлаар бас олон жил бид нар маргаад л явдаг. Би бодвол Цэцийн гишүүнийг ингэж л ойлгож орж ирлээ гэж ойлгож байгаа шүү дээ. 65 хүрээгүй бол томилогдож болно. 65-аас хэтэрчихсэн байсан ч гэсэн бүрэн эрхээ дуусгана гэдэг ийм л логик явж байгаа юм байна л гэж ойлгож байгаа. Нэг зүйлээр ингээд хориглочих юм. Юм л бол энэ улс төрийн албан тушаалуудыг ерөөсөө юм бүгд хорьдог болжээ. Энүүгээр бас хориод хаячихсан улс төрийн албан тушаалтнуудыг. Юу байна вэ гэхээр ер нь энэ парламентад ч юм уу, улс төрд бол Монголын ард түмэн арай гайгүй гэснээ л нэр дэвшүүлээд л тэгээд л сонгуульд ялаад л парламентад ч бай, Засгийн газарт ч бай ажиллаж байгаа шүү дээ.

Гэтэл нөгөө улс төрчдөө дараа нь юманд очихоор ингээд хориод хаячих юм. Манай энэ өмнөх парламентад ч байсан, одоо байгаа, олон парламентад байгаа туршлагатай маш сайн хуульчид, төрийн зүтгэлтнүүд байна. Одоо эдгээрийг бүгдийг нь хаачхаж байгаа байхгүй юу. Яагаад гэхээр улс төрийн албан тушаал хашиж байсан бол 5 жил ийш очихгүй гээд хаачхаж байгаа юм. Тийм, тэгээд энийг би бол нээж өгөх ёстой байхгүй юу. Парламент чинь энэ чинь хууль боловсруулж байгаа, баталж байгаа газар тэнд мундаг Мөнх-Оргил гишүүн өөрөөс нь эхлээд.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Хууль зүйн, улс төрийн өндөр мэргэжилтэй гэдгийг тодотгоогүй байна гэж байгаа юм. Бид нар янз янзын хувилбарууд л үзсэн л дээ. Тэгээд их зовлонтой юм байна лээ. Яг хууль зүйн өндөр мэргэшил гэхлээр чинь яг ямар болчхоод тэр хүн өндөр болчих вэ гэдэг чинь асуудалтай болчхоод байгаа байхгүй юу. Жишээ нь, улс төрийн өндөр мэргэжилтэй гэж байгаа юм. Манай түүхэнд Монгол Улсын Ерөнхийлөгч байсан хүн байсан Их Хурлын дэд дарга байсан хүн, Их Хурлын гишүүд байсан хүмүүс эд нар бол улс төрийн өндөр мэргэжилтэй гэдэг дээр маргаан гарахгүй л дээ.

Гэтэл юу гэдэг юм Их Хурлын гишүүнээр 1 удаа сонгогдчихвол улс төрийн өндөр мэргэжилтэй болчихдог, 4 удаа сонгогдвол улс төрийн өндөр мэргэшил нь бүүр бүүр өндөр мэргэжилтэй, 1 ч удаа сонгогдвол улс төрийн өндөр мэргэжилд хүрэхгүй ч юм уу ингээд хуулиар хайрцаглахад аягүй хэцүү болчхоод байгаа байхгүй юу. Бололцоогүй.

Тэгэхлээр бид нар Үндсэн хуулийн энэ шаардлагаар нь үлдээе. Энэ дээрээ хууль зүйн боловсролтой байя гэдэг л нэг л заалт нэмж байгаа юм. Хууль зүйн боловсролтой. Яагаад гэвэл нөгөө үндсэн эрхийн маргаан хэлэлцэх учраас. Мэргэжилтэй биш. Хууль зүйн боловсролтой байх ёстой байхгүй юу. Тэгэхдээ өөр ажил хийж байж болно шүү дээ. Боловсрол нь л тийм байх ёстой гэсэн санаа байгаа юм.

Мэдлэг, ёс зүйн өндөр шаардлага тавих асуудлаар бид нар их, энэ өргөн барьсан төсөл хүрэн хүртлээ хэд хэдэн заалт байсан. Ёс зүй ийм ийм шаардлага хангасан, мэдлэг боловсрол ийм ийм ийм гээд. Тэгээд энэ хуулийн төсөл дээр санал авах явцад Цэцээс, Дээд шүүхээс, Ерөнхий прокурорын газраас, Хуульчдын холбооноос энэ тэр гээд саналууд ирсэн. Энэ санал дээр мэргэжлийн байгууллагууд ихэнхдээ юу гэж санал өгсөн бэ гэхлээр үгүй тэрийгээ та нар Их Хурал дээрээ л өөрсдөө хар л даа. Үндсэн хууль дээр энэ чинь маш ойлгомжтой хэлчихсэн байна шүү дээ. Хууль зүй улс төрийн өндөр мэргэжилтэй 40 нас хүрсэн гэдэг дотор тэр хүний ёс зүй, мэдлэг боловсрол нь хүрч байна уу, үгүй юү гэдгийг та нар л шүүх гэж бид нар тэр эрхийг чинь та нар Улсын Их Хуралд өгчихсөн байгаа шүү дээ. Тэрийгээ л үгүй тэгээд нэр дэвшүүлж байгаа хүн буруу хүн оруулчихвал Улсын Их Хурал тэрийг нь зөвшөөрөхгүй л байх бүрэн эрх нь байгаа байхгүй юу.

Тэгэхлээр бид нар нөгөө нэр дэвшүүлж байгаа субъектүүдийн оруулж ирсэн юунд нь өөрсдөө босго тавьж өгөхгүй, өөрсдөө бид нар босгоод давуулчхаад л байгаадаа л байгаа юм л даа.

Хориглох зүйл эд нар нэлээн дэлгэрэнгүй болсон. Тэгээд энэ дээр энэ чинь нөгөө Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль эд нар чинь бүгд л Цэцийн гишүүддээ үйлчилнэ шүү дээ. Тэр сүүлийн



4 жилийн хугацаанд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрх.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Нямаагийн Энхболд гишүүн асууна. Тодруулах байсан уу? Тогтохсүрэн гишүүн тодруулга 1 минут.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Би түрүүн асууж амжаагүй юм. Хоёр зүйлийг маш товчхон асуучихъя.

Хоёр дахь нь энэ Цэцийн хараат бус, бие даасан байдалтай холбоотой асуудал байхгүй юу. Тэр нь Цэцийн хараат бус байдлыг хамгаалах, хараат бус байдлыг нь хамгаалах нөгөө үйл ажиллагаа, бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад нь энийг ер нь яаж шинэлэг зохицуулалт оруулав аа? Хамгийн чухал юм нь энэ байгаа юм.

Хоёр дахь юм нь Цэцээ бид нар их өндөр чадавхтай байлгахын тулд ажлын албыг нь бэхжүүлж өгөх ёстой юм. Тэгээд энэ хууль батлагдсантай холбогдуулаад орон тоо, ажлын албыг нь бэхжүүлэхтэй холбоотой, ялангуяа судалгаа, эрдэм шинжилгээ энэ чиглэл рүү нь бас нэлээд хэмжээгээр бас гаднын юмыг судлах ийм шаардлагатай учраас энэ чиглэлийнх нь энэ энэ бүтэц, орон тоо энэ юмнууд нь тусгагдаж өгсөн үү гэдэг ийм хоёр зүйлийг тодруулъя.

**С.Одонтуяа:** Хууль санаачлагч Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Өргөн барьсан гол хуультай хавсаргаад Дагаж мөрдөх журмын тухай хууль өргөн барьж байгаа. Энэ дээр энэ асуудлууд туссан байгаа. Дээр нь энэ ажлын албыг бэхжүүлэх асуудал дээр би би нэг том санал орсон гэж бодож байгаа. Тэн дээр одоо та нар маань дэмжих байх гэж найдаж байгаа юм. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын ажилтнуудын цалин хөлсийг Улсын Их Хурал тогтоодог болъё. Улсын Их Хурал

тогтоохдоо Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын түвшинд тогтоож байна. Нэг түвшинд аваачаад. Тэгэх юм бол одоо энэ Цэцийн Тамгын газрын ажилтнуудын цалин хөлс Улсын Их Хурлын Тамгын газрын цалинтай дүйцэж очих юм.

Хараат бус байдлыг бэхжүүлэх тал дээр нэлээн зүйл орсон. Өмнөх жилийн төсвийг нь багасгаж болохгүй. Тэр гол миний бодлоор энэ хараат бусыг бэхжүүлж байгаа зүйл бол 6 жилээр томилоод, дахиж 1 удаа улируулан томилох асуудал. Энэ бол өөрөө энэ хараат бус байдалд нь бэхжүүлэхэд их чухал үүрэг нөлөө үзүүлнэ гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр энэ хараат бус байдлыг бэхжүүлэх бүхэл бүтэн 4 дүгээр бүлэг орсон байгаа. 3 дугаар бүлэг Цэц түүний гишүүний хараат бус байдал гээд. Энэ дотор нөлөөллийн мэдүүлгийн асуудал байгаа, эдийн засаг, нийгмийн баталгааны асуудал байгаа. Цэцийн нөгөө байгууллагынх нь хувьд хараат бус байлгах талаар 17 дугаар зүйл гэж орсон байгаа. 18 дугаар зүйл Цэцийн төсөв, санхүүгийн баталгаа гэж зүйл орсон байгаа.

**С.Одонтуяа:** Энхболд гишүүн тодруулах юм уу? Тодруулга 1 минут.

Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя.

**Н.Энхболд:** Баярлалаа. Би ганцхан асуулт асуух гэсэн юм. Ерөнхийдөө би энэ Цэцийн тухай, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүдийг хэлэлцээд болж өгвөл энэ чуулганаараа баталчих юм сан гэсэн ийм байр суурьтай байгаа.

Түрүүн юуны асуултад хариулахдаа Мөнх-Оргил гишүүн хэлж байна лээ. Энэ бас тэр болгон бүрдээд байхгүй ийм яг тодорхой түүхэн нөхцөл байдал, нийгмийн уур амьсгал, ялангуяа салбарынхны дунд үүссэн ойлголцол ийм бүрдчихлээ. Тэгэхээр энэ үед батлаад

авахгүй бол дахиад цаг алдана гэсэн энэ үндэслэлтэй нь бол би бүрэн дүүрэн санал нийлж байгаа. Дараагийн Их Хурал гарч ирээд энэ 32 жил Цэцийг тойрсон, салбарт хуримтлагдсан асуудлуудыг дахиад судлаад нэгдсэн ойлголтод хүрнэ гэхэд бол бас л их цаг алдах ийм зүйл болох болов уу гэж ингэж бодоод байгаа юм.

Одоо ингээд гишүүдийн юунаас харж байхад гол маргаантай асуудал ерөөсөө хүний үндсэн эрхтэй Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрхтэй холбоотой асуудлыг тойрсон зүйлүүд их гарч байна. Ингэхээс ч өөр арга байхгүй. Цоо шинээр ороод ирсэн учраас. Бусад тэр процедуртай холбоотой, гишүүнтэй холбоотой, тэр томилгоо элдэв янзын зохион байгуулалтын асуудалтай зүйлүүд нь бол их маргаан дагуулахгүй явчих болов уу л гэж бодож байгаа юм. Энэ манай Ардчилсан намынхан завсарлага авч байгаа юм байна. Бас ярихаар ойлголтууд авах болов уу гэж бодож байна. Бид нар манай нам дээр сүүлийн 3 жил 800-гаад хуульд, бүх хуульд ингээд дүн шинжилгээ хийгээд үзэхэд 840 гаруй хуульд хүний эрхийн зөрчилтэй холбоотой заалтууд байна гэсэн ийм дүгнэлт гарсан юм. Тэрний дагуу хийгдэж байгаа ажлуудын олон ажил бий. Одоо бид нарын баталсан олон хуульд тэр судалгаануудаар гарсан заалтууд орж хөндөгдсөн, өөрчлөгдсөн зүйлүүд байгаа. Тэгээд энэнээс харахад ч гэсэн үнэхээр Цэц дээр юм уу аль нэг газар хүний үндсэн эрхийг хамгаалдаг энэ тогтолцоог, зохицуулалтуудыг хийхгүй бол болохгүй нь гэдэг ийм 32 жилийн дүгнэлттэй бид нарын хийсэн судалгаа зориод байгаа юм шиг нийлж байгаа юм.

Тэгээд миний асуулт юу вэ гэхээр ингээд хэлэлцэх эсэхээ шийдчихлээ гэж бодъё тийм ээ Мөнх-Оргил гишүүн ээ. Тэгээд хэрэв энэ хүний үндсэн эрхийг тойрсон асуудал, яг гишүүдийн асуугаад байгаа шиг энэ асуудлууд яригдаад энэнээс болоод энэ хоёр хууль явахгүй болоод ирвэл жишээ нь, хууль

санаачлагчдын зүгээс, ажлын хэсгийн зүгээс энэ зүйлүүдээ яг ямар хүрээ, аль хязгаар хүртэл заримаас нь татгалзаж болох вэ? Бүүр аваад хаячихвал харамсалтай байна л даа. Яг энэнтэй холбоотой асуудлаар яг энэнээс цааш бол уг нь явмааргүй байгаа юм даа. Ядаж энэ хүртэл нь зогсоогоод эхний алхмыг нь хийчихмээр байна гэдэг тийм юу гэдэг юм бэ дээ төсөл санаачлагчдын тийм юмнуудаа өөрчилж, татгалзаж болох уу гэдэг нэг ийм асуулт байна. Төрүүлсэн хүүхдийнх нь тухай асуухаар хариулахад хэцүү байж магадгүй. Гэхдээ энийг асуугаад, ойлголцоод явбал магадгүй хоёр хуулиа бүүр шийдэхгүй орхисноос арай наагуур нь бас дундыг баримтлаад шийдчих хувилбар байх юм болов уу даа гэж би дотроо бодож сууна.

Тэгэхээр би саяын, энэ ердөө л миний ганц асуулт. Тэгээд ер нь ингээд энэ нийгмийн, эдийн засгийн, хуулийн шинжлэх ухаанууд бол байгалийн хууль шиг ингээд л физикийн, химийн хуулиуд шиг ямар ч тохиолдолд нэг урвал, үзэгдэл, томъёонд эцсийн үр дүн нь яг хэвээрээ байдаг ийм зүйлүүд биш л дээ. Нийгмийн хөгжлийн шаардлагын дагуу заавал өөрчлөгдөж, магадгүй нийгмийн шинжлэх ухаануудын ганц өөрчилж болохгүй ойлголцдог үнэн зүйл нь бол нийгмийн, улс төрийн, амьдралын шаардлагаар цаг үе тухайн хэрдээ тохирсон өөрчлөлт ийм хуулиудад заавал орж байх ёстой гэдэг ийм хуулиуд заавал орж байх ёстой гэдэг нэг ийм.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Цэндийн Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Хэдүүлээ Улсын Их Хурал дээр яриад үндсэн эрхийн маргааныг Цэцээр хэлэлцүүлдэг болно гэж шийдэх юм бол ерөөсөө яг энэ хэлбэрээрээ л явна. Энд бол илүү юм ерөөсөө байхгүй. Үндсэн эрхийн маргаан шийдлээ, шүүхэд өглөө, гол асуудал бол шүүх яах вэ л гэдэг асуудал байсан байхгүй юу. Тэрийг Дээд

шүүх хэлэлцээд бид нар яг ийм процессоор шийднэ асуудал байхгүй гээд хэлчихсэн байхгүй юу. Өмнө нь Дээд шүүх тэгдэггүй байсан байхгүй юу. Юу яриад байгаа юм бэ, Дээд шүүхийн шийдвэрийг хэлэлцдэг юу байдаг юм, 4 шатын шүүх гээд. Одоо бол Дээд шүүх тэгэхгүй байгаа байхгүй юу. Үндсэн хуульд ийм заалт байхад бид нар энэ заалтыг ашиглаад хүний эрхийг тэр Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг бүх эрх нь биш шүү дээ. Бүх эрх нь биш. Улс төр, улс төрийн эрхүүдийг л яриад байгаа шүү дээ бид нар. Тэрнээс биш бүх эрхүүдийг нь яриагүй байхгүй юу. Үгүй гэх юм бол ерөөсөө үндсэн эрхийг тэр хүртэл нь оруулаад, тэр хүртэл нь хасна гэсэн заалт байхгүй болчихно л доо. Бүхэлд нь авч хаяад л яг өнөөдрийнх шиг болгоод л. Одоо бид нарын оруулж байгаа энэ нөгөө томилгооны асуудлууд, баталгааны асуудлууд гэсэн нөгөө харьцангуй техникийн чанартай зохицуулалтууд байна шүү дээ. Энийгээ батлаад явах юм бол Цэцийн үйл ажиллагаа нь мэдээж том дэвшил гарна.

Гэхдээ үндсэн эрхийн маргааныг оруулж байж Цэц жинхэнэ утгаараа Үндсэн хуулийн манаач болно гэж би бол жишээ нь, хувьдаа итгэлтэй байгаа. Үндсэн хууль үндсэн хоёрхон асуудал зохицуулж байна шүү дээ. Иргэний үндсэн эрх, эрх чөлөө юу юм бэ гэдгийг баталгаажуулж өгч байна. Өөрөөр хэлбэл төр иргэн хоёрын харилцааг баталгаажуулж өгч байна.

Хоёр дахь асуудал нь төрийн тогтолцоо буюу төр нь өөрөө ямар байх юм бэ гэдэг л асуудлыг шийдэж өгч байна шүү дээ. Тэгэхлээр одоо болтол 32 жил Цэц ямар ажил хийсэн бэ гэхлээр төрийн тогтолцоо Улсын Их Хурлын гаргаж байгаа хууль Үндсэн хуультай нийцэж байна уу, төрийн тогтолцооны асуудлууд. Тэр иргэний үндсэн эрх тухайн шийдвэрээр зөрчигдөж байна уу, үгүй юү гэдэг тэр том асуудал бол Цэцийн хяналтаас гадуур үлдчихсэн байхгүй юу.

Жишээ хэлэхэд Германы Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны 95 хувь нь үндсэн эрхийн маргаан. Тэр иргэн Дорж, иргэн Долгорын Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрх зөрчигдөж үү, үгүй юү гэдгийг л тэр Үндсэн хуулийн шүүх нь хянаж байгаа болохоос биш, тэр нөгөө бусад асуудлууд нь 5-хан хувь байхгүй юу. Манайх бол ерөөсөө яг эсрэгээрээ болчихсон. 100 хувь нь л улс төрийн шийдвэрүүдтэй л холбоотой асуудлууд.

Тэгэхлээр энэ өөрөө Цэц улс төрийн байгууллага болох том хардлага, хандлага сүүлийн 10 жил ажиглагдаад байгаа байхгүй юу. Ерөөсөө улс төрийн. Манай гишүүд бүгд л ярьж байна шүү дээ. Захиалгаар шийдвэр гаргадаг, эсвэл улс төрийн хүрээнд Улсын Их Хурал дотор шийдэж чадаагүй маргаануудыг Цэц дээр аваачиж шийдүүлдэг улс төрийн байгууллага болох гээд байгаа юм. Тэгэхлээр энэ жинхэнэ утгаар нь шүүхийн байгууллага болгоход тэр бололцоо хэрэгтэй байна.

Уул нь ингээд хийчих юм бол бид нар 32 жилийн туршид хуримтлуулсан энэ алдаа дутагдал, онолоо судалж үзсэнийхээ үр дүнд шийдвэр гаргачихвал хэрэгтэй л байгаа юм. Том дэвшил болно.../минут дуусав./

**С.Одонтуяа:** 1 минут тодруулъя. Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Ингэж ойлголоо Мөнх-Оргил гишүүн ээ миний ойлголт зөв үү? Хоёр хуулиа ямар ч байсан явуулъя. Үндсэн эрхтэй холбоотой асуудал эс үгүй бол одоо байгаагаар нь, эс үгүй бол тийм бүрэн хасагдах нь. Гэхдээ энэ хоёр хуулийг баталчихсан байхад Цэцийн ядаж зохион байгуулалтын усад талаасаа олон асуудал өнөөдөр хуримтлагдчихаад байгаа тийм асуудлуудыг шийдэх боломж бүрдэнэ гэсэн ийм л л хууль орж байна гэж би ойлгож байна.

Тэгэх нь, би хасах тал дээр нь ерөөсөө байхгүй байгаа. Байвал тэн дээр нь л явна биз дээ тийм ээ? Сайн л байна. Үгүй ядаж энэ хоёр хуулиа та тэр энд тэнд очиж тайлбарлахдаа яах вэ мэдээж энийгээ хасчихъя гэж хэлэхгүй л дээ. Тэгэхдээ хөөе хуулиа явуулаад. Одоо өнөөдөр гэхэд Цэц дээр асуудал тулчихсан. Бид нар сонин л байдалтай байж байгаа шүү дээ. Ядаж энийгээ ишийдэх хэрэгтэй юм биш үү гэдэг талаас нь бас хэлээрэй л гэж.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Би хоёр зүйл асуучихъя.

Гишүүдийн асуусан асуулт, хариултыг их анхааралтай сонслоо. Хоёр зүйлийг асуух гэсэн юм. Нэг нь энэ 14.10-д Цэцийн гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд илэрхийлсэн санал, шийдвэрийнх нь төлөө тухайн хүнийг аливаа хариуцлагад татахыг хориглоно гэсэн ийм заалт байгаа. Тэгэхээр энэ хүн чинь жишээлэхэд төрийн эсрэг гэмт хэрэг хийсэн юм уу, ноцтой алдаа гаргасан бол ингээд энэ хүнийг хариуцлагад татахыг хориглох юм уу?

Жишээлэхэд, өнгөрсөн хугацаанд маш олон асуудал дээр Цэц бол үнэхээр шийдвэрээрээ самарсан шүү дээ. Жишээлэхэд тэр нарийн царигийн асуудал байна, дээрээс нь тэр давхар дээлийн асуудал байна, Сонгуулийн хууль байна, саяын таны хэлсэн тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн бүрэлдэхүүн хэсэг гэж авч үзэхгүйгээр агуулгынх нь хувьд хянаад зөрчсөн байна гэх мэтчилэн ийм маш том том алдааг захиалгаар гаргаж байсан. Тэгэхээр энэ тал дээр хариулт хэлж өгөөч. Энэ арай л болохгүй юм шиг санагдах юм. Хүн бол тэгвэл дураараа дургиж байгаад л надад хэн ч хариуцлага тооцохгүй гээд ингээд явчих юм уу?

Хоёр дахь асуудал бол энэ хэлмэгдүүлэлттэй холбоотой юм. Одоо миний энэ хэлмэгдүүлэлтийн асуудал хариуцсан юу бол зөвхөн 1990 оноос

өмнөх асуудал байхгүй юу. Тэгэхээр одоо 1990 оноос хойших асуудлыг зохицуулах гээд бид нар хуульчидтай энэ бүх зүйлийг ярилцаж байна л даа. Тэгэхээр энэ дээр хөөн хэлэлцэх хугацаа гэж байх уу. Иргэн гомдол гаргалаа. Өөрөөр хэлбэл төрийн буруутай үйл ажиллагаанаас болоод нийтийг хамарсан ийм хэлмэгдүүлэлт болоход тэр хөөн хэлэлцэх хугацаа гэж байх уу? Ер нь энэ иргэний маргаан дээр?

Өөрөөр хэлбэл, тухайн төр барьж байгаа үед хүн тэр маргааныг шийдвэрлүүлэх боломжгүй байдаг учраас нэлээн олон жилийн дараа энэ асуудлууд гарч ирдэг. Тэгэхээр энэ дээр тэр нийтийг хамарсан ийм асуудал дээр, хоёрт хөөн хэлэлцэх хугацаа.

Дээрээс нь энэ 90 хоног гэхээр чинь арай удаан шийдвэрлэх үү? Дахиад 90 хоногоор сунгаж болно гэхээр энэ маргаанууд чинь их л сунжрах юм шиг санагдаад байгаа юм.

Түүрүүн та бас хэллээ. Тэр шийдвэрийн үндэслэл, ил тод байдал ерөөсөө хангалтгүй байдаг гэж. Тэр баахан хүмүүсийн хэлсэн үгийг бичиж бичиж байснаа л Цэц ингэж шийдвэрлэлээ гээд. Тэгэхээр энийг ахиулсан ийм зүйл хуульд харагдахгүй байх юм. Энэ гурав дээр хариулж өгөөч.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Тэр 90 хоног дээр би эхлээд товчхон хариулчихъя. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс жишээ нь, хугацаагүй. Хэдэн ч хоног, хэдэн ч сарын дараа шийдвэрээ гаргаж болно. Хуралдчихаад, тэд нар яадаг вэ гэхлээр хуралдчихаад бид нар шийдвэрээ гаргана та нар байж байгаарай гээд явчихна. Солонгост бол 180 хоног. Бид нар 30 гээд шахчихлаар нөгөө үндэслэл бичиж чадахгүй байгаа чинь ерөөсөө тэрнээс үүдээд байгаа байхгүй юу.

Жишээ нь, саяын тэр Үндсэн хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуультай нийцэж

байна уу, үгүй юу гэдэг агуулгын хувьд Үндсэн хуулийн цэц хянах уу, үгүй юу гэдэг бол жишээ нь, Монголд байтугай дэлхий даяараа онолын болон практикийн асар том маргаан дагуулсан асуудал байхгүй юу. Тэгэхлээр тэрийг 30 хоногийн дотор хэн ч үндэслэл гаргаад чадахгүй. Бид нар шахаад байгаа учраас тэд нар чинь нөгөө үндэслэлгүй юм бичээд байгаа байхгүй юу.

Тэгэхлээр 90 хоног би ер нь бага талтай гэж бодож байгаа юм. Тэгэхдээ 90 хоногтоо хүргэ гэсэн үг биш шүү дээ. 90 хоногийн дотор. Цаад талын хугацаа нь 90. Үнэхээр чадахгүй байгаа бол ахиад 90 хоногоор сунга гэж байгаа юм.

Тэр 14.10 ийм учиртай Цэцийн гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд гэж байгаа юм шүү Одонтуяа гишүүн ээ, бүрэн эрхийнхээ хүрээнд өөрөөр хэлбэл ажлаа хийж байхад л. Тэрнээс биш хүн зодчихдог ч юм уу, цохичихдог ч юм уу тэр гэмт хэрэг явдгаараа явна. Бүрэн эрхийнхээ хүрээнд илэрхийлсэн санал, гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй. Тэгэхгүй бол шийдвэр гарахгүй шүү дээ. Тийм. Улсын Их Хурал ч гэсэн адилхан шүү дээ. Та бид нар ч гэсэн өнөөдөр хууль баталчихдаг. 10 жилийн дараа чи улс орны эрх ашгийн эсрэг хууль баталсан байна гээд та бид нарыг эрүүгийн хариуцлага татдаггүй, захиргааны хариуцлага татдаггүйтэй адилхан байхгүй юу.

Яагаад гэвэл нэгдүгээрт хамтын байгууллага, хоёрдугаарт ямар нэгэн нөлөөлөлгүйгээр ирээдүй, өмнөх хойчоосоо айхгүйгээр өөрийнхөө итгэл үнэмшил дээр үндэслэж, шийдвэр гаргах бололцоог л гаргаж өгч байгаа байхгүй юу. Шүүхийн хуульд ч гэсэн ийм заалт байгаа юм. Шүүгч шүүхийн шийдвэр гаргахдаа тэр гаргасан шийдвэрийнхээ төлөө ямар нэгэн эрүүгийн хариуцлага хүлээхгүй.

Харин таны саяын хэлж байгаа шиг шийдвэр гаргахдаа авлигал хээл

хахууль авсан, авлигал хээл хахууль авсан, эсвэл бусдын буруу нөлөөнд өртсөн тийм үндэслэл тогтоох юм бол тэр хүн эрүүгийн болон бусад хариуцлагаа хүлээнэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тийм үндэслэл илрэх юм бол Цэц шийдвэрээ эргэж харна шүү дээ. Цэцийн шийдвэр гарчихлаар ахиж хэзээ ч эргэж хардаггүй гэж бид нар ойлгоод байгаа байхгүй юу. Үгүй. Цэцийн хуульд чинь тодорхой заалт одоо ч гэсэн байгаа. Одоо энэ бид нар батлах гэж байгаа хуульд ч гэсэн орсон байгаа. Цэц өөрийнхөө шийдвэрийг эргэж харах үндэслэл байгаа байхгүй юу. Тэр нь нарийн процесслогдоогүй, процессыг нь нарийн бичээгүй учраас л гардаггүй. Түрүүн жишээ нь, түрүүн хэн хэлчхэв дээ? Цогтгэрэл гишүүн хэлсэн. Нэг асуудлаар хоёр шийдвэр гаргаад гэж байгаа юм. Болно шүү дээ. Цэц алдаатай шийдвэр гаргачихсан байх юм бол алдаагаа засаж болох байхгүй юу. Тэгэхлээр хариуцлага бол байдгаараа байна.

Харин ажлаа хийсний төлөө, итгэл үнэмшлийнхээ төлөө, итгэл үнэмшил дээрээ үндэслэж ямар нэгэн нөлөөнд авталгүйгээр.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Дуусгаж хариулъя. Хөөн хэлэлцэх.

**Ц.Мөнх-Оргил:** Хөөн хэлэлцэх хугацааны талаар та их чухал асуулт асуулаа. Энэ ийм юм болно. Хэрвээ хууль Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг асуудал ярих юм бол хугацаагүй. Хэзээ ч гарч болно. Өөрөөр хэлбэл, таны асуусан нийтийг хамарсан заалт байна шүү дээ. Тэр бол хугацаагүй.

Харин тухайн иргэн жишээ нь, иргэн Мөнх-Оргилтой холбоотой захиргааны шийдвэр ч юм уу, сайдын тушаал ч юм уу юм гараад тэрийг шүүхэд маргалдуулж байгаа бол тэр хугацаатай. Яг нөгөө Захиргааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх журмын хуулиар

юу гэдэг юм сайдын тушаал гараад 10 жилийн дараа би энийг хэлэлцүүлбэ гээд орж ирдэггүй шүү дээ. Тэрэнтэй л адилхан. Шүүхийн процесстойгоо адилхан явна. Хууль нийтийг хамарсан шийдвэрүүд дээр хугацаа байхгүй. Яагаад гэвэл буруу үр дагавар нь хэзээ ч илэрч магадгүй учраас.

**С.Одонтуяа:** Тэрийгээ яг хуульд яг зааж өгсөн байгаа юм уу тээ?

**Ц.Мөнх-Оргил:** Байгаа.

**С.Одонтуяа:** Тэн дээр төрийн буруутай үйл ажиллагааны улмаас энэ тэр гэсэн заалтууд бий юу?

**Ц.Мөнх-Оргил:** Тэр бол тусдаа хуулиар явж байгаа шүү дээ.

**С.Одонтуяа:** Тусдаа юу тээ. Яг тусдаа ямар хуулиар явах вэ?

**Ц.Мөнх-Оргил:** Тэр бол. Цэцийн хуулиар зохицуулагдахгүй асуудал. Тэр бол Эрүүгийн хуулиараа явна, Иргэний хуулиараа явна, Захиргааны хуулиараа явна.

**С.Одонтуяа:** Үгүй ээ би төрийн буруутай үйл ажиллагааны улмаас нийтийг хамарсан ийм хэлмэгдүүлэлт гарахад хүмүүс Цэцэд хандлаа шүү дээ. Тэгэх тохиолдлыг л асууж байгаа.

**Ц.Мөнх-Оргил:** Тэр бол хугацаагүй шүү дээ. Нийтэд хамаарч байгаа учраас. Яг Мөнх-Оргилд биш, Энхболдод биш, Одонтуяад биш. Нийтэд хамарсан үйлчилж байгаа юман дээр бол хугацаа байхгүй.

**С.Одонтуяа:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ардчилсан намын бүлэг завсарлага авах хүсэлт. Харин гишүүд ингэсэн юм түрүүн үг хэлэх юугаа дараа нь ирээд авъя гээд. Гишүүд бүгд зөвшөөрлөө аваад цайндаа орчихсон. Бүгд үг хэлэх

хүсэлтэй. Тэгэхээр тэрийг дараагийн хурал руу шилжүүлбэ.

Ингээд Ардчилсан намын бүлэгт ажлын 5 хоногийн завсарлага өглөө. Цогтгэрэл дарга заавал 5 авна. Амжихгүй гэнэ ээ? Том хууль амжихгүй ээ гэнэ.

13.26 цаг

Баасан гараг, 22 Гуравдугаар сар 2024  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
14 цаг 07 минут.

## ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**С.Одонтуяа:** Үдээс хойших хуралдаан эхэлснийг мэдэгдье.

**Үдээс хойших хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсууриас Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэд хандаж эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар тавьсан асуулгын хариуг сонсоно.**

Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар мэдээллийг Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн хариулна. Индэрт урьж байна.

**Б.Чойжилсүрэн:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсууриас Тавантолгойн 450 мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын төслийн талаар асуулга ирүүлсний дагуу та бүхэнд товч мэдээллийг хүргэе.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 71 дүгээр тогтоолоор Тавантолгойн цахилгаан станцын төслийн нэгж байгуулах, санхүүжүүлэх төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээг

хийлгэх, холбогдох судалгааг хийлгэх үүргийг өгч, төслийг эхлүүлж байсан ба төслийн бэлтгэл шатад төслийн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг шалгаруулж, Монгол Улсын Засгийн газар төслийн компани болох “Тавантолгойн цахилгаан станц” ХХК болон “Эм Си Эс повер” ХХК-ийн хооронд Тавантолгой цахилгаан станц төслийг хөрөнгө оруулалтын гэрээг 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдөр байгуулж байсан билээ.

Төслийг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтыг олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авах замаар босгох нөхцөлийг бүрдүүлэхэд ирээдүйн гол хэрэглэгч болох “Рио Тинто” ХХК-ийн эрчим хүчний төлбөрийн баталгаа гаргах. “Оюу-Толгой” ХХК болон “Тавантолгой цахилгаан станц” ХХК компаниуд эрчим хүч худалдах, худалдан авах үнийг харилцан тохиролцох асуудал шийдэгдээгүйн улмаас 2016 оноос хойш төсөл хүлээлтийн байдалд орсон бөгөөд төслийн хөгжүүлэлтийн үе шат удааширалтай байсан тул 2017 онд гадаадын хөрөнгө оруулагч “Marubeni” корпорац төслөөс гарч байгаагаа мэдэгдсэн байна.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор өмнөд бүсийн уул уурхайн болон Оюу-Толгой төслийн эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх төрийн өмчит “Тавантолгой дулааны цахилгаан станц” ХХК-ийг байгуулж, төслийн санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэхийг Сангийн яам “Эрдэнэс Тавантолгой” ХК-д даалгасан.

Тус тогтоолын дагуу “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК нь 2020 оны 10 дугаар сард байгуулагдан төслийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Төслийн хүрээнд доор дурдсан барилга байгууламжууд баригдана. Үүнд:

3 блок бүхий 450, 3-ыг үржих 150мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, “Тавантолгой”, “Оюу толгой” дэд станц руу чиглэсэн хоёр хэлхээ 220 киловольтын 167км цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станц, станцын усан хангамжийн барилга, байгууламжийг тус тус барих төлөвлөгөөтэй.

Тавантолгойн 450 мвт-ын хүчин чадалтай цахилгаан станцын ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан ба Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 132 дугаар тогтоолын дагуу Тавантолгойн 450 мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц төслийг санхүү, хөрөнгө оруулалтын нөхцөл байдалтай уялдуулан 300 дээр нэмэх нь 150 мвт хүчин чадалтай хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр болсон.

Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр 2021 оны 10 дугаар сар болон 2022 оны 5 дугаар саруудад тус тус зарлаж байсан бөгөөд тухайн тендерүүдэд тус бүр 1 оролцогч оролцож, техникийн шаардлага хангаагүй санал ирүүлснээс тус тендерүүд амжилтгүй болж байсан байна.

Тендер амжилтгүй болсон шалтгаануудыг судлан үзэхэд дараах асуудлууд байсан байна. Үүнд:

1.Тендерт оролцогч компаниуд нь төслийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, төлбөрийг нүүрсээр авах оффтейк нөхцөлтэй санал ирүүлсэн нь Монгол Улсын Засгийн газраас нүүрсийг барьцаалах буюу нүүрс борлуулсан орлогоор санхүүжих оффтейк гэрээг хязгаарлах арга хэмжээтэй давхцаж,

тус нөхцөлөөр цааш төслийг бас хэрэгжүүлэх боломжгүй байдалтай тулгарсан.

2. 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Жиньпин Хятад улс нь гадаад улс оронд хатуу түлшээр галладаг цахилгаан эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төслийг санхүүжүүлэхгүй гэж мэдэгдсэн. Үүний дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэстний хөгжил шинэтгэлийн хорооноос ТӨК-удад гадаад улс оронд нүүрсээр ажилладаг цахилгаан эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төсөлд санхүүжилт хийхгүй, зөвхөн барилга угсралтын ажилд туслан гүйцэтгэгчээр оролцох хязгаарлалтыг тавьсан ба энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудаас төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллах боломжгүй. Зөвхөн туслан гүйцэтгэгчээр ажиллах боломжтой талаар дурдаж, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн байдаг.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулан нүүрсээр ажиллах цахилгаан станцын төслийг санхүүжүүлэхээс засгийн газрууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагад татгалзаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрээнд дэлхийн 43 банк, санхүүгийн байгууллага 2021 оны 4 дүгээр сарын сарын 21-ний өдөр Тэг хүлэмжийн хий банкнуудын холбоог үүсгэн байгуулсан байна. Тус холбоонд одоогийн байдлаар байдлаар нийт 41 улс орны 125 банк санхүүгийн байгууллага гишүүнээр элсэн орсон бөгөөд гишүүд нь 2005 он гэхэд олгосон зээл, хөрөнгө оруулалтын багцад байх төсөл, хөтөлбөрүүдийн хүлэмжийн хийн ялгарлын 0-д хүргэх амлалтыг авсан байна.

Үүнээс шалтгаалан тендерт оролцогчид нүүрсээр ажилладаг дулааны

цахилгаан станцын төсөлд санхүүжилт босгоход хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан Засгийн газар 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Тавантолгой дулааны цахилгаан станц төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 132 дугаар тогтоолыг баталсан.

Тус тогтоолд Тавантолгой дулааны цахилгаан станц төслийг 300мвт дээр нэмэх нь 150мвт гэсэн 2 үе шатад хуваан эхний ээлжид 300мвт-аар ашиглалтад оруулахаар тогтсон.

2.Төслийн барилга угсралт болон санхүүжилт дэх хамтатгасан EPC+F хэлбэрээр төслийн санхүүжилтийг шийдвэрлэх хувилбарыг хязгаарлахгүй, санхүүгийн саналыг нээлттэй нөхцөлтэйгөөр сонгон шалгаруулахыг даалгасан.

3.Төслийн 300 мвт-ын нэгдүгээр үе шатын EPC+F гэрээний 30 хувийг санхүүжүүлж, Тавантолгой дулааны цахилгаан станц олгосон зээл, зээлийн хүүгийн үлдэгдлийг төлөх, эдгээр зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК болон төрийн өмчийн хувийн эзэмшилд оруулж тооцохыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д даалгасан.

4.Төслийн 70 хувийг санхүүжүүлэхтэй холбогдуулан авах төслийн зээл, санхүүгийн бусад хэлцэлтэй холбогдон баталгаа гаргах, холбогдох бусад үүргийг хүлээх эрхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тус тус үүрэг болгосон.

Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Эрчим хүчний яамнаас Тавантолгой дулааны цахилгаан станцын төслийн тендерийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох бараа, ажил үйлчилгээний хэмжээг хязгаарлахгүй байх, туслан



гүйцэтгэгчийн туршлагыг тендерт оролцож, үнэлэх үнэлгээнд оруулж тооцох талаар Сангийн яамтай зөвшилцөж, Сангийн сайдын 2023 оны А/118 дугаар тушаалаар тендерийн жишиг баримт баримт бичихэд зохих өөрчлөлтийг оруулж тендер зарласан.

Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавагтолгой 450 мвт-ын дулаан цахилгаан станцын эхний ээлжийн 300 мвт-ын гүйцэтгэгч болон санхүүжүүлэх эх үүсвэрийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдөр зарлаж, 2023 оны 7 дугаар сарын 27-ны өдөр нээсэн. Тендерт дараах 2 оролцогч оролцсон байна. Үүнд:

Камбожийн Хаант Улсын “Mitime International” ХХК нь ерөнхий гүйцэтгэгчээр оролцохоор санал ирүүлсэн бөгөөд зураг, төсөл, инженерийн зөвлөх үйлчилгээнд туслан гүйцэтгэгчээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Пауэрчайна, ...Электрик, Повер Инженеринг компани, Чайна Энерджи Инженеринг Групп, Хелложинг Энерджи Инженеринг компанитай туслан гүйцэтгэгчийн гэрээг байгуулжээ.

Мөн цахилгаан станцын үндсэн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Хятадын 8 компанитай тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг тус тус байгуулж тендерт оролцсон болно.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “China Western Power Industrial” ХК, “Бээжин уурын турбин генератор” ХХК, Монгол Улсын “Майнс Ап” ХХК-ийн түншлэлд тус тус санал ирүүлсэн болно.

Тендерт Камбожийн Хаант Улсын “Mitime International” ХХК-ийг шалгаруулж, зөвлөмж хүргүүлсэн боловч тендерт шалгараагүй ... -аас Сангийн яаманд удаа дараа гомдол гаргасан.

Гомдлын дагуу Сангийн яамнаас тендерийг түр түдгэлзүүлж, тендерийг

дахин үнэлэх чиглэлийг өгсөн ба тендерийг хүчинтэй хугацаанд багтаан үнэлгээ хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах боломжгүй болсон тул тендер хүчингүй болжээ.

Тендер хүчингүй болсонтой холбоотойгоор тендерт оролцогчоос Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхэд нэхэмжлэл гаргасан ба шүүхийн шийдвэр гараагүй байна.

Төслийн ерөнхий гүйцэтгэгчийг гэрээ байгуулсан тохиолдолд 30 сарын хугацаанд төслийн бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил үргэлжлэх бөгөөд Тавантолгой 300 мвт-ын дулааны цахилгаан станцын төслийг 2024-27 онд хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авах боломжтой юм.

Тавагтолгой дулааны цахилгаан станц нь ашиглалтад орсноор Монгол Улсын нийгэм, эдийн засаг, ард иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх өндөр ач холбогдолтой төсөл юм.

Тухайлбал, 300 мвт-ын хүчин чадлаар ажиллахад Монгол Улсын төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 1.88 тэрбум квт цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлэх буюу төвийн бүсийн нэгдсэн сүлжээний нийт хэрэглээний 20 орчим хувийг нийлүүлэх өндөр ач холбогдолтой төсөл юм.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Одонтуяа:** Чойжилсүрэн сайдад баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулья.

Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Зоригийн Мөнх-Оргил Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Базарваанийн Эрдэнэбулган Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ,

тарифын газрын дарга. Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Асуулгын хариулттай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Нэр авъя. Батсуурь гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн гишүүн асуултаа асууя.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Тэгээд эрчим хүчний асуудал үнэхээр чухал л даа. Манай улсын цаашидын аюулгүй байдлын нэг номерын асуудал нь яах аргагүй эрчим хүчний асуудал. Сүүлийн үед эрчим хүчний хэрэглээ эрс нэмэгдэж байгаа, экспорт нэмэгдсэн, үйлдвэрлэлүүд нэмэгдэж байгаатай холбоотой эрчим хүчний хэрэглээ хурдацтай нэмэгдэж байгаа.

Тийм учраас эрчим хүчний шинэ эх үүсвэрийн асуудал үнэхээр чухал. Бид бас толгой өвдөж байгаа хамгийн том асуудал Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас тодорхой хэмжээний эрчим хүчний хангамж авч байна. Энэ нь ч өндөр өртөгтэй байна. Энэ нь ч бас эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа. Тийм учраас эрчим хүчний хэрэглээний асуудал үнэхээр чухал. Би хоёр зүйлийг сайдаас тодруулъя гэж бодож байна.

Нэг дэх нь сая та танилцууллаа манай Батсуурь гишүүний асуултад энэ Тавантолгойн түшсэн Тавантолгойн дулааны станцын асуудал, дулааны цахилгаан станцын асуудал маань 300 мвт-ын хүчин чадалтай станц байна гээд. Тэгээд тендер нь би сая таны илтгэлээс сонсоход маргаан үүсээд хүчингүй болчихсон гэж ингэж ойлголоо. Тэгэхээр одоо бид нарт хамгийн чухал юм бол энэ өвөл ч гэсэн их хүндрэлтэй давлаа. Одоо энэ эрчим хүчнийхээ өсөөд байгаа энэ том хэрэглээгээ ойрын үед яг хэрхэн яаж шийдэх вэ? Тухайлбал, 2024 онд яаж шийдье гэж харж байна? 2025 онд яаж шийдвэрлэе гэж харж байна? Бид нар эдийн засаг өсөөд байгаа нь сайн тал нь хэрэглээ нэмэгдээд байгаа, нөгөө

талаасаа хүчин чадал нь хүрэхгүй болчихоод байгаа байхгүй юу. Тийм учраас бол энэ эрчим хүчний хэрэглээтэй холбоотой нэг дэх ийм асуулт байна.

Хоёр дахь нь бол энэ аймгуудын дулааны станцын асуудал танаас олон удаа л ярьж байгаа нөгөө 10 аймгийн дулааны станцын асуудал. Бүгд Найрамдах Солонгос Улсын “Эксим” банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжээд явж байгаа. Тэгэхээр нэгдүгээрт үнэ эд нар нэмэгдэх, эд нартай холбоотойгоор бас ажил жаахан хойшлохоор байгаа юм. Гэрээгээрээ бол энэ оны 7 сард ашиглалтад өгөхөөр байгаа юм. Гэтэл барилгын явц бол 50 хувиас хэтрэхгүй байгаа барилга угсралтын ажил.

Тэгэхээр ер нь сүүлийн үед эрчим хүчний ярьж байгаагаар ямар хугацаанд энэ дулааны станцуудаа ашиглалтад оруулъя гэж тохирч байгаа вэ? Дээр нь хамгийн чухал юм хоёр дахь нь дахин дамжуулах станцын асуудлууд байна, магистрал шугамын асуудлууд байна. Эдгээрийг ер нь ямар түвшинд, яаж шийдье гэж харж байгаа юм бэ гэдэг асуудал.

Гурав дахь асуудал. Нийслэл Улаанбаатар хотдоо хамгийн тулгамдсан асуудлын нэг нь яах аргагүй энэ дулааны болон цахилгааны хэрэглээний асуудал байгаа юм. Бүгд ингээд хэрэглээнийхээ хүчин чадлаас хэд дахин давчихсан. Гэтэл ингээд л өдөр, шөнөгүй барилга бариад л ингээд л хэрэглээгээ нэмээд л байгаа бид. Тэгэхээр цаашидаа энэ нийслэлийн эрчим хүчний эх үүсвэрийн асуудал үнэхээр чухал болоод байгаа юм. Энийг ер нь ойрын үед яаж шийдье гэж ингэж бодож байгаа вэ гэсэн гурван зүйлийг Эрчим хүчний сайдаас асууя.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Чойжилсүрэн сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. Тогтохсүрэн дарга бас яг зөв мэдээлэлтэй байна. Манай эрчим хүчний цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд 2023-аас өмнөх жилүүдэд бол 4-6 хувийн өсөлттэй явж байсан. Жилийн хэрэглээ. Өнгөрсөн 2023 оноос энэ хэрэглээ огцом нэмэгдэж, 7 орчим хувьтай болж байгаа.

Гэхдээ онцлог нь 11, 12, 1, 2 дугаар сарын хэрэглээ бол 11.8 хувьтай нэмэгдэж байгаа юм. Ингээд өнгөрсөн 2024 оны, 23 оны 12 сарын 21-ний өдөр манай цахилгаан эрчим хүчний оргил ачааллын хамгийн өндөр хэрэглээ 1636 мвт-д хүрсэн. Одоо энэ таазаар дахиад үргэлжлүүлээд төлөвлөлт таамаглах юм бол 2024-2025 оны өвлийн оргил ачааллын хэрэглээ 1800 орчим мегаватт хүрэх болов уу гэсэн ийм таамаглал үүсэж байгаа. Энэ 200 гаруй мегаваттаар өнгөрсөн 2023 оны өвөлтэй харьцуулахад 24-25 оны өвөл нэмэгдэх нь. Энэ өсөлтийг хэрэглэхийн тулд эхний ээлжид энэ оны 10 дугаар сарын сүүл гэхэд энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 2-ыг үржих 150 мвт-ын, 300 мвт-ын цахилгаан станц хувийн хэвшилийнхэн барьж байгаа. Эхний 150 мвт-ыг ашиглалтад оруулна гэдэг ийм нэг төлөвлөгөө.

Хоёрдугаарт, Дорнод бүсийн Дорнодын дулааны цахилгаан станцын 50 мвт-ын өргөтгөлийг бид нар энэ 4 дүгээр сарын сүүл, 5 дугаар сарын эхний 10 хоногт багтаагаад ашиглалтад оруулах байх. Тэр ашиглалтад оруулах юм бол төвийн бүс 30 мвт-ын дэмжлэг үзүүлэх болов уу гэсэн ийм хоёр дахь тооцоолол.

Гурав дахь тооцоолол бол энэ шаардлагатай тохиолдолд Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 80 мегаватт хүртэл цахилгаан эрчим хүч импортлохоор холбогдох гэрээ хэлцлүүдийг хийгээд явж байгаа. Техникийн дэд бүтцийг бол энэ “Оюу толгой” компани санхүүжүүлэхээр тендер нь “Оюу толгой” компани дээр

зарлагдсан байгаа. Ингээд энэ 3 төсөл амжилттай болсон тохиолдолд бид нар энэ оны өвлийн оргил ачаалал эхлэхээс өмнө 260 орчим мегаваттаар цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх болов уу гэсэн ийм тооцоололтойгоор Эрчим хүчний яам ажиллаж байна гэдгийг та бүхэнд хэлье.

Хоёр дахь асуудал нь энэ 10 аймгийн дулааны цахилгаан станцын төсөл гээд Солонгос улсын “Экзим” банкны санхүүжилтээр ийм төсөл хэрэгжиж байгаа. Энэ төслийн хэрэгжилт маань харамсалтай нь сайн үр дүнд хүрэхгүй байгаа, жоохон гүйцэтгэгч компанитай бид нар маргаантай байгаа. Яг өнөөдөр сүүлийн өдрүүдэд бид нар энэ “Бьюксан инженеринг” гэдэг Солонгос компанийн Ерөнхий захирлын орлогч нь манай Монгол Улсад ирчихсэн ажиллаж байна. Манай Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Тавинбэхээр ахлуулсан ажлын хэсэг энэ компанитай хэлэлцээр хийгээд явж байна. Ямар ч байсан үнийн өсөлтийг энэ 3 дугаар сарын төгсгөл, 4 дүгээр сарын эхний 10 хоног гэхэд тохирох ийм байдалтай болж байна.

Үнийн өсөлт нь бол 60 орчим, 64 сая доллароор нэмэгдүүлнэ гэдэг ийм хүсэлтийг тавьсан. 9 аймгийн дулааны станц 110 сая долларын санхүүжилттэй явж байсныг энэ бол хэт өндөр байна гэдэг ийм байр суурийг, мөн манай Эрчим хүчний яамнаас баримтлаад хоёр талаасаа ер нь тохиролцоод холбогдох үнийн өөрчлөлтүүдийг хийж байна. Эрчим хүчний хөгжлийн төв энийг баталгаажуулах байх. Түүний дараа Аудитын ерөнхий газарт энэ үнийн өсөлт хүрэх болов уу.

Гэхдээ төслийнхөн өөрийнх нь гэрээн дотор байгаа магадлалын зардал дотор нь багтаагаад нэмэгдүүлэх ийм байдалтай явж байна. Удахгүй, магадгүй энэ долоо хоногийн төгсгөл, ирэх долоо хоногийн төгсгөл гэхэд бид нар хугацааг

эцэслэн тохирно. Үнийг тохирсны дараа. 24 оны 7 сард ашиглалтад орох ёстой хуваарьтай байсан. Мэдээж энэ төсөл хугацаандаа ашиглалтад орж амжихгүй болох нь. Энэ онд нь багтаах талаар шаардлагыг тавих гэж байгаа бид. Энэ ийм асуултууд.

Нийслэл гэлтгүй нийслэл маань энэ төвийн эрчим хүчний систем дотроо орж байгаа. Ерөөсөө энэ бүх энэ хямралд, хүндрэл дотор, хомсдол дотор бол нийслэл орж байгаа юм. Тэгэхээр энэ нийслэлийн цахилгаан эрчим хүчний дутагдлыг саяын миний ярьсан Бөөрөлжүүтийн цахилгаан станцын эхний ээлжид орох, хоёрдугаарт Дорнод бүсийн эрчим хүчний систем дээр 50 мвт-ын өргөтгөл, гуравдугаарт нийслэлд шаардлагатай тохиолдолд хэрвээ хүрэлцэхгүй бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 80 мвт хүртэл цахилгаан эрчим хүчийг өвлийн оргил ачааллын үед импортлохоор ийм тооцооллууд бэлтгэл ажлууд хийгдээд явж байгаа. Ийм.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Тогтохсүрэн гишүүн асуултаа асууж дууслаа. Одоо Батсуурь гишүүн асуулт асууна. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

**Ж.Батсуурь:** Баярлалаа. Тэгэхлээр Монгол Улсын Ерөнхий сайдад өнгөрсөн оны 10 дугаар сард эрчим хүчний талаар асуулга тавьсан. Учир юу вэ гэхлээр Монгол Улсад өнөөдөр болж бүтэхгүй байгаа зүйл, үйлдвэрлэл хөгжихгүй байгаа, энэ утаа, түгжрэл, ядуурал гээд маш олон зүйлээс шалтгаалдаг боловч миний хувьд хамгийн гол энд нөлөөлж байгаа зүйл бол эрчим хүчний хязгаарлалт гэж ингэж боддог. Та олон удаа бас Ерөнхий сайдын асуулга олон зүйл дээр бид нарт Монгол Улсын өнөөгийн хэрэглээ, нийлүүлэлт хоёр бол хэрэглээ нь аль урж даваад өнгөрчихсөн гэсэн энэ зүйлүүдийг хэлдэг. Энийг ойлгодог, мэддэг.

Дээр нь энийг бас сонирхоод байгаагийн шалтгаан бол нэгэнт Монголын эрчим хүчний систем хомсдолтой байгаа болохлоор зүүн бүсийг хязгаарладаг. Тэгэхлээр зүүн бүсэд өөрсдөд нь бас 5-7 тэрбум хүрэн нүүрсний нөөц байдаг. Үүгээрээ бид нар бас энэ цахилгаан станцыг босгох боломжтой биш байгаа гэсэн судалгааны явц Тавантолгойн энэ цахилгаан станцын 10 гаруй жилийн энэ түүхийг сонирхох асуултууд надад маш олноор ирсэн юм Чойжоо сайд аа.

Тийм учраас танаас хэд хэдэн зүйлийг асууя. Таны илтгэлтэй холбогдуулаад надад маш олон сайхан материалууд ирсэн байна лээ. Тэгээд танд баярлалаа. Энэ материалуудаас хараад байхад хэд хэдэн зүйлийг асуумаар санагдсан. Нэгдүгээр асуулт “Оюу толгой”, Тавантолгойг хэдэн мегаваттыг хэрэглэдэг юм бэ? Энэ хэрэглээнд жилд хэдэн сая долларыг гадагш нь өгдөг юм бэ гэсэн асуулт байгаа юм.

Дээр нь энэ Тавантолгойн цахилгаан станц 450 мвт-ын цахилгаан станц бол 10 гаруй жил яригдаад таныг Эрчим хүчний сайд болохлоор энэ бас явчих юм байна, бизнес хүн бас л энэ чиглэлийг дэмждэг хүн гэсэн. Харин ч бүүр ингээд удаашираад явчихлаа. Тэгээд 21 онд тендер хүчингүй болсон, 22 онд тендер хүчингүй болсон, 23 онд тендер хүчингүй болсон, одоо шүүхийн шатад байгаа гэж ингэж та хэллээ. Тэгээд асуудлыг ингээд таны энд ирсэн бичиг баримтуудыг үзээд байхад Сангийн яам энэ тендерийг хүчингүй болгоод, дараагийнхыг нь яаралтай зарла гээд байгаа юм биш үү? Тэгэнгүүт шүүх дээр байна гэсэн байдлаар асуудалд хандаад байдаг.

Тэгэхлээр энэ шүүх дээр байгаа энэ асуудлуудыг хандаад байхад өрсөлдөгч компаниасаа 30 сая доллароор илүү санал өгсөн. Тэгээд ингээд туризлага муутай тэр Камбожийн компани гэдгийг

л шалгаруулах гээд бас ингээд жаахан хүч түрээд байгаа юм биш байгаа? Тэгээд энэ нь өөрөө Сангийн яам болон бодлогын яамнууд нь энийг дахиж зарлаад тэгж байх гэж байхад энийг зогсоохгүйгээр цааш нь явуулах гээд шүүх дээр байгаа гээд байгаа асуудал нь тэр компанийг зориудаар шалгаруулах гээд байгаа юм шиг л ийм асуудлууд гарч ирээд байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ нөхцөл байдал яг ногоон автобусны энэ шалгаруулалттай их төстэй харагдаад байгаа юм. Тийм учраас энэ дээр та.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. “Оюу толгой” руу 1.3 тэрбум квт цаг эрчим хүч жилд нийлүүлнэ. 300 мегаваттаар эхний ээлжид барьсан тохиолдолд. Ойролцоогоор жилд 1.8, 1.9 квт цаг эрчим хүч үйлдвэрлэнэ. Үлдэгдэл 500-600 сая квт цагийг нь бол өмнөд бүсийн эрчим хүчний системд нийлүүлэхээр ингэж ТЭЗҮ боловсруулагдсан. “Оюу толгой” компани жилд дунджаар 1.3 тэрбум квт цаг эрчим хүч хэрэглээд төлбөрт нь жилд дунджаар 120-оос жил бүр жоохон ялгаатай 140 орчим сая долларын цахилгаан эрчим хүч импортлож, Хятад Ард Хятад Улсаас импортлож өөрийнхөө цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангаж байгаа ийм байдалтай байна.

Тендерт хоёр компани оролцсон. Эхнийх нь тэр “Mitime International” гэдэг компани. Нөгөөдөх нь бол Консорциумын гээд хоёр компани оролцсон. Манай Эрчим хүчний яамны Үнэлгээний хорооны дарга оролцож байгаа. Энэ талаар мэдээлэл өгчих үү. тэгээд би гүйцээгээд мэдээлэл өгчихье гэж бодож байна.

**С.Одонтуяа:** Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон. Ерэн-Өлзий юү?

**Б.Ерэн-Өлзий:** Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ерэн-Өлзий. Батсуурь гишүүний асуултад хариулъя.

Тендерийг 23 оны 6 сарын 12-нд зарлаж, 7 сарын 27-нд нээсэн нийт 9 компани тендерийн материал худалдаж авсан. Үүнээс 2 компани тендерийн саналаа ирүүлсэн. Нэг нь болохоор Камбож улсын “Mitime” компани барилга, гүүр, зам, цахилгаан станц болон эрчим хүчний дэд бүтцийн чиглэлээрээ мэргэшсэн компани байсан. Нөгөөдөх нь болохоор Бүгд Найрамдах Хятад Улсын “China Western Power Industrial”, Монгол Улсын “Майнс Ан” компани мөн Хятадын Бээжинг Бизо, Стим, Турбин гэсэн ийм 3 компанийн түншлэл байсан.

Компаниудын ирүүлсэн саналыг Үнэлгээний хороо нарийвчлан үнэлсэн. Техникийн болон санхүүгийн саналыг үзэж байгаа, үнэлж байгаа. Энэ тендерийн нэг онцлох юм нь болохоор 30 хувийг “Эрдэнэс Тавантолгой” компани гаргана, 70 хувийг гүйцэтгэгч компани гаргаж санхүүжүүлээд станц ашиглалтад орсны дараа үйл ажиллагаагаар нь оруулсан санхүүжилтээ буцааж авна гэсэн ийм нөхцөлтэй. Тэгээд 70 хувь дээрээ компани болгон өөр өөр санхүүгийн нөхцөл ирүүлдэг.

Тухайлбал, яагаад ийм нөхцөл байдал үүссэн бэ гэхээр ерөнхийдөө тендерт шалгарахын тулд бага үнийн дүн санал болгоод тэгээд нөгөө 70 хувийн санхүүжилт дээрээ өндөр хүү тооцож ийм ашиг олох ийм магадлал, эрсдэлтэй байдаг болохоор ирүүлсэн үнийн санал болон санхүүжилтийн зардал хоёрын хоорондын нийлбэр нэмээд нийт Монголоос гарах санхүүжилтийг нь хооронд нь харьцуулах замаар ингэж сонгон шалгаруулалтыг хийсэн байгаа.

Ирүүлсэн компаниудын яг Монголын талаас гарах санхүүжилтийн

зардлаар нь харьцуулбал “Mitime International” компани 689 сая ам.долларын санал ирүүлсэн гэсэн үг. “China Western Power Industrial” компаниар ахлуулсан Консорциум 706 сая ам.долларын санхүүжилтийн санал ирүүлсэн байна гэж нарийвчилж дүгнэсэн.

Үнэлгээний хорооноос эдгээр санхүүгийн санал болон санхүүжилт босох магадлалыг нь нарийвчлан үзэж, Mitime компанийг шалгаруулсан байгаа. Яагаад гэвэл үнийн саналаар бага, хоёрдугаарт Малайзын банкнаас 70 хувийн санхүүжилтийн зээлээ авна гэсэн тухайн банкны expression of interest буюу зээл олгох сонирхлын бичгийг ирүүлсэн. Шалгараагүй China Western Power компани болохоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээлд Монгол Улсад цахилгаан станц барих асуудлаар бонд гаргаж, санхүүжилт босгоод энэ санхүүжилтээрээ энэ станцыг барина.

Хоёрдугаарт, “Эрдэнэс Тавантолгой” компани 504 сая доллартой тэнцэх хэмжээний санхүүгийн баталгааг нэр хүнд бүхий банкаар гаргасан байх шаардлагатай. Энэ баталгаа нь зээл болох үндэслэл болно гэсэн ийм санхүүжилтийн нөхцөл ирүүлсэн.

Тэгэхээр энэ санхүүжилтийн нөхцөлөөс ерөнхийдөө үнэлгээний хороо дүгнэхэд бол энэ түншлэлийн ирүүлсэн санал хэрэгжих магадлал маш багатай байсан. Тэгээд ерөнхийдөө үнэлгээний хорооноос “Mitime” компанийг шалгаруулаад ингээд явсан байгаа.

**С.Одонтуяа:** Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Батсуурь гишүүний асуултад нэмээд хариулъя. Энэ түншлэлийн тендерт ирүүлсэн санхүүгийн саналын нөхцөлөөр энэ 504 сая долларыг баталгаа гаргахад

Монголын арилжааны бүх банкнууд нийлээд хүрэхгүй юм байна лээ.

Хоёрдугаарт, “Эрдэнэс Тавантолгой” компани гадаадын банкаар баталгаа гаргуулах энэ асуудал бол нэгдүгээрт энэ үнэлэх бололцоогүй, өндөр зардал гарна.

Гуравдугаарт, энэ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Жиньпин дарга 21 онд бол Монгол Улс Хятадын нутаг дэвсгэрээс гадуур нүүрсэн түлштэй цахилгаан станцыг санхүүжүүлэхгүй гээд амлалт авчихсан. Тэрний дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн байгууллагууд шийдвэр гаргачихсан. Хятадын дотоодын санхүүгийн зах зээлд Монголд нүүрсээр ажилладаг цахилгаан станц санхүүжүүлнэ гэдэг ийм бонд гарах ямар ч бололцоо байхгүй. Ийм санал.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Батсуурь гишүүн тодруулъя. 1 минут.

**Ж.Батсуурь:** Энэ асуулгын журмыг чинь өөрчлөхгүй бол сонин юм байна. Асуулт нь 1 юм уу, 3 минут. Хариулт нь олон талаас 5 минут болохлоор ойлгомжгүй байна.

Тэгэхлээр Си Жиньпиний даргын хэлсэн гээд байгаа зүйл чинь улсын компани улсын газрууддаа уриалсан уриалга, шийдвэр байгаа. Гэтэл энд орж ирж байгаа компани бол хувийн хөрөнгө оруулалт болохлоор энд бол хамаарахгүй нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Сангийн яаманд гомдол гаргаад Сангийн яам руу танайд ирж байгаа асуудлууд бол энэ гомдол нь үндэслэлтэй байна, энийг хүчингүй болгоод зарлаа гээд байхад танайх үндэслэлгүй байна гээд ингээд байгаагийн учир шалтгаан юу юм бэ хоёрдугаарт? Нэгдүгээрт нь Си Жиньпиний асуудал.

Гуравдугаарт, энэ Камбожийн “Mitime International” компани чинь 2018 онд байгуулагдсан компани байна шүү дээ. Тэгээд одоо 4, 5-хан жил болсон. Тэгээд энэ нөхцөл байдлыг дагахгүй компанийг.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Чойжилсүрэн сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Нэгдүгээрт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээл дээр хувийнх ч тэр, төрийн өмчийн аж ахуйн нэгж ч тэр яг Хятад Улсын нутаг дэвсгэрээс гадагшаа цахилгаан станц санхүүжүүлнэ гэдэг ийм байдлаар бонд босгохгүй гэдэг нь ойлгомжтой Хятадын бүх холбогдох санхүүгийн байгууллагуудаас бид нар тодруулга авсан.

Хоёрдугаарт, энэ “Майнс Ап” компани тэргүүтэй энэ Монголын талын энэ Сүхбаатар аймгаас гаралтай хүмүүс үүсгэн байгуулсан компани юм гэнэ лээ. Энэ компани бол тэр 504 сая долларын баталгаа нэхээд байгаа байхгүй юу. Банкны. Энэ банкиг “Эрдэнэс Тавантолгой” компани өөрөө яаж, ямар өртөгтэй, ямар хугацаанд гаргахыг нь үнэлэх бололцоогүй юмыг шахаад байгаа байхгүй юу.

Гуравдугаарт, зохиомлоор ЕРС-ийнхээ үнийг хямд өгчхөөд яг Монголоос энэ бүх санхүү.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Сайд дуусгаж хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Яг ингээд ЕРС+F, тэгэхээр ЕРС үнийн үнэ дээр нэмэх нь тэр санхүүжилтийн зардлыг нэмэхээр өндөр тусчхаад байгаа байхгүй юу. Иймэрхүү байдалтай юман дээр л заавал шалгарна гээд зүтгээд байгаа юм. Тэгээд танаар дамжуулж асуулга тавих л байх шиг боллоо.

**С.Одонтуяа:** Сангийн яамнаас хүн байхгүй шүү дээ Батсуурь гишүүн ээ.

Эрчим хүчний яамны 4 хүн байна. Ажлын хэсгээс хариулах хүн байна уу? Саяынх Батсуурь гишүүний юун дээр нэмээд? Та асуултаа дахиад тодруулаад асуучих юм уу? Одоо дэгээрээ 1 минут. Шинээр Батсуурь гишүүнд. Ажлын хэсгийнхэн сонсоорой.

**Ж.Батсуурь:** Энэ Сангийн яам удаа дараа энэ асуудлуудыг, гомдлыг нь хүлээж ав гээд байхад яагаад Үнэлгээний хороо авч хэлэлцэхгүй байгаа юм бэ л гэсэн асуултад би Үнэлгээний хорооноос асуугаад байна л даа. Тэгээд энд хариулахгүй нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яагаад 2018 онд байгуулагдсан компанийг турилагатай гэж үзэж байгаа юм бэ? Яагаад 30 сая доллароор илүү болзолтойгоор орж ирсэн компанийг хүчинтэй гэж үзээд байгаа юм бэ? Миний бодлоор бол энийг зогсоогоод, яаралтай ахиад зарлачихвал Монгол Улсдаа хэрэгтэй юм биш үү, хугацаа алдахгүй юм биш үү гэсэн л талаас нь асуугаад байгаа юм. Тэгээд хариулахгүй байна л даа. Тойруулаад яваад байгаа юм.

**С.Одонтуяа:** Сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Нэгдүгээрт, таны асуулга тавиад “Майнс Ап” тэргүүтэй компанийн хүмүүсийн өр төлбөр, борлуулалтын орлого сүүлийн 5 жилийн хугацаанд дандаа бууж ирсэн байгаа. 1.3 тэрбум долларын өртэй. Хамгийн сүүлийн 23 оны байдлаар 100 сая долларын борлуулалтын орлоготой байгаа юм.

Хоёрдугаарт, тэр 18 онд байгуулагдсан компани сүүлийн 5 жилийн хугацааныхаа энэ шалгуурыг хангаж байгаа юм байна лээ. Энэ талаар манай Үнэлгээний хорооныхон бас нэмээд тайлбарлачихна биз.

**С.Одонтуяа:** Хэд вэ? 5 уу? Үнэ, тарифын газрын дарга Эрдэнэбулган

хариулах уу? 4 дүгээр микрофон Ерэн-Өлзий.

**Б.Ерэн-Өлзий:** “Mitime” компанийн борлуулалтын орлого нь 18 онд 88 сая, 19 онд 180 сая, 20 онд 300 сая, 21 онд 373 сая, 22 онд 426 сая гээд ийм борлуулалтын орлоготой байгаа. Түншлэлийн борлуулалтын орлого 18 онд 547, 19 онд 534, 20 онд 228, 21 онд 150, 22 онд 183 гээд. Тэгээд өр болон өөрийн хөрөнгийн харьцааг нь ингээд харьцуулаад харахаар түншлэлийн санхүүгийн үзүүлэлт маш муу ийм байдалтай байсан. Түрүүн 30 сая доллароор илүү үнэтэйг нь шалгаруулчихлаа гэж байна. Энэ бол биш. Яг энэ барилга угсралтаа хийгээд, оруулсан хөрөнгөө тодорхой хүүтэйгээр буцаагаад авна. Тэр хүүгийнх нь зар.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Гүйцээгээд хариулчих даа. Ерэн-Өлзий 4 дүгээр микрофон.

**Б.Ерэн-Өлзий:** Монголын талаас гарах тэр хүүгийн зардлыг нь оруулаад харьцуулалт хийнэ гэж анхнаасаа ийм зарчимтайгаар тендерийн материал дээр тодорхой тусгаад энэ тендерийг зарласан. Ингээд үзэхэд “Mitime” компани 689 сая доллар, Консорциум 706 сая долларын ийм санхүүгийн санал ирүүлжээ гэдгийг нь тооцоолоод гараад ирсэн.

Өөрөөр хэлбэл, 17 сая доллароор нөгөө Консорциум маань өндөр байсан гэсэн үг. Тэгээд бид бага үнэтэйг нь Эрчим хүчний яам шалгаруулсан.

**С.Одонтуяа:** Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууна.

**О.Цогтгэрэл:** Эрчим хүчний талаар дэлхий дээр эрчим хүч гэдэг чинь техник технологи нь хөгжсөөд, хөгжил дэвшлийнхээ гол хөдөлгөгч хүч нь, зүтгүүр нь болоод дэлхий нийт бараг хүн төрөлхтний хөгжил, дэвшлийн сүүлийн

үеийг харахад ийм л байдалтай. Манай Монголд эрчим хүч нь хөгжил дэвшлийнх нь боймлогч хүчин зүйл нь болоод улам даамжирчихсан ийм л байдалтай.

Зөвхөн ганц хоёр төсөл хэлэхэд л Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц гээд л баахан ярьж байсан. Одоо яг санхүүжилт нь шийдэгдсэн юм уу тэнд? Бид нар энд баахан л том том л юм ярьцаагаад байдаг. Яг үнэндээ санхүүжилт нь шийдэгдээгүй бололтой одоог хүртэл ингээд дуу чимээгүй л болчихлоо.

Тавантолгой гэж байна. Яг Тавантолгойн цахилгаан станц, Эрдэнэс Тавантолгой дээр баригдах станцын тухай ярьж байна. Энэ дээр бичсэнээр Оюу-Толгойтойгоо одоо хүртэл худалдах, худалдан авах гэрээгээ хийгээгүй л юм байна. Худалдах, худалдан авах гэрээгээ хийгээгүй хаашаагаа энэ нийлүүлэлтээ хийх нь тодорхойгүй ийм төслийн тендерийн тухай яриад байдаг. Энэ чинь яг дараалал нь болж байгаа юм уу? Хаашаа зарах нь мэдэхгүй тэгээд байсан. Гэрээгээ хийгээгүй.

V дугаар цахилгаан станц гээд алдартай зүйл ярьдаг байсан. Одоо бүүр сураг байхгүй. Улаанбаатар хот нь хөлдсөн, хөлдөхдөө бэлэн, гадаадаас авч байгаа импорт энэ бүх зүйл нь болохоо байчихсан. Улаанбаатар хотод хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, олон зүйл нь цахилгаан станцаасаа болоод байхгүй. Энэнээсээ болоод хотынхоо төвд шавсан. Энэнээсээ болоод түгжрэл, утаа, олон зүйл чинь яг гарчихсан.

Тэгэхээр энэ эрчим хүчний систем маань яг хаанаа, ямар түвшинд явж байгааг бид нар ёстой нөгөө амаараа, чихээрээ, хэлээрээ, биеэрээ бүгдээрээ л мэдэрцгээж байна л даа. Тэгээд зарим мэдээллээр энэ 5 дугаар сар гэхэд Монголын эрчим хүчний систем цалингаа тавьж чадахгүй энэ байдалд очиж байгаа гэдэг мэдээллүүд ч явж байна лээ.



Ер нь яагаад бас өнгөрсөн ингээд 8 жилийн хугацаанд энэ эрх баригчид ийм их сэтгэлгүй, зөвхөн улс төрд зориулж, зөвхөн сонгуульд зориулж ингэж ажиллаж байгаа юм бэ? 8 жилийн хугацаа гэдэг чинь хангалттай хугацаа. 8 жилийн хугацаанд бид нар цаг алдсанаас болоод нүүрсний цахилгаан станцыг санхүүжүүлэхгүй гэдэг энэ олон улсын хандлага Хятадын энэ шийдвэрүүд гарчихлаа. Зүгээр л аргацааж, улс төрд зориулж аргацааж явсны л үр, гор л гарч байна шүү дээ. Энэ хооронд ингээд бүх зүйл улам бид нараас алдагдаад, улам бид нараас алсраад ийм л байдалтай. Одоо бас цаг хугацаа алдаж байгаа олон зүйлүүд бий. Тэр сэргээгдэх эрчим хүч гээд зүйл баахан иргэдийн мөнгөн дээр иргэдийн цахилгааны төлбөр дээр тэр сэргээгдэхийн үнийн зөрүү төлдөг. Энийг энд засаж, засварлах ёстой том ажил бас л ингээд хүлээгдэж явж байгаа.

Гэр хорооллын иргэд гэж ядарсан хэдэн иргэд нь цахилгааны мөнгөнөөс, тэд нараас цахилгааны мөнгө аваад, орон сууцад амьдарч байгаа иргэдийн дулааны мөнгийг татаас өгдөг, төлдөг зөрүүг нь орон сууцад иргэдийг дулаан амьдруулахын тулд гэр хорооллынхон цахилгааны мөнгөн дээр татаас төлдөг энэ тогтолцоо явж л байгаа шүү дээ. Энэ бүгдийг хэзээ өөрчлөх юм бэ? Бас л яг тэр алдагдсан 8 жил шиг өнгөрсөн хугацааны.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Дэгийнхээ дагуу ийм шүү. Асуулт асуух хугацаа 3 минут. Тайлбар хангалтгүй гэж үзвэл 1 минут, дахин тайлбар авах шаардлагатай гэвэл 1 минут. Ингээд л юм болж байгаа. Хэн хариулах вэ? Чойжилсүрэн сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын асуудал энэ санхүүжилтийн гэрээ байгуулагдаж байгаа. Энэ 4 сарын сүүл, 5 сарын эхээр ажил нь эхэлнэ. Нэг.

Хоёрдугаарт, “Оюу толгой”-той цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ хийгдсэн байгаа. Цогтгэрэл гишүүнд тэр гэрээний хувилбарыг хүргүүлье. Юу гэсэн үг юм? Оюу толгойтой 1.3 тэрбум квт-ын цаг эрчим хүч нийлүүлнэ гээд гэрээний нөхцөл хийгдсэн байгаа тэнд. Манай ажлын хэсгээс тэрийг хүргээд өгнө.

Гуравдугаарт, V дугаар цахилгаан станцын талаар тайлбар өгье. V дугаар цахилгаан станцыг энэ Хонхор хавьд барихаар газар сонгосон юм байна лээ. Ер нь бол ярьж байгаад энэ V дугаар цахилгаан станц нэг хүндрэлтэй сэдэв байгаа нь цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэнэ. Энэ хоёр бүтээгдэхүүнээ борлуулахын тулд холбогдох шугам, дэд бүтцүүдийг тавих ёстой. Трасс байхгүй юм байна лээ. Тийм учраас тухайн үедээ зогссон юм байна лээ. Одоо бидний үед ч гэсэн энэ V дугаар цахилгаан станцыг яг энэ хэлбэрээр нь явуулах бололцоо байхгүй.

Яагаад гэвэл дулаанаа, цахилгаан эрчим хүчээ татах трасс байхгүй. Шугам татах. Ийм нөхцөлд энэ V дугаар цахилгаан станцын тооцоолол явчихсан юм байна лээ гэдгээ товч хэлье.

Бусад зүйл дээр бол таны шүүмжилж байгаа зүйлийг хүлээж авахаас ондоо аргагүй. Эрчим хүчний систем маань яг зах зээлийн системд шилжиж чадаагүй. Зардал нь зах зээлийн үнээр гардаг. Үнэ нь, борлуулалтын үнэ, тариф гэж нэрлэдэг нийтээр дагаж мөрддөг төрөөс зохицуулалттай байсан нь шалтгаалаад алдагдалтай ажиллаж байгаа. Нууц биш зүйл. Магадгүй таны яриад байгаагаар тодорхой хэмжээнд энэ сүүлийн жилүүдэд олон жил дараалаад алдагдалтай ажилласан учраас үнэ нэмэгдүүлж, тарифыг нэмэгдүүлж чадахгүй байгаа учраас бид нар бол энэ алдагдалтай, хүндрэлтэй байгааг нуухгүй гэдгийг таны өмнө хэлье.

Ер нь бол энэ 23 он бол эдийн засгийн уналтыг зогсоогоод, КОВИД-ын дараах хүндрэл, дайн ба КОВИД гэдэг энэ хүндрэл дээр 20, 21, 22 оны хүндрэлүүдийг даваад тогтворжуулах ажил хийнэ. 24 оны төгсгөл гэхэд иргэдийн амьдрал маань, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдрал айлын хаалгаар ороод орлого тогтворжиж эхэлсэн тохиолдолд бол бид нар үнийг нэмэхээс ондоо аргагүй байдалтай тулсан гэдгийг бас энэ үнэнийг хэлэх ёстой байх байх гэж бодож байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухайд бол төвөгтэй хоёр нөхцөл бий. Одоо Монголд байгаа сэргээгдэх эрчим хүчний хоёр нөөц бол нар ба салхи байгаа юм. Тэгээд нар орох юм уу, эсвэл салхи зогсчихоор энэтэй дүйх хэмжээний чадлыг хаа нэг газар нөөцлөх хэрэгтэй болно. Тэгэхээр энэ асуудлыг бид нар шийдэж чадахгүй байгаа учраас энэ нарны ба салхин цахилгаан станцуудыг, цаашид төвийн бүсийн болон Монголын сүлжээнүүдэд холбоход хүндрэлтэй байгаагийн нэгдүгээр асуудал бий.

Хоёрдугаарт, одоо байгаа, байгуулагдчихсан байгаа нарны цахилгаан станцын 1 квт-ын өртөг нь 15-19 центийн үнэтэй байгуулагдсан байна. Хэт өндөр үнэтэй. Нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээний нийлүүлэлтийн 9 хувийг нийлүүлээд, үнийнх нь 27 хувийг авч байгаагаас шалтгаалаад манай төвийн бүсийн эрчим хүчний систем болон эрчим хүчний систем бүхэлд нь алдагдалд оруулж байгаа том хүчин зүйлүүдийн нэг. Ийм хоёр хүндрэл байгаа учраас энийг явуулж чадахгүй байгаа гэдгийг бас танд хэлье.

**С.Одонтуяа:** Цогтгэрэл гишүүн тодруулъя.

**О.Цогтгэрэл:** Дэлхий болохоор цэвэр эрчим хүч, сэргээгдэх гээд олон тал руу л ингээд техник, технологийн шийдэл, олон олон зүйлүүд ингээд гараад яваад байдаг. Бид бүгд болохоор энд улс

төр, халамж, улс төрийн санал, иргэд дургүйцэх вий гээд олон зүйлээр ингэж үнэхээр цаг хугацааг асар их алдаж явснаар л ийм байдалд очлоо. Тэгээд сая энэ танилцуулгатай холбоотой нэг зүйл эндээс харахад Тавантолгойн цахилгаан станцын төслийн нэгж гэдэг байгууллага бараг гэрээ байгуулалгүйгээр 17 сая долларын буюу 61 тэрбумын өртэй байгаад татан буугдсан гэсэн энэ тоо явж байна л даа.

Тэгэхээр энэ жишээ нь, яг энэ ямар нэгж, тэгээд татан буугдсан бол шинээр байгуулагдаад явж байгаа ч юм уу, ямар хэрэгтэй цаас бий болж энд ер нь тийм 61 тэрбум төгрөгийн өр, үлдэгдэл ийм баахан зүйл болоод явчлав? Энэ төслийн нэгж яг энэ ирсэн энэ “Эрдэнэс Тавантолгой” дулааны цахилгаан станцтай холбоотой үнэхээр бас энэний.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон Ерэн-Өлзий.

**Б.Ерэн-Өлзий:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. 13 онд Засгийн газрын тогтоолоор Тавантолгойн цахилгаан станцын төслийн нэгжийг байгуулсан. Энэ “Хөгжлийн” банкны зээлээр энэ төслийн нэгжийн санхүүжилтийг болон төслийн хөгжүүлэлтийн зардлыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ хүрээнд “Хөгжлийн” банкнаас төслийн нэгжээ авсан санхүү, зардал болон төслийг хөгжүүлэхэд төслийн ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ, олон улсын зөвлөх компаниуд авч ажиллуулсан зардлын нийлбэр нь түрүүн таны дурдсан тоо болсон байгаа. Энэ төслийн нэгж 2016 онд төслийн нэгжийг татан буулгаад Тавантолгой цахилгаан станц ТӨК-ийг байгуулаад ингээд явсан байгаа.

**С.Одонтуяа:** Сайд нэмж хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ 61

орчим тэрбум төгрөг буюу энэ 17 орчим сая долларыг 2013-2016 оны хооронд гаргасан байдаг юм. Одоо тэр төслийн нэгжийг татан буулгаад Тавантолгой дулааны цахилгаан станц ТӨК байгуулахад энэ зардлыг, энэ өглөгийг “Хөгжлийн” банканд залгамжлагч гээд эрх шилжүүлэн залгамжлагч гэдгээр нь энэ ТӨК төлөхөөр байгаа.

Харамсалтай нь одоо энэ компани өөрийн орлогогүй байгаа учраас төлж чадахгүй байгаа. Энэ төсөл хэрэгжсэн тохиолдолд бол “Эрдэнэс Тавантолгой” компанийн энэ урьдын өрийг нь “Хөгжлийн” банканд төлөхөөр энэ Засгийн газрын холбогдох тогтоолын заалт гарсан байгаа. Ийм л зүйл. Анх авсан зээл, үүссэн, тавьсан өр нь бол 13-16 онд тавигдсан гэс гэж ойлгож болно.

**С.Одонтуяа:** Цогтгэрэл гишүүн тодруулъя.

**О.Цогтгэрэл:** Саяын компанийн түүх нь үргэлжилж байна л даа. Жишээ нь, энэ дээр бичсэнээр саяны компанийн толгой компани “Эрдэнэс Тавантолгой” гэнэ. Нүүрсний компани. “Эрдэнэс Тавантолгой” компани дээр аваачаад баахан энд тэнд хэрэгтэй, хэрэггүй баахан ёolkны гацуур шиг баахан төслүүдийг хамааруулдаг. Яг энэний цаана юу харагдаж байна вэ гэхээр “Эрдэнэс Тавантолгой” компани чинь уг нь бол ТӨК-ийнхаа хувьд ашиг, ноогдол ашиг олон зүйлээ улсын төсөвт төвлөрүүлээд улсын төсвөөр энэ Улсын Их Хурал дээр шийдвэр гараад дараагийн ямар төсөлд хэрэгжүүлэх вэ гэдгийг уг нь шийдэх ёстой.

Гэтэл “Эрдэнэс Тавантолгой” компани энэ төслийг чинь ингээд хариуцаад явчихлаар төсвийн гадуурх төсөв, үндсэндээ Монгол Улсын төсвийн гадуур Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан “Эрдэнэс Тавантолгой” компани өөрөө дураараа тэнд, дураараа ч юу байх вэ дээ “Эрдэнэс Тавантолгой” компанийн ашгаас, орлогоос, олон

зүйлээс шууд төслийн нэгжийг санхүүжүүлээд. Тэгэхээр одоо яг л ийм загвар руу ороод л явж байгаа юм байна. Энэ чинь өөрөө дахиад засаглалын хувьд төсвийн гадуурх төсөв л гэсэн үг шүү дээ.

**С.Одонтуяа:** Сайд тодруулгад хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя “Эрдэнэс Тавантолгой” компани энэний төслийн өөрийн санхүүжилт буюу 30 хувийг нь санхүүжүүлэх, ойролцоогоор 180-200 орчим сая долларыг “Эрдэнэс Тавантолгой” компани санхүүжүүлэхээр ийм Засгийн газрын тогтоол гарсан.

Яагаад энэ “Эрдэнэс Тавантолгой” компаниар гаргасан талаар үндэслэлээ хэлье гэж бодож байна. Эхний ээлжид “Эрдэнэс Тавантолгой” компанид бүх татвар төлсний дараа өөрт ноогдох, төрд ноогдох ноогдол ашгаас санхүүжүүлнэ. Нэг.

Хоёрдугаарт, оффтейк гэрээ хийхгүй. Хоёр.

Гуравдугаарт, “Эрдэнэс Тавантолгой” компани энэ цахилгаан станц ашиглалтад орсон тохиолдолд өөрөө жилд 1.3 орчим сая тонн борлуулж чадахгүй байгаа эрчим хүчний нүүрсээ борлуулах зах зээл болно.

Дөрөвдүгээрт, өөрийнх нь хэрэглээ “Эрдэнэс Тавантолгой” компанийн бусад төслийг санхүүжүүлэхэд энэ цахилгаан станц зайлшгүй шаардлагатай болчихоод байгаа учраас “Эрдэнэс Тавантолгой” компанийг сонгож авсан. Түүнээс биш урьд нь яриад байсан шиг нөгөө янз бүрийн оффтейк гэрээгээр санхүү.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууна. 3

минут. Пүрэвдорж гишүүний микрофоныг нээе.

**Б.Пүрэвдорж:** Дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй 10 орон дэлхийн нийт эрчим хүчний 90-ээд хувийг нь үйлдвэрлээд, түүнийгээ өөрсдөө хэрэглээд, тэгээд хөгжлийн хувьд хамгийн хол тасраад яваад байна л даа. Тэгэхдээ эрчим хүч гэдэг бол хөгжлийн гол үндэс болчихоод байгаа юм.

Манай Монгол орны хувьд эрчим хүчний тусгаар тогтнол хамгийн чухал зүйл. Ер нь ингээд том том станц барина гэхээр л том том орнуудын нөлөө орж ирээд гацаадаг, зогсоодог янз янзын учир нь мэдэгдэхгүй бослого, тэмцэл гардаг, эсэргүүцдэг ийм зүйл гараад байгаа юм. Ер нь гуравдагч орныхон орж ирэх дээр бас асуудал үүсгэдэг.

Жишээ нь, ураны орд дээр Францынхан орж ирэхэд одоо тэгээд л юу нь мэдэгдэхгүй ингээд л ажил нь зогсчихоод л ингээд л байж байгаа шүү дээ. Энийгээ урагшаа явуулах хэрэгтэй. Ер нь мэдээж хоёр том хөршийнхөө энэ бас хөрөнгө оруулалтыг бас тодорхой хэмжээгээр оруулах хэрэгтэй.

Жишээ нь, Оросын Холбооны Улстай нийлээд тэр Эгийн голын станц бариад, Тавантолгой дээр Хятадын сонирхлыг оруулаад ингээд явах юм бол илүү асуудал хурдан шийдэгдэх ийм боломж нь байж байгаа юм.

Тэгээд дотооддоо ч гэсэн нэгнийгээ хорлодог. Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг барихын тулд Багануурын цахилгаан станцыг зогсоож байх жишээтэй. Тэгээд өнөөдөр Бөөрөлжүүтийн цахилгаан станц нь хаана яваа юм? Юу нь ч мэдэгдэхгүй ийм байдалтай байж байгаа юм. Тэгээд нэг төсөл зарладаг. Том том төсөл заралдангуут, тэгэнгүүт ерөөсөө анхнаасаа энэ асуудлыг гацаах санаатай тэр хүмүүс л тэр төсөл дээр орж ирээд би чадна гээд л ингээд л явдаг тэгж

байгаад алга болгодог, эрч хүчийг нь бууруулдаг ийм зүйл гараад байгаа.

Тийм учраас ер нь энэ эрчим хүч дээрээ бас нэлээн тийм бодлого гаргаад энэ нэлээн хатуу байр суурь дээрээ хандаад асуудлаа шийдээд явах зайлиггүй шаардлага байна.

Жишээ нь, бид нар 11 центээр Оросоос авдаг байсан 7 болгосон гэж буулгасан гэж ярьж байх шиг байна. Бид нар бас яг эрчим хүчээ гаргадаг юм шүү дээ, бас хэрэглээ багатай үед Орос руу гаргадаг. Тэгэхдээ буцаагаад 2 цент, 3 центээр өгдөг ийм наймаа гэж юу байдаг юм бэ? Ийм байдлаар асуудал гараад байна.

Тийм учраас ер нь яг энэ өглөө, үүрээр энэ эрчим хүчний хэрэглээ багассан үед бид нар энэ цахилгаан эрчим хүчээ тэнцвэржүүлэлтийн цахилгаан станц, усан цахилгаан станцад хэрэглэмээр байна.

Жишээ нь, Туул гол дээр хоёрын зэрэг усан цахилгаан станц барих боломжтой шүү дээ. Шөнө нь усаа дээшээ гаргаж татчихаад л, эрчим хүч багатай үед нь гаргачхаад, буцаагаад эрчим хүчний хэрэглээ ихэссэн үед буулгаад түүнийгээ төвийн эрчим хүчтэй холбоод ингээд явах юм бол маш их амжилт гаргах боломж байж байна шүү дээ. Тэгээд ийм юм ерөөсөө ажлууд хийхгүй тэгээд л ерөөсөө тийм барина, бүтээнэ гэдэг.

**С.Одонтуяа:** Сайд хариулъя.

**Б.Чойжилсүрэн:** Пүрэвдорж гишүүн ч бараг бас асуудлыг бүгдийг нь өөрөө мэдэж байх шиг байна. Энэ Монгол Улсаас эхтэй голууд дээр баригддаг усан цахилгаан станцууд бол энэ Оросын Холбооны Улс руу дийлэнх нь гарч байгаа Монголын голууд. Оросын Холбооны Улсад энэ талаар байнга ийм ЮНЕСКО-д гомдол гаргасан Эгийн голын усан цахилгаан станцтай

холбогдолтой жишээлбэл. Иймэрхүү байдлаар төслүүд удааширч байгааг та мэдэж байгаа.

Усан, цэнэг цахилгаан станцын тухайд бол энэ нэг ийм төвөгтэй юм байгаа. Бид нар судалж байгаа юм. Эрдэнэтэд 2, Улаанбаатарт 1 усан цахилгаан станцын тухай асуудал ярихаар шөнөдөө 2 центрээр энэ усан цахилгаан станц руу нийлүүлээд төвийн бүсийн эрчим хүчний системээс, буцаагаад оргил ачааллын цагаар 15 центр буцаагаад нийлүүлье гэхэд 15 жилийн дотор, 20 жилийн дотор оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөж өгөхгүй, үр ашиг нь гарч өгөхгүй байгаа учраас одоо ийм хүндрэлтэй байдалд энэ төслүүд бол зогсонги байдалд байгаа нь үнэн. Хүссэн, хүсээгүй манай 2030 он хүртэл бид нар эрчим хүчний үнийг чөлөөлж, бүрэн либералчилж, зах зээлийн горимд шилжүүлэхгүйгээр иймэрхүү асуудлууд бол хөрөнгө оруулагч нарын сонирхлыг татахгүй байгаа нь бас үнэн. Ийм төвөгтэй нөхцөл байдалд байгаа юм. Энэ өнгөрсөн 34 жилийн өмнө 90 онд бид нар ардчилсан замыг сонгож авсан. Тэр үеэс хойш яг зах зээлийн бүрэн горимд шилжээгүй байгаа цөөн хэдэн салбар бол энэ манай тэтгэврийн систем, манай эрчим хүчний систем, энэ төмөр замын тээвэр гэх мэт энд хэдийн өнгөрсөн зуунаараа байгаа, зах зээлийн горимд шилжээгүй байгаа салбаруудын нэг нь энэ эрчим хүчний систем мөн байгаа юм.

Тийм учраас энэ магадгүй энэ иргэдийн орлого, эдийн засгийн өсөлтийг эхний ээлжид бий болгоё. Энэ дараа нь, хэсэг хугацааны дараа магадгүй 6-12 сарын хоцрогдолтой эдийн засгийн өсөлт маань иргэдийн айл өрхийн хаалгаар ороод иргэдийн орлого нэмэгдсэн тэр мөчийг амдаж байж цахилгаан эрчим хүчний үнийг өөрчлөх асуудлыг ярина гэсэн ийм байр суурьтай л байгаа.

Тэгэхгүй бол манай эрчим хүчний системд одоо байгаа үнэ, тариф, үнэ

нөхцөлөөр ямар ч хувийн болон улсын хөрөнгө оруулалт оруулаад бүгд эргэн төлөгдөхгүй нь ийм байдалд алдагдалтай болчихоод байгаа нь нууцгүй зүйл.

**С.Одонтуяа:** Пүрэвдорж гишүүн тодруулъя.

**Б.Пүрэвдорж:** Туул гол дээр хоёрын хоёр зэрэг тэнцвэржүүлэлтийн станцыг барих боломжтой. Тэр байтугай 100 мвт-ын станцын ТЭЗҮ нь бүгдээрээ гарчихсан, гэрээ нь танайтай байгуулагдчихсан л юм шиг байгаа юм. Тэгээд би тэр дээр үеийнх юм шиг байгаа юм. Энийг заавал Туул гол дээр барих юмыг энд, тэндээс асуухгүйгээр бид нар бас тодорхой хэмжээгээр тэр хувийн хэвилийн компаниудыг дэмжих замаар тэр ажлуудыг нь хийгээд, тэндээсээ бас тодорхой тарифын бас урамшуулал энэ тэр өгөөд ялангуяа усан цахилгаан станц бол тодорхой хэмжээгээр маш үр дүнтэй ийм эрчим хүчний хамгийн гол эх үүсвэр байгаа.

Тэгээд энэ дээрээ ингээд бас тодорхой хэмжээгээр ажиллаад явахгүй бол одоо ингээд л Монгол ардын нам хийх гэж байна, өө одоо сонгууль дөхчихлөө, дуусчихлаа, тэгээд сонгуулийн дараа та нар санал өгвөл дахиад л хийнэ гэдэг ийм байдлаар л асуудалд дандаа хандах юм даа.

**С.Одонтуяа:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь үг хэлнэ. 5 минут. 1 удаа 5 минут.

**Ж.Батсуурь:** Энэ асуулгыг бас анхаармаар юм байна. Асууж байгаа хүн нь 1 минут, хариулж байгаа хүн нь, субъект тус бүр нь 5 минут гэхлээр энэ ойлгомжгүй болоод явчхаж байна.

Тэгэхлээр энэ асуулгад Эрчим хүчний яам, Чойжилсүрэн сайдаас маш олон материалууд ирсэн бас талархаж байна.

Тэгээд миний асууж байгаа асуулт, тодруулах гэж байгаа зүйл бол та бүхний ирүүлсэн материалын түвшинд л асуугаад байгаа юм. Санаа зовож байгаа зүйл бол аль 10 хэдэн жилийн өмнө эхэлчих боломжтой зүйлүүд янз бүрийн шалтгаануудын улмаас ингээд л хойшлоод л байдаг, хойшлоод л байдаг, тэгээд таныг бас хурдлуулчих болов уу гэсэн чинь бас л ингээд хойшлоод байдаг. Тэгээд энэ дээр хариултын явцад жишээлэх юм бол Эрчим хүчний яамны Үнэлгээний комисс ерөөсөө хариулахгүй бултаж зугтаагаад байна л даа. Тэрэнд л би бас гайхаад байгаа юм.

Учир юу вэ гэхлээр би ч өөрөө бас төсвийн ерөнхийлөн захирагч хийж байсан. Монгол Улсын хэмжээнд тендерийн будилаантай асуудлуудын маргаан бол Сангийн яаман дээр очдог. Тэгээд Сангийн яамны гаргасан шийдвэр бол үндсэндээ эцсийнх болоод явдаг. Тэгэхлээр Сангийн яамнаас хоёр ч удаа энэ гомдол нь үндэслэлтэй байна, энэ асуудлууд нь цэгцлээд, дахин зарлаа л гэсэн байна. Тэгэхээс тэрийг нь, энийг нь шалгаруул гээгүй байгаа юм.

Тэгэхлээр би ч гэсэн юу гэж хэлж байна вэ гэхлээр хугацаа алдаж байгаад нь л санаа зовоод байгаа юм. Тэгээд тэр хугацаанд нь Сангийн яам хоёр удаа асуудлыг шийдэгдчихсэн, хүчингүй болгоод зарлачихсан бол өнөөдөр ямар ч болтугай нэг боловч болтугай, хоёр боловч болтугай алчихсан байх ёстой юм биш байгаа гэсэн энэ талаас нь л асуугаад байгаа юм.

Тэгэхээс ер нь янз бүрийн байдлаар зарим зүйлийг хар сэрийн байдлаар ингэж асууж, хариулж энэ тэр болохгүй байх гэж ингэж бодож байгаа юм. Ер нь сая манай Пүрэвдорж гишүүн ч л хэлж байна, Цогтгэрэл гишүүн ч л хэлж байна. Эрчим хүчний асуудал бол үнэндээ хэлэхэд номер нэг асуудал. Бүх салбараас өмнөх асуудлууд. Тэгээд одоо

ингээд гарч байгаа дүнгээ энэ тэр сонсоод үзэхлээр жилд 130 сая доллар гэж байгаа юм.

Тэгэхлээр 10 жилд гэхлээр чинь хэд юм? Тэр мөнгө 300 сая доллар аль урсаад алга болчихсон байна. Энэ зарлах явцадаа энэ барих цахилгаан станцынхаа эх үүсвэрийг зарах гэрээгээ хийгээгүй байдаг. Тэгээд ийм түүхий нөхцөл байдлуудыг аль нэгийг нь хамгаалаад ингээд удаашруулаад байгаа нь өөрөө Монгол Улсын эрх ашгийг, иргэн бүрийн олох эрх ашгийг улам л ахиад хойш нь тавиад байгаа юм биш байгаа. Нөгөө л бусадтай адилхан Эгийн голын усан цахилгаан станц, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Багануурын усан цахилгаан станц, Бөөрөлжүүтийн усан цахилгаан ч гэсэн энэ үлгэр домгийн араас л ахиад л ийм олон жил суллуулсан үлгэр домог бий болоод байна.

Тэгэхлээр энийг таслан зогсоогоод, хурдан түргэн явах боломж нь бол үндсэндээ Эрчим хүчний яамны Үнэлгээний хороон дээр байсан байгаа байхгүй юу. Энэ та бүхний надад өгсөн, би хаанаас ч өөр газраас бичиг аваагүй. Ерөнхий сайдад асуулга тавиад ингээд та бүхнийг маш нарийн ингээд үзээд байхад энэнийхээ асуудлыг шийдээд, дахин зарлаа гээд эрх бүхий төрийн байгууллагууд нь хэлээд байхад үгүй ээ энийг цааш нь явуулъя, энэ Камбож компанийг 18 онд байгуулагдсан Камбож компанийг шалгаруулъя гэсэн хандлага харагдаад байгаа нь энэ ногоон автобус шиг юм болчих юм биш байгаа гэж бодоод байгаа байхгүй юу.

Ногоон автобус чинь яг энэ одоогийн өндөрлөгөөс харахад бол Үнэлгээний хороон дээрээ ийм л асуудлууд болсон юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ утсыг хөвөөд байнгуут очоод Хюндай гэдэг тэр том брэндийг хөөсөөр явж байгаад нэг Вьетнамын засварын газар дээр л очсон юм шүү дээ. Энэ шиг Монголын хойч ирээдүйг хангах хэмжээний ийм том эрчим хүчний эх

үүсвэр утас нь хөөгдсөөр явж байгаад дахиад Камбожийн компани гээд ахиад 10 жилээр хойшлох эцэс төгсгөлгүй маргаан болчих энэ асуудлыг Эрчим хүчний яам таслан зогсоогоод, ингээд дараагийн дэлхий нийт нээлттэй болчихсон байна, олон улсын зөндөө мөнгөтэй байна. Тэр ганцхан Си Жиньпиний хэлсэн үгийн дагуу Монголын нэг ийм том төсөл зогсож болохгүй шүү дээ. Тэр хэлэхдээ төрийн байгууллагууд л тэгсэн. Өнөөдөр Монголоос өөр төрийн оролцоотой газрууд бол ховорхон байгаа шүү дээ. Хувийн хэдэн тэрбум доллароороо, хэдэн сая доллароороо хөрөнгө оруулаад хамтын ашигтай асуудлууд байх боломжтой юм гэж ингэж харж байгаа юм.

Тэгэхлээр одоо би туршилагатай Чойжилсүрэн сайдыг бас та энэ эрх мэдэл байгаа дээрээ Монголын нэг боловч энэ том төслийг хурдан, түргэн хугацаанд шинээр зарлаж өгөөд бас эхлүүлчихвэл та бидний энэ парламентад хамтарч суусны, таны бас Эрчим хүчний сайд хийсний бас гавьяа болох болов уу. Монголын ард түмэнд ингэж тус болох юм сан гэсэн л энэ агуулгаар ханд.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Баярлалаа. Би бас мэдээлэл өгчихье. Энэ сая Пүрэвдорж гишүүн хэлсэн энэ жижиг оврын усан цахилгаан станцууд гээд одоо Бүгд Найрамдах Лаос Ард Улс гэхэд л бас л жижигхэн л улс шүү дээ тэгэхэд 54 усан цахилгаан станцтай гэж. Тэгээд манай дарга нар очоод л үзээд байдаг юм байна лээ энэ станцуудыг нь. Бас бариад байж болдоггүй юм уу?

Хоёрт, энэ Салхитын салхин станц гэж байгаа шүү дээ? Манайд байгаа гадаадын хөрөнгө оруулалттай 50 мвт-ын. Энэ байгууллага гэхэд л байгуулахын тулд 264 гарын үсэг авсан гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулагч нарыг хамгийн их туйлдуулж байгаа юм чинь ерөөсөө л энэ хүнд суртал. Тийм учраас

сайд энэ хүнд суртлыг халах талаар нэлээн ажиллахгүй бол 264 гарын үсгийг авсан. Тэгэхээр энэ бол үнэхээр бас байж болигүй л зүйл. Та энэ дээрээ сайн анхаарч ажиллаарай.

Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсууриас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан тавьсан асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Өмнөх юу руугаа орно. Урагшилуулаадахъя. Дөрөв дэх тээ? Энэ чинь хэн орох билээ? Дараагийн асуудал.

14.07 цаг.

**Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Мөнх-Оргил:** Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахлан гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Баатарбилиг, Батсуурь, Бямбацогт, Сандаг-Очир, Энхбаяр нар ажиллаж хуулийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай 36 зүйлтэй хуулийг

1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр баталж, өнгөрсөн хугацаанд 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын эрх зүйн тогтолцоо нь тулгуур хуулиуд болох эрүү, иргэн, захиргааны эрх зүйн шинэчлэлийг нийгмийн харилцааны хөгжил, олон улсын сайн туршлага, хууль хэрэгжүүлэх явцад гарсан алдаа, дутагдалд үндэслэн хийж ирсэн хэдий ч Үндсэн хуулийн цэцийн хяналтын асуудлаар эрх зүйн шинэчлэлийг хийж чадалгүй өнөөдрийг хүрсэн.

Үндсэн хуулийн хяналтын гол зорилго бол төрийн байгууллагын дур зоргын шийдвэрээс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн бүхий л шатад хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оришиж байдаг бөгөөд дэлхий дахинд Үндсэн хуультай ёсны төлөвшилд Үндсэн хуулийн хяналтын байгууллагын үүрэг оролцоо нэн тэргүүнд тавигдахаас гадна Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаа иргэд, олон нийтийн зүгээс авч байгаа үнэлэлтээр хэмжигдэж байна.

Эрх зүйн шинэчлэлийг хийхгүй удах нь иргэд, олон нийтийн шүүмжлэлийг дагуулж, бухимдлыг төрүүлэхийн сацуу тухайн институтийн нэр хүнд үйл үйл ажиллагаанд нөлөөлөх, улс төржүүлэх, Үндсэн хуулийн үзэл баримтлалыг гажуудуулах сөрөг үр дагаврыг гаргаж болзошгүй байна.

Сүүлийн үед Үндсэн хуулийн цэц улс төрөөс хараат болсон, захиалга биелүүлдэг болсон гэх мэт шүүмжлэл гаргах болсон нь эрх зүйн шинэчлэлийг хийгээгүйтэй, Цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааг нарийн тодорхой зохицуулаагүйтэй холбоотой байж болно.

Тодруулбал, иргэн, эрх бүхий байгууллага, албан тушаалтан Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл өгөх, хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэж байгаа үйл ажиллагааг нарийвчлан

зохицуулаагүйтэй холбоотой маргааныг шийдвэрлэхгүй удаашируулах, маргаан үүсгээд мартаж, Цэцийн шийдвэрийн үндэслэл дутмаг байх зэрэг олон сөрөг үр дагавар гарсаар байна.

Ажлын хэсэг 30 гаруй жилийн алдаа оноог дүгнэн цэгнэж, дэлхий дахинаа төлөвшин хөгжиж буй Үндсэн хуультай ёс, Үндсэн хуулийн шүүхийн өсөн нэмэгдэж буй үүрэг, хүний эрхийг тодорхой тохиолдолд хамгаалах хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өнгөрсөн 3 жилийн хугацаанд тасралтгүй ажиллан хуулийн төслийг боловсрууллаа.

Ажлын хэсэг Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын Тамгын газар, эрдэмтэн, судлаачдыг оролцуулан ажлын дэд хэсгийг байгуулан мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа авч ажиллалаа.

Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил нарын 2024 оны 3 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн



байнгын хороо 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх тухай хууль 1997 онд батлагдсан бөгөөд хэт ерөнхий, агуулгын хувьд Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуультай давхардсан зохицуулалт агуулсан, маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиар зайлигүй зохицуулах зарим харилцааг зохицуулаагүйгээс Цэцийн дүгнэлт, шийдвэрт нөлөөлж байгааг өөрчлөх, Цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны дэгийг хуулийн төсөл боловсруулахдаа нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн байна.

Хууль санаачлагч хуулийн төслийг боловсруулахдаа иргэн эрхээ хамгаалах хуульд заасан зарим арга замыг дуусгасны дараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага албан тушаалтны гаргасан шийдвэр, бусад акт өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөн хэвээр байна гэж үзвэл Цэцэд өргөдөл гаргах, иргэд эрх бүхий этгээдээс Цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт, тавигдах шаардлага, хүлээн авахаас татгалзах үндэслэл, маргааныг хянан шийдвэрлэх үндэслэл журмыг тодорхой болгох, Цэцэд маргаан үүсгэснээс хойш 90 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд тухайн маргаан ээдрээ төвөгтэйд төвөгтэй бол энэ хугацааг 90 хоногоор 2 хүртэл удаа сунгаж болохоор, Цэц түүний гишүүн гишүүний хараат бус байдал, Цэцийн процессын шударга байдлыг нэмэгдүүлэх, Цэцийн гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлийг энэ онолын түвшинд ойлгомжтой, үндэслэл сайтай гаргах шаардлагын үүднээс зөвлөлдөөнд дууссанаас хойш 45 хоногийн дотор Цэцийн шийдвэрийг эцэслэн бичиж ёсчлох, улмаар тодорхой хугацаанд нийтэд мэдээлэх, нийтлэх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон бусад материаллаг зардал жилд ойролцоогоор 304167117 төгрөгийн зарцуулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд хуулийн төслийг *d.parliament.mn* цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг төсөлд үндсэн эрхэд хамаарах зарим эрхүүд орхигдсон шалтгааны талаар, Цэцийн шийдвэрийн үндэслэл тодорхой, онолын үндэстэй, ойлгомжтой байх талаар ямар онцлог зохицуулалт туссан талаар, Цэц хүний үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэдэг болсноор ажлын ачаалал нь хэрхэн нэмэгдэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Цэц хүний үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэдэг болсноор шүүхийн үйл ажиллагаатай хэрхэн уялдах, үүсэх үр дагаврын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх тухай журмын тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**С.Одонтуяа:** Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байвал нэрээ авъя. Гишүүд байна уу?

*Тогтохсүрэн даргаар тасаллаа. Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.*

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ Үндсэн хуулийн цэц хүний үндсэн эрхийн маргааныг хэлэлцэн шийдвэрлэдэг болж байгаа энэ зохицуулалт бол үнэхээр маш том дэвшил байгаа. Өнгөрсөн Үндсэн хууль батлагдсанаас хойших 30 жилийн хугацаан дахь яг хуулиар буюу Үндсэн хуулиар хамгаалагдаагүй томоохон заалт бол энэ хүний үндсэн эрхийн маргаанууд байж ирсэн. Хэдийгээр бид нар хүний эрхийг дэмжих чиглэлээр нэлээд олон хуулиуд баталж, Гэрч, хохирогчийг хамгаалах, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль гээд баталсан боловч яг тодорхой амьдралд тодорхой нөхцөлд маш их зөрчилтэй байна.

Тухайлбал, миний хувьд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн ажлын хэсгийг ахлан ажиллаж байна. Маш олон иргэд хүний эрхийн төлөө, эсвэл уул уурхайн асуудлаар, байгалийн баялгийн төлөө гэдэг юм уу жагсаал, цуглаан хийж тэмцэж байгаа

их олон иргэд бол хүний эрх нь зөрчигдсөн, тэгээд энэ талаар шүүх, цагдаа дээр, прокурор дээр гомдол гаргаад явсан ч гэсэн шийдэгдэхгүй асар их удаж байгаа тухай мэдээлэл, гомдол ирүүлж байна. Дөнгөж өнөөдөр бид нар энэ Байгалийн баялаг иргэдийн хяналт ТББ, мөн Бүх ард түмний их хурал ТББ, Зөв найзууд гээд ТББ-ын төлөөллүүдтэй уулзлаа. Ерөөсөө анхан шатдаа буюу яг тухайн хүний эрхийн асуудал дээр цагдаагийн байгууллага, цагдаагийн албан хаагч нар ихээхэн дарамт учруулдаг, хянан шалгадаг. Дээр нь бас тодорхой асуудлаар жагсаал, цуглаан хийх эрхийн тухайд бол асар их зөрчил байгааг уламжилж байна.

Ер нь Хууль зүйн яам Жагсаал, цуглаан хийх тухай журмын тухай хуулийг шинэчлэн найруулж, өргөн барина гэж бид нар хүлээж байна. Энийг бас яаралтай өргөн барихаар байна.

Тэгэхээр яг энэ хүний эрхийг зөрчөөд байгаа энэ асуудлаар Монгол Улсын шүүх, цагдаа, ялангуяа прокурорын байгууллагын хувьд зөрчил, гомдлууд их ирээд байгаа учраас Үндсэн хуулийн цэц энийг авч хэлэлцэх нь үнэхээр том дэвшил. Тэгэхээр энэ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн шүүх бол ер нь Европын холбооны улсуудын Үндсэн хуулийн шүүхийн бараг 80-95 хувь Цэц цэвэр хүний эрхийн гомдлууд байдаг. Гомдол, маргаан байдаг.

Тэгэхээр энэ чиглэлд манай Үндсэн хуулийн цэцийн гишүүдээ яаж бэлдэх вэ? Анхнаас нь тэр томилгоо дээр нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэдэг дотор яг хүний эрхээр мэргэшсэн гэдэг энэ тусгайлсан шалгуур ер нь баймаар санагдаад байна.

Жишээлбэл, энэ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын үндсэн хуулийн шүүх их маргаантай олон асуудлаар яг хүний эрхийн зөрчөөгүй тухайд үндсэн хуулийн дүгнэлтүүдийг гаргаж байсан

юм байна лээ. Тэгэхээр манай одоо энэ Үндсэн хуулийн цэцийн өнөөгийн бүрэлдэхүүн гэдэг юм уу, энэ чиглэлээр мэдрэмжтэй ажиллаж чадах уу, үгүй юү?

Жишээлбэл, Холбооны Германы Улсын нэг сонин шүүхийн кэйс байгаа. Нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тухайн нийтийн сургуульд сургах боломжгүй. Энэ хүүхдийг тусгайлсан тусгай сургуульд сурах ёстой гэдэг ийм мужийн шүүхийн шийдвэр гарсан. Үүнийг бол давж заалдаад Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзсэн байгаа юм.

Өөрөөр хэлбэл, тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурган бэлтгэх нөөц болон боловсон хүчин гээд энэ боломж нийтийн сургууль байхгүй учраас тусгайлсан сургуульд явах нь зөв гэж үзсэн. Энэ дээр тухайн үедээ маш их маргаанууд гарч байсан юм байна лээ.

Ер нь иймэрхүү хүний эрхийн чиглэлийн асуудлаар яг дээр тодорхойлон мэдрэмжтэй ажиллах, энэ боловсон хүчнийг бэлдэх, Үндсэн хуулийн цэц маань энэ дээр илүү мэдрэмжтэй ажиллах шаардлага байна. Тэгэхээр энэ тал дээр хэрхэн бэлдэх вэ?

Хоёрдугаарт нь тэр манай яг Монгол Улсад гарч байгаа Жагсаал, цуглааны тухай хуулиуд, иргэний эрхийн төлөө гэдэг юм уу, улс төрийн төлөөх тэмцэл, хөдөлгөөний үед хүний эрхийн эрх зөрчигдөж байна. Үүнийг манай цагдаа, шүүхийн байгууллага шат шатдаа маш анхаардаггүй гэдэг юм уу, хүний эрхийн мэдрэмжгүй хандсан гомдлууд Хүний эрхийн дэд хороонд их ирж байна. Энэ талтай холбогдуулаад хүний эрхийн асуудлаар Үндсэн хуулийн цэцийг сайн мэргэшүүлэх ёстой энэ тал дээр ямар ажлууд хийгдэх вэ гэдгийг асуумаар байна.

**С.Одонтуяа:** Хууль санаачлагч Цэндийн Мөнх-Оргил хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Цэц үндсэн эрхийн маргаан шийдвэрлэдэг болох саналыг оруулж ирж байгаа юм л даа. Тэгэхдээ энэ Цэц ерөөсөө хүний эрхийн асуудал хэлэлцэхгүй өдий хүрчихсэн гэсэн үг бас биш л дээ. Цэц бол хүний эрхийн асуудлыг ярьж байгаа, Үндсэн хуультай нийцэж байна уу, үгүй юү гэж хууль тогтоомж, зарлигийг хянаж байгаа, шүүхийн байгууллагууд чинь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж шүүхийн шийдвэр гаргаж байна гэдэг чинь шууд болон цаад утгаараа хүний эрхийг хамгаалж л байгаа юм л даа.

Гэхдээ гагцхүү бидний энэ оруулж ирж байгаа үндсэн эрхийн маргааныг Цэцээр хэлэлцүүлнэ гэдгийн зарчмын бөгөөд ач холбогдолтой гол ялгаа нь Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг Үндсэн хуулийн шүүх нь өөрөө хамгаалах энэ шинэ тогтолцоо л орж ирж байгаа юм.

Тэгэхдээ би түрүүн өмнөх хууль дээр ярьж байсан. Энэ нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоцхож байгаа юм биш, Үндсэн хуулийн 50.1.3-д заасан Үндсэн хуулийн цэц Улсын дээд шүүхэд хүний эрхийг хамгаалахтай холбоотой асуудлаар асуудал оруулж, шийдүүлж болно гэдэг тэр заалтыг л амилуулж байгаа хэрэг байгаа юм.

Яаж бэлдэх вэ гэдэг асуудал байна. Миний бодлоор манай Улсын Их Хурал өөр дээрээ л ачаалал авах ёстой асуудал. Яагаад гэвэл бид нар томилж байгаа байхгүй юу. Таны сая ярьж байгаа шаардлагад хангаагүй хүнийг, мэргэжилтнийг Ерөнхийлөгч юм уу, Дээд шүүх юм уу, Улсын Их Хурал өөрөө оруулаад ирвэл бид нар л энд хамгаалалт тогтоохгүй бол энэ хуульд бид нар хэчнээн ч янз бүрийн босго, шаардлага тавиад бид нар өөрсдөө Их Хурал өөрөө тэр шүүлтүүрийг л тавьж, улс төрийн

зориг гаргаж уучлаарай энэ хүн чинь шаардлага хангахгүй байна гэж зохицуулж л байхгүй бол асуудал явахгүй л дээ.

Өөрөөр хэлбэл, бид нар өөрсдөөсөө л эхлэх ёстой гэж би санаа хэлэх гээд байгаа юм. Энэ асуудал хэлэлцдэг болсноор би бас их айж гэх юм уу, санаа зовж байгаа зүйл их байгаа. Цэцийн ажил асар их ачаалал дарагдана. Хэдэн жилийн доороос нь гарахгүй олон том өргөдөл ирнэ. Иргэд яг ямар асуудлаараа би өргөдлөө өгөх ёстой, юм ямар асуудлаар гомдол гаргах ёстой юм гэдгээ ойлгож, өмгөөлөгч нар нь нь ойлгож зөвлөх гэж, энийг жигдрэх гэсээр байтал нэлээн хэдэн жил болно.

Гэхдээ жигдэрсний дараа бол энэ өөрөө их чухал ач холбогдолтой учраас эрсдэлтэй ч гэсэн энэ алхмыг хийгээд ингээд урагшлуулаад явах нь зүйтэй гэж бодож байгаа юм. Жигдэртлээ нэлээн цаг хугацаа болно. Учраа олохгүй. Энэ зөвхөн манайд ч биш, ер нь хаа хаанаа л энэ асуудлыг ингээд нөгөө үндсэн эрхийн маргаан Үндсэн хуулийн цэц дээр хэлэлцдэг болоод эхлэхлээр бүх улс орнуудад ийм проблем үүсдэг юм байна лээ.

Тэр жагсаал цуглааны хувьд ийм байгаа юм. Энэ үндсэн эрхийн маргааныг Цэцээр хэлэлцдэг боллоо гээд энэ Үндсэн хуульд заачихсан бүх эрхийг хүн болгонд тэгш, абсолют хэрэгжүүлнэ гэсэн үг бас биш шүү дээ тийм ээ. Одоо би жагсаал, цуглаан хийнэ гээд шөнө.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн дуустал хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ абсолют эрхийг хангах тухай асуудал бас биш шүү дээ тийм ээ. Би жагсаал, цуглаан хийх эрхтэй гээд л шөнийн 12 цагт олон мянган хүний унтаж амарч байгаа үед нь жагсаал цуглаан хийгээд л хүмүүсийн амгалан тайван амьдрах эрхэд нөлөөлөх юм бол тэр эрхийг

хязгаарлахаас өөр аргагүй байдалд л орно шүү дээ.

Өөрөөр хэлбэл, энэ Үндсэн хуульд заасан энэ олон эрхүүдийн тэнцвэржүүлэх асуудал, балансын онол гэж ярьдаг шүү дээ тэрүүгээр байна. Тэрнээс биш юу гэдэг юм энэ хууль ингээд л батлагдаад л Цэц үндсэн эрхийн маргааныг хэлэлцдэг болоод л, хүн болгоны үндсэн эрх ингээд л ерөөсөө 100 хувь хэрэгжээд л, бусдын эрх ашиг хамаагүй болоод л явчих тухай асуудал биш л дээ.

Тэгээд энэ дээр манай Цэцийн гишүүдийн одоогийн бүрэлдэхүүн онолын болон практикийн өндөр мэдлэгтэй хуульчид байгаа гэдэгт би итгэлтэй байгаа. Тэгэхдээ сурах, боловсрох, энийгээ зөв хэрэглэхэд нэлээн цаг хугацаа орно. Энэ дээр бид нар нэлээн ажил зохион байгуулна гэж бодож байгаа. Цэцэд тусалдаг бүтэц, бүрэлдэхүүнийг нэмнэ, тодорхой хэмжээгээр орон тоо, цалин нэмэгдэнэ. Хамгийн гол нь Цэц өөрийнхөө ажил, үйлчилгээнд энэ процессоо нарийвчилж, гаргаж өгөх л асуудал чухал байгаа юм. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Одоо Тогтохсүрэн гишүүн асуултаа асууна.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Үндсэн хуулийн цэцийн маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль бас нэлээн бас боловсронгуй болж орж ирж байна. Бид ч бас олон удаа ярьдаг энэ маргаан хянан шийдвэрлэх хуулийг заавал нэлээн тодорхой болгож ярих ёстой гэдэгтэй санал нэг явдаг юм.

Үндсэн хуулийн цэц өмнө нь бол хууль, Улсын Их Хурлын шийдвэр, албан тушаалтны тодорхой шийдвэрүүдийг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан шийддэг байсан. Одоо энэ Маргаан хянан шийдвэрлэх хуулиар хоёр дахь том асуудал орж ирж байна. Энэ нь бол энэ иргэдийн үндсэн эрхийн маргааныг хянан

шийдвэрлэхтэй холбоотой асуудал болж байгаа юм.

Хүний эрхийн үндсэн маргааны үндсэн эрхтэй холбоотой асуудал яахын аргагүй өнөөдөр нийгэмд их өндрөөр тавигдаж байгаа. Энийг Үндсэн хуулийн цэцэд харьяалуулж байгаа асуудал бол нэг талаасаа аягүй том дэвшилд гарч байгаа зүйл мөн.

Нөгөө талаасаа жаахан маргаантай асуудал гараад байгаа юм. Би энийг нь л асуух гээд байгаа юм. Учир нь юунд байна вэ гэхээр манай хууль нь ингээд биччихсэн байна. Хуульд заасан арга буюу шүүхийн процессыг дуусгасны дараа үндсэн эрх нь зөрчигдсөн нь хэвээрээ гэж бол Үндсэн хууль цэцэд хандана гэж.

Тэгээд энэ юу гэсэн үг вэ гэхээр шүүхийн шийдвэрийн дараа хандана л гэсэн ийм л ойлголт байгаа юм. Тэгэхлээр Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дээр Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна гэгчихсэн. Тийм, энэнтэй одоо яаж зөрчилдөх вэ гэдэг асуудал байгаа юм. Тийм, энэнтэй зөрчилдөх асуудал бол гол, нэг.

Хоёрдугаарт нь ингээд хүний эрх зөрчлөө гэж үзье, зөрчигдсөн байна гэж Цэц үзэхээр шүүх дахиж авч хэлэлцэх үү гэдэг асуудал гарна. Тийм учраас бол энэ дээр нарийн процессын асуудлууд цаашаа ингээд үргэлжлэх юм. Тэгээд энэтэй холбогдуулаад хоёр дахь асуух гэж байгаа юм нь энэ Цэцийн ачаалал нэмэгдэж байгаа, энэтэй холбогдуулаад ер нь хэр олон хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байгаа вэ? Энэ бодвол энэ хүний эрхийн хуулиас эхлээд их олон хуульд өөрчлөлт орох болов уу гэж би бодож байгаа юм.

Хоёр дахь асуудал юу байна вэ гэхээр нөгөө бид өнгөрсөн жил ч яригдаад байсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хянах уу, үгүй юү гэдэг асуудал байдаг. Өмнө нь

бол Үндсэн хуулийн өөрчлөлтүүдийг хянаж ирсэн. Тийм. Тэгэхээр одоо энэ маргаан хянан шийдвэрлэх хууль дээр Үндсэн хуулийн өөрчлөлтийг хянах, тэр дотроо хэрхэн яаж хянаж авч үзэх вэ гэдэг процессыг нарийвчлалд нь тусгасан уу, үгүй юү гэдэг асуудал байгаа юм.

Гурав дахь асуудал бол маргаан хянан шийдвэрлэх хугацаануудыг тодорхой болгох шаардлагатай байгаад байгаа юм хуульд. Бага суудлын хуралдаан, их суудлын хуралдаан, маргаан үүсгэх, дунд суудлын хуралдаан эд нар гээд энэний процессын асуудлуудыг нарийн энэ хуулиар хугацааны асуудлуудыг нь нарийн авч үзэж чадсан уу гэдэг ийм 3 зүйлийг хууль санаачлагч тодруулъя. Баярлалаа.

Хууль санаачлагч Мөнх-Оргил гишүүн хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт энэ Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна гээд заалттай л даа. Тэгээд энэтэй зөрчилдөж байна уу гэж асууж байгаа юм. Тэгээд энэ дээр зөрчилдөхгүй байгаа юм Тогтохсүрэн дарга.

Яагаад гэвэл яг дараагийн өгүүлбэр нь хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно гээд гарц нь байгаа байхгүй юу.

Дээд шүүхэд хэн асуудал тавих юм бэ гэдгийг нь 50 дугаар зүйлийн 1.3 дээрээ Үндсэн хуульдаа заагаад өгчихсөн юм. Хууль түүнд заасан энэ Дээд шүүхийн бүрэн эрхийн асуудал. Хууль түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц Улсын ерөнхий прокурор руу шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэнэ гээд.

Тэгэхээр Цэц зөвхөн хүний эрхийг хамгаалах асуудлаар, өөр асуудал байхгүй. Зөвхөн хүний эрхийг хамгаалах

асуудлаар Дээд шүүхэд хандана. 50.2-оороо Дээд шүүх нь өөрийнхөө шийдвэрийг хуультай харшилж байна гэж үзвэл өөрөө засаж болно. Энэ л.

Тэгэхээр шүүхийн шийдвэрийг Цэц бол үгүй хийхгүй, хүчингүй болгохгүй, асуудлаа цэгцэлье гэж оруулж байгаа юм. Үүнийг Дээд шүүхийн нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцээд, энэ бол зөв юм байна гэдгийг хүлээн зөвшөөрөөд, шүүхийн хууль, эрүү, иргэн, захиргааны процессуудад нэмэлт орсон. Одоо энийг бид нар хамт өргөн барьчихсан байгаа. Шүүхийн хуульд жишээ нь, ямар нэмэлт орсон бэ гэхлээр Цэц шүүхийн шийдвэрийн үйлчлэлийг түдгэлзүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3-д заасны дагуу үндсэн эрхийг хамгаалах асуудлыг шилжүүлсэн тохиолдолд уг шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж, тухайн асуудлыг Цэцийн дүгнэлтийн дагуу үндсэн эрхэд нийцүүлэн хянан шийдвэрлэх, өөрийнхөө юмыг хянан шийдвэрлэхчлэн, эсвэл давж заалдах шатын шүүхийн шийдвэр байх юм бол холбогдох шүүхэд шилжүүлнэ.

Өөрөөр хэлбэл, Цэцийн шийдвэрийг хүндэтгэж үзээд, Цэцийн гарсан шийдвэрийг үндэслээд шийдвэрээ эргэж хараад шийдвэрлэ гээд Дээд шүүх шийдвэр гаргана гэсэн үг. Тэгэхлээр энэ бол Үндсэн хуулийн заалттай яг цав нийцэж байгаа юм.

Энэ бусад оронд Цэцийн шүүхийн шийдвэр нь Дээд шүүхийнхээ шийдвэрийг шууд хүчингүй болгочихдог юм байна лээ. Солонгос ч гэсэн тэгж байгаа. Герман ч гэсэн тэгж байгаа, Австри ч гэсэн тэгж байгаа. Манайд бол тийм бололцоо байхгүй.

Яагаад гэвэл 50.2-оороо шүүхийн шийдвэр эцсийнх байх учраас тэр бололцоог нь шүүхэд нь олгож байгаа юм. Энийг ч гэсэн манай Үндсэн хууль тогтоогчид хараад, мэдээд 51.3 дээрээ

зөвхөн Цэц, прокурор хоёрт зөвхөн хүний эрхийг хамгаалах асуудлаар асуудал оруулж болно гэсэн заалт оруулсан байгаа юм.

Тэр хугацааг тодорхой болгосон. Сая танилцуулга дээр бид нар буруу бичээд оруулчихсан байна. 90 хоног. 90 хоногийг 1 л удаа сунгана. Өмнөх төсөл дээр 2 удаа сунгана гэж ярьсан юм. Тэгээд хэлэлцүүлгийн явцад санал гараад 1 удаа сунгахаар орсон байгаа. Тэгээд дунд суудал, бага суудал, их суудлынх бүгд хугацаанууд нь нарийвчлаад тодорхой орчихсон байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар энэ хуульд тусгаагүй. Яагаад гэвэл энэ асуудал өөрөө.../минут дуусав./

**С.Одонтуяа:** Мөнх-Оргил гишүүн нэмж хариулъя.

**Ц.Мөнх-Оргил:** Тэр асуудлыг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх талаар Цэц дүгнэлт гаргах уу, үгүй юү гэдэг асуудлыг бид нар энэ хуульд тусгаагүй. Хоёр шалтгаанаар.

Нэгд, хууль санаачлагч бидний хувьд бол бидний хувь Улсын Их Хурлын гишүүний нүдээр харахад энэ асуудалд Үндсэн хуульд маш тодорхой хариулт өгчихсөн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн адил хүчин төгөлдөр үйлчилнэ гээд.

Тэгэхлээр нэгэнт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн бусад заалтуудтай адил үйлчилчхээж байгаа бол Цэц бол нэмэлт, өөрчлөлт дээр дүгнэлт гаргаж болохгүй.

Харин хэлбэрийн хяналтыг тавьж болно. Тэр бол хэвээрээ байгаа. Энэ дээр бид нар санал нэг байгаа.

Хоёр дахь шалтгаан нь энэ асуудлаар Цэц дээр маргаан үүсээд, энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай

одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад нэмэлт, өөрчлөлт орчихсон. Тэрүүгээр бол нэмэлт, өөрчлөлтийг хянахгүй шүү гээд заачихсан шүү дээ. Тэгээд тэн дээр маргаантай байгаа асуудал учраас энийг тусгаагүй.

Шаардлагатай гэж үзвэл хуулийн хэлэлцүүлгийн явцад энэ заалтыг тодруулж оруулж болно. Өөрөө энэ их тийм маргаантай, зовлонтой асуудал. Манай Монголын онцлог, манай Монголын Үндсэн хуулийн заалт бол их тодорхой байна гэж бид нар харж байгаа. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж дууслаа. Санал хураалт.

Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл горимын санал гаргая гэж байна.

**О.Цогтгэрэл:** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль хэлэлцэгдэж байна. Ер нь аливаа хуулийг дагасан нь энэ процессын хууль, үйл явцын хуулийг ингэж оруулж ирж энэ дээр тодорхой ажиллах нь маш тийм хэрэгтэй.

Яагаад гэхээр процессын хуулийг тодорхой болгоогүйгээс болоод энэ тухайн байгууллагын дарга, удирдлага үзэмжээрээ асуудлыг шийдэх ийм нөхцөл байдлууд үүсдэг. Манай Монголын ихэнх хуулиуд дээр. Тэр тусмаа процессын хуулиудыг, процессын зүйл, заалтуудыг тодорхой болгоогүйгээс болоод Засгийн газар дээр, бусад хууль тогтоох эрхгүй байгууллагууд дээр журам, дүрэм гаргадаг.

Журам гэж дахиад хуулиас давсан эрхүүдийг авдаг. Энэ нь өөрөө дахиад Улсын Их Хурлын хууль тогтоох эрхэд халдах, энийг дагаж хүнд суртал, авлигын олон асуудлууд үүсэх асуудлууд энэ процессын хуулийг боловсронгуй болгоогүйгээс болж олон олон асуудлууд ингээд гардаг.

Тэгэхээр энэ Цэцийн хуулийг үндсэндээ дагасан энэ процессын хууль орж ирж байгаа нь бас их зөв зүйтэй. Гэхдээ үдээс өмнөх хуралдаан дээр Ардчилсан намын бүлгийн зүгээс Үндсэн хуулийн процессын биш, Үндсэн хуулийн цэцийн тухай буюу гол хууль дээр нь 5 хоногийн завсарлага авсан.

Тэгэхээр энэ ирэх 5 хоногийн хугацаанд бас хууль санаачлагчид бол олон хүмүүстэй бас энэ хүрээнд бас тодотгож ярилцах зүйлүүд байгаа. Тийм болохоор яг Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг дагалдуулж орж ирж байгаа Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль дээр бас адилхан 5 хоногийн завсарлага өгөхийг хүсье.

**С.Одонтуяа:** Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн саналын дагуу ажлын 5 хоногийн завсарлага өгч байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

15.35 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

